




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ,
ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР, АМГТГ-ЫН
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,
2017-2020 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ, ХҮРЭХ ҮР ДҮН



2017 он





ЭРХЛЭН ГАРСАН:
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын 12-р байрны баруун жигүүр
211238. Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976-51-263678
Факс: 976-51-26310370
Вэб: www.mrpm.gov.mn
И-мэйл: info@mrpm.gov.mn

Эмхэтгэсэн: Т.Баасанпүрэв
Ашигт малтмал, газрын тосны
газрын Уул уурхайн үйлдвэрлэл,
технологийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн



Ашигт малтмал, газрын тосны газрын захиалгаар
The Mongolian Mining Journal сэтгүүл гүйцэтгэв.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМЕР	Австрали-Монголын эрдэс баялгийн хамтын ажиллагааны хөтөлбөр
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АҮНБ	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТТХ	Газрын тосны тухай хууль
ГЗЕЭА	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил
ГШХО	Гадаадын шүүд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ЗГҮХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
УГЗ	Улсын геологийн зураглал
УИХ	Монгол Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УТХ	Улсын төсвийн хөрөнгө
ХАБЭА	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй
ХОТХ	Хөрөнгө оруулалтын тухай хууль
ЭБМТТ	Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГА Б.БААТАРЦОГТ

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газар, Газрын тосны газрыг нэгтгэж шийдвэрлэсний дагуу Ашигт малтмал, газрын тосны газар нь шинэ бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

Ашигт малтмал, газрын тосны газар нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагч, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Бид 2016 онд Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа түргэн шуурхай, хүнд сурталгүй, ил тод, нээлттэй болгохдоо мэдээллийн технологийн ололттой талуудыг ашиглаж, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хууль эрх зүйн хүрээнд чанарын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэхэд анхаарч ажиллалаа.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2016 оны үйл ажиллагааны тайланг танд танилцуулахын зэрэгцээ Төрөөс эрдэс баялаг, газрын тосны салбарт баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ирэх жилүүдэд хийж гүйцэтгэх гол ажлууд, зорилго, зорилтыг Та бүхэнд хүргэж байна.

Цаашид бид олон улсын сайн туршлагад үндэслэн байгалийн баялгийн нөөц болон ашигт малтмалын орлогыг удирдах, институциудын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах замаар хөрөнгө оруулалтыг татах чиглэлд онцгой анхаарч ажиллана.

Та бүхнийг манай газрын үйл ажиллагаа, ирэх жилүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилттой танилцаж хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

АГУУЛГА

I БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	8
1.1 Монгол Улсын талаарх ерөнхий мэдээлэл	8
1.2 Монгол Улсын эдийн засагт геологи, уул уурхай, газрын тосны салбарын эзлэх байр суурь	10
1.3 Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, гадаадын шууд хөрөнгө оруулалт	11
1.4 Ашигт малтмал, газрын тосны газрын бүтэц зохион байгуулалт, салбарын хууль эрх зүйн орчин	15
II БҮЛЭГ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	23
2.1 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	23
2.2 Ашигт малтмал, газрын тосны нөөц, хайгуул	26
2.2.1 Геологийн судалгааны ажлууд	26
2.2.2 Хувийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж нөөц тогтоосон байдал	31
2.2.3 Газрын тосны хайгуул	34
2.2.4 Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв	37
2.3 Уул уурхайн ашиглалт	39
2.3.1 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл	39
2.3.2 Уулын ажлын тайлан төлөвлөгөө	40
2.3.3 Түр зогсолттой байгаа үйлдвэр, уурхайн судалгаа	41
2.3.4 Ашиглалтад бэлтгэгдсэн үйлдвэр, уурхайн мэдээлэл	42
2.3.5 Уул уурхайн үйлдвэрлэлийн мэдээлэл	43
2.3.6 Уул уурхайн гаралтай экспортын голлох ашигт малтмалын бүтээгдэхүүн гаргалтын мэдээ	47
2.3.7 Уул уурхайн салбарын орон нутагт төлсөн татвар, төлбөр, нөхөн сэргээлт	48
2.3.8 Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт эзлэх байр суурь	49
2.3.9 Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт	50
2.4 Газрын тосны ашиглалт, олборлолт	51
2.4.1 Газрын тосны гэрээлэлт	51
2.4.2 Газрын тосны хайгуул, нөөц (ашиглалтын 3 талбайд)	52
2.4.3 Газрын тосны олборлолт, экспорт	53
2.4.4 Улс орон нутагт төлсөн татвар, төлбөр, шимтгэл, хураамж	54
2.4.5 Газрын тосны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт	55
2.5 Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, импорт	55
2.6 Хүнд үйлдвэр	58
2.6.1 Хүнд үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн орчин	58
2.6.2 Хүнд үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ	59
2.6.3 Газрын тос боловсруулах үйлдвэр	63
2.6.4 Нүүрс боловсруулах үйлдвэр	63
2.6.5 Хар төмөрлөгийн үйлдвэрлэл	64
2.6.6 Уул уурхай, металлургийн цогцолбор	66
2.6.7 Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл	67
2.7 АМГТГ-ын гадаад хамтын ажиллагаа, хамтарч ажиллаж байгаа төсөл хөтөлбөрүүд	68

III БҮЛЭГ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ 2017-2020 ОНД ХИЙГДЭХ ГОЛ АЖЛУУД, ХҮРЭХ ҮР ДҮН

73

3.1	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	73
3.2	Засгийн газрын Мөрийн хөтөлбөрт тусгагдсан томоохон ажлууд	73
3.3	Тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулах, бүртгэх чиглэлээр хийгдэх ажлууд	76
3.4	Ашигт малтмал, газрын тосны хайгуулын ажил, нөөцийн удирдлага	77
3.5	Ашигт малтмал, газрын тосны олборлолт, экспортын урьдчилсан төсөөлөл,	77
3.6	Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хийгдэх ажлууд	80
3.7	Салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, боловсруулах, хэрэглэгчдэд түгээх	82
3.8	Эрдэс бүтээгдэхүүн, газрын тосны үнийн урьдчилсан төсөөлөл	82
3.9	Геологи, уул уурхай, газрын тосны салбараас улс, орон нутагт төвлөрүүлэх татвар төлбөрүүдийн урьдчилсан төсөөлөл	84
3.10	Уул уурхай, газрын тосны салбарын орлогын менежмент	87
3.11	Уул уурхай, газрын тосны салбарын борлуулалт, эдийн засагт эзлэх байр суурь, ДНБ-ий төсөөлөл	92
3.12	Монгол Улсын геологи, уул уурхай, газрын тосны салбарын гадаад орчин, томоохон судалгааны байгууллагуудын индексийн урьдчилсан төсөөлөл	94



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

IV БҮЛЭГ. ХАВСРАЛТ

96

4.1	Ирээдүйтэй хайгуулын төслүүд	98
4.2	Олборлолт явуулж байгаа томоохон үйлдвэр, уурхай	111
4.3	2016 онд ашиглалтад хүлээн авсан үйлдвэр, уурхайн танилцуулга	132
4.4	Ашиглалтад бэлтгэгдсэн томоохон уурхай	133
4.5	Монгол Улсын геологи, уул уурхай, газрын тосны салбартай хамааралтай гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтууд	136
	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг	140
	Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй талбай	144

V БҮЛЭГ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ АЖИЛЛАДАГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

148

5.1	Төрийн байгууллагууд,	148
5.2	Төрийн бус байгууллагууд,	149
5.3	Эрдэм, шинжилгээний байгууллагууд,	149
5.4	Төсөл хөтөлбөрүүд	149
5.5	Мэргэжлийн холбоод	150
5.6	Мэргэжлийн сонин, сэтгүүл	151

ЗУРАГ

Зураг 1.	Монгол Улсын газар зүйн байршил	8
Зураг 2.	Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хувь, урьдчилсан төлөв	9
Зураг 3.	Уул уурхайн салбарын ДНБ, АҮНБ-д эзлэх хувь	10
Зураг 4.	Монгол Улсын хөрөнгө оруулалт татах чадварын индекс	11
Зураг 5.	Олон улсын байгалийн засаглалын индекс	12
Зураг 6.	Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт	13
Зураг 7.	Ашигт малтмал, газрын тосны газрын бүтэц зохион байгуулалт	15
Зураг 8.	Тусгай зөвшөөрлийн тархалтын зураг	23
Зураг 9.	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байдал	24
Зураг 10.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байдал	24
Зураг 11.	Тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлс	25
Зураг 12.	Цахимаар дугаар олгож хайгуулын тусгай зөвшөөрөл олгох диаграмм	25
Зураг 13.	Монгол Улсын геологийн судалгааны түвшин	26
Зураг 14.	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүд	27



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 15.	УГЗ-200 төслийн хэрэгжилт	27
Зураг 16.	УГЗ-200 зуураг, судалгаагаар бүрхэгдсэн (хамрагдсан) байдал	28
Зураг 17.	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааны зураг	28
Зураг 18.	Алтай-1, Алтай-2 төсөл	29
Зураг 19.	Хайгуулын ажлын жилийн тайлан ирүүлсэн байдал	30
Зураг 20.	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын ажилд зарцуулсан зардлын ажлын төрлөөр эзлэх хувь	31
Зураг 21.	Улсын нөөцийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн ордууд	31
Зураг 22.	Шинээр бүртгэгдсэн алтны үндсэн ордын нөөц, тн	32
Зураг 23.	Шинээр бүртгэгдсэн алтны шороон ордын нөөц, тн	32
Зураг 24.	Шинээр бүртгэгдсэн эсийн нөөц, мян.тн	32
Зураг 25.	Шинээр бүртгэгдсэн төмрийн хүдрийн нөөц, сая.тн	33
Зураг 26.	Шинээр бүртгэгдсэн нүүрсний нөөц, тэрбум.тн	33
Зураг 27.	Шинээр бүртгэгдсэн хайлуур жоншны хүдрийн нөөц, сая.тн	33
Зураг 28.	Монгол орны мезозойн тунамал хурдаст хотгоруудын тархалт ба тэдгээрийн газрын тосны геологийн нөөцийн зураг	34
Зураг 29.	Газрын тосны хайгуулын талбай	34
Зураг 30.	Газрын тосны эрлийн талбай	36
Зураг 31.	Эрдэс баялгийн мэдээллийн сан	38
Зураг 32.	Геофизикийн зургийн сан	38
Зураг 33.	Агаар, сансрын зургийн сан	38
Зураг 34.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл (<i>ашигт малтмалын төрлөөр, аймгаар</i>)	39
Зураг 35.	Уулын ажлын тайлан, төлөвлөгөө ирүүлсэн байдал	40
Зураг 36.	Нүүрс олборлолт, борлуулалт, экспорт	46
Зураг 37.	Нүүрсний салбараас улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого /2013-2015 он, 2016-2020 оны төсөөлөл/	46
Зураг 38.	Нүүрсний салбарын хөрөнгө оруулалт /2013-2015 он, 2016-2020 оны төсөөлөл/	47
Зураг 39.	Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө	49
Зураг 40.	Газрын тосны гэрээлэлт хийсэн, олборлолт явуулж байгаа талбайн мэдээлэл	51
Зураг 41.	Газрын тосны хайгуул, нөөц	52
Зураг 42.	Газрын тосны олборлолт, экспорт, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	53
Зураг 43.	2016 онд олборлосон болон экспортолсон газрын тосны хэмжээ, /мян.баррель/	54
Зураг 44.	Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний импорт	55
Зураг 45.	2016 онд экспортолсон газрын тосны бүтээгдэхүүн /10 дугаар сарын байдлаар/	56
Зураг 46.	Газрын тосны бүтээгдэхүүний төв лаборатори	57
Зураг 47.	Уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори	57
Зураг 48.	Хүнд үйлдвэрийн салбарын хууль эрхзүйн орчин	58
Зураг 49.	Экспортын бүтээгдэхүүний технологийн агууламж хувиар	59
Зураг 50.	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60
Зураг 51.	Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох талбай	76
Зураг 52.	Өргөдлөөр тусгай зөвшөөрөл олгох талбай	76
Зураг 53.	Зэс, катодын зэс, газрын тосны бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл	78
Зураг 54.	Цайр, жоншны бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл	78
Зураг 55.	Нүүрсний бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл	79
Зураг 56.	Мөнгө, цагаан тугалга, гянтболдын бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл	79
Зураг 57.	Алт, молебден, төмрийн хүдрийн бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл	79
Зураг 58.	Алт, зэс, цайрын үнийн мэдээлэл	83
Зураг 59.	Уул уурхай, газрын тосны салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, сая доллараар	85
Зураг 60.	Уул уурхай, газрын тосны салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувь хэмжээ, ашигт малтмалын төрлөөр	85
Зураг 61.	Эдийн засаг дахь татварын ачаалал	86
Зураг 62.	Уул уурхай, газрын тосны салбараас улсын нэгдсэн төсөвт 2017-2020 онд төвлөрүүлэх орлого	86
Зураг 63.	Монгол Улсын уул уурхай, газрын тосны орлогын хуваарилалтын схем	87
Зураг 64.	Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, уул уурхайн салбарын эзлэх хувь	88
Зураг 65.	Байгалийн нөөцийн Харти	89
Зураг 66.	Улсын нэгдсэн төсөв, уул уурхайн салбарын орлогын 2017-2020 оны төсөөлөл	92
Зураг 67.	ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь	93

Зураг 68.	АҮНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь	93
Зураг 69.	Экспортын бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь	93
Зураг 70.	Байгалийн баялгийн засаглалын индексийн хүрэх үр дүн	95
Зураг 71.	Монгол Улсад хайгуул, ашиглалт явуулж байгаа томоохон төслүүдийн байршлын зураг	97

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	Азийн улсуудын Хөрөнгө оруулалт татах чадварын индекс, эрэмбэ	11
Хүснэгт 2.	Монгол Улсын 2016 оны зээлжих зэрэглэл	13
Хүснэгт 3.	УГЗ-200 төслийн хэрэгжилт	27
Хүснэгт 4.	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын санхүүжилт	29
Хүснэгт 5.	Геологи хайгуулын ажлын төлөвлөлт ба гүйцэтгэл /тэрбум төгрөг/	30
Хүснэгт 6.	Газрын тосны БХГ-т талбайнуудад хийгдсэн хайгуулын ажил	35
Хүснэгт 7.	Нийт баримтын тоон үзүүлэлт /2016 оны 10 дугаар сарын байдлаар/	37
Хүснэгт 8.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, УАТ ирүүлсэн байдал	40
Хүснэгт 9.	2016 онд үйл ажиллагаа явуулаагүй үйлдвэр, уурхай	41
Хүснэгт 10.	2016 онд үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан	42
Хүснэгт 11.	2016 онд шинээр ашиглалтанд хүлээн авсан үйлдвэр, уурхай	42
Хүснэгт 12.	Алт олборлолтын хэмжээ, нийт борлуулалт	43
Хүснэгт 13.	“Эрдэнэт үйлдвэр”-ийн зэсийн баяжмал үйлдвэрлэл	43
Хүснэгт 14.	Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн зэсийн баяжмал үйлдвэрлэл	44
Хүснэгт 15.	Төмрийн хүдрийн олборлолтын байдал	44
Хүснэгт 16.	Жонш үйлдвэрлэл	45
Хүснэгт 17.	Гянтболдын олборлолт, борлуулалт	45
Хүснэгт 18.	Молибдений баяжмал	45
Хүснэгт 19.	Цайрын баяжмал үйлдвэрлэл	45
Хүснэгт 20.	Цагаан тугалганы баяжмал үйлдвэрлэл	45
Хүснэгт 21.	Нүүрсний уурхайн болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайлангийн баталгаажсан байдал /2013-2016/	46
Хүснэгт 22.	Нүүрсний уурхайн болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний баталгаажсан байдал /2013-2016/	46
Хүснэгт 23.	2016 оны төлөвлөлт ба гүйцэтгэл, бүтээгдэхүүн гаргалтын мэдээ	47
Хүснэгт 24.	Уулын ажилд хамрагдсан болон нөхөн сэргээсэн талбайн хэмжээ, зардал	49
Хүснэгт 25.	Газрын тосны олборлолт явуулж байгаа компани, талбайн мэдээлэл	51
Хүснэгт 26.	Газрын тосны улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, шимтгэл, хураамж	54
Хүснэгт 27.	Газрын тосны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт	55
Хүснэгт 28.	Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, автомашины тоо	56
Хүснэгт 29.	Хүнд үйлдвэрийн салбар дахь гол нэр төрлийн боловсруулах үйлдвэрлэл	60
Хүснэгт 30.	Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл	60
Хүснэгт 31.	Хүнд үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт	60
Хүснэгт 32.	Монгол Улсын бүтээгдэхүүний гадаад зах зээлийн орчин	61
Хүснэгт 33.	Монгол Улсын төмөрлөгийн үйлдвэрлэлийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээ	61
Хүснэгт 34.	Төмөрлөг бүтээгдэхүүний зах зээлийн нийлүүлэлт /2012-2016 он,/мян.тн/сая.ам.доллар	62
Хүснэгт 35.	Гангийн үйлдвэрүүдийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл	62
Хүснэгт 36.	Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 2017 онд хэрэгжих боломжтой зорилтууд	74
Хүснэгт 37.	Монгол улсын ашигт малтмалын нөөц	77
Хүснэгт 38.	Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөөлөл 2017-2020 он	78
Хүснэгт 39.	Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр 2017 онд хийгдэх гол ажлууд, хэрэгжүүлэх арга зам	80
Хүснэгт 40.	Гол нэрийн бүтээгдэхүүний үнийн урьдчилсан төсөөлөл	83
Хүснэгт 41.	Уул уурхай, газрын тосны салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, сая доллараар	84
Хүснэгт 42.	Байгалийн нөөцийн засаглалыг сайжруулах 12 ЖОР	90
Хүснэгт 43.	Хөрөнгө оруулалтыг татах чадварын индексийг сайжруулах гол үзүүлэлт	94
Хүснэгт 44.	Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай	144



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

I БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1.1.

МОНГОЛ УЛСЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Газар зүйн байршил

Монгол Улс нь Ази тивийн төв хэсэгт, дорнод уртрагийн $87^{\circ}44' - 119^{\circ}56'$, хойд өргөргийн $41^{\circ}35' - 52^{\circ}09'$ хооронд оршдог, 1,566.5 мянган кв.км нутагтай, газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд XVII байранд ордог. Хойд талаараа ОХУ, зүүн, баруун, урд талаараа БНХАУ-тай тус тус хиллэдэг.



Зураг 1. Монгол Улсын газар зүйн байршил



Байгалийн нөөц, баялаг

Монгол улсад өнөөгийн байдлаар ашигт малтмалын 50 гаруй төрлийн 3000 гаруй орд, илрэл мэдэгдэн судлагдаад байна. Хэнтий, Хангайн нурууны ар өврөөр алтны, Орхон, Сэлэнгийн сав газраар зэс молибдений, Дорнод Монголын нутгаар хайлуур жоншны, Хөвсгөл аймагт фосфоритын орд зонхилон тархжээ. Тавантолгой, Хар тарвагатай, Ачит нуур, Багануур, Өвдөгхудаг зэрэг чулуун нүүрсний үлэмж их нөөц бүхий ордуудтай. Налайх, Шарын гол, Адуунчулуун, Багануур зэрэг үйлдвэрийн бүсэд оршдог ордууд нь төв суурин газруудыг түлш, эрчим хүчээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

Төмрийн хүдрийн хувьд Төмөртолгой, Баянгол, Тамир гол зэрэг томоохон орд газар бий. Зэсийн хүдрийн ордуудын ихэнх нь Орхон, Сэлэнгэ, говийн бүс, өмнөд Хэрлэн, Баянхонгор, Ханхөхийн нутаг дэвсгэрт төвлөрдөг. Эдгээрээс хамгийн том нь Орхон, Сэлэнгийн бүс дэх Эрдэнэтийн зэс-молибденийн орд юм. Төмөртэйн овоо, Салхит, Тугалгатайн нуруу, Модон-Овооны цайрын хүдрийн хэд хэдэн зангилаа ордтой. Мөн алтны ордууд түгээмэл илэрсэн. Нутгийн зүүн хагаст хайлуур жоншны ордууд түгээмэл тархсан бөгөөд 1954 онд нээгдсэн Бэрхийн уурхай нь манай орны хайлуур жоншны томоохон ордуудын нэг. Фосфоритын ордуудын ихэнх нь Саяаны нурууны өврөөс Хөвсгөл нуурын баруун эргийг даган тархсан. Мөн болор, молор, биндэрьяа, анар, хризолит, аметист, оюу, пийсүү зэрэг эрдэнийн чулуу багагүй тархацтай төдийгүй зарим үйлдвэрлэлийн ач холбогдолтой орд ч бий.




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Монгол орон нийтдээ 67 мянга гаруй км урт гол горхи, 0.1 кв.км-ээс их талбай бүхий 4000 гаруй нуур, 7000 шахам булаг шандтайгаас гадна хөрсөн доорх цэнгэг усны арвин нөөцтэй. Манай орны гол мөрнийг Хойд мөсөн далайн, Номхон далайн, Төв Азийн гадагшаа урсгалгүй сав газрын гэж гурав хуваадаг. Сэлэнгэ нь Монголын хамгийн том мөрөн. Түүний сав газар цутгалуудынхаа хамт улсын нийт газар нутгийн 20 орчим хувийг эзлэн урсдаг. Урсгал нууруудаас хамгийн том нь Төв Азидаа хамгийн гүнд (262м) тооцогдох Хөвсгөл, тогтмол нуурын том нь Увс нуур (усны талбай нь 3350 кв.км).

Эдийн засгийн өнөөгийн байдал

Монгол Улс эрдэс баялгийн салбараас хараат эдийн засагтай улсуудын тоонд багтдаг. Статистик үзүүлэлтээс харвал эрдэс түүхий эдийн үнэ өсөлттэй байсан 2006 оноос Монгол Улсын эдийн засаг өсч эхэлсэн бөгөөд 2011 онд 1тн зэсийн үнэ 10000 ам.доллар, нүүрсний үнэ 300 орчим ам.долларт хүрч байх үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт 17.3% хүрч, дэлхийн хамгийн өсөлттэй (fastest growing) оронд тооцогдож байв. Харин эрдэс түүхий эдийн үнэ буурах үед эдийн засгийн өсөлт огцом буурч, 2015 онд 2.3%-д хүрсэн бол 2016 оны төгсгөлөөр 0.3%-д хүрэх төлөвтэй байна.

Зураг 2. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хувь, урьдчилсан төлөв*



Үүнээс үзвэл Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтвортой бус, эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралтаас шууд хамаардаг боловч хуримтлал үүсгэх, эдийн засгийн уналттай үед зарцуулах менежмент хийгдэхгүй байна.

Монгол Улсын 2016 оны эдийн засагт нөлөөлсөн гол хүчин зүйлүүд

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн гаргасан тооцоогоор дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 2016 онд 3,5%-тай гарсан нь 10 гаруй жилийн өмнө тохиосон дэлхийн санхүүгийн хямралын дараах жилийн өсөлт болох 4,5%-иас ч бага байна.

Монгол Улсын 2016 оны эдийн засгийн төлөв байдалд дараах хүчин зүйлс голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

- УИХ-ын сонгууль
- Том төсөл, Оюутолгойн далд уурхайн санхүүжилт
- Өрийн дарамт
- Санхүүгийн салбарын нөхцөл байдал
- Барилгын салбарын уналт
- Гадаад зах зээл

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын ДНБ оны үнээр 2016 оны эхний 9 сард 17258.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 136.4 тэрбум төгрөгөөр /0,8%/ буурсан бол нэг хүнд ногдох ДНБ 6.5 сая төгрөг байна. Монгол Улс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээрээ дэлхийн 183 улсаас 107-д бичигджээ.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



1.2

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГТ
ГЕОЛОГИ,
УУЛ УУРХАЙ,
ГАЗРЫН ТОСНЫ
САЛБАРЫН
ЭЗЛЭХ БАЙР
СУУРЬ

Монгол Улсын ДНБ 2016 оны эхний 9 сарын байдлаар 17.2 их наяд төгрөг байсан бөгөөд үүнээс уул уурхайн салбарынх 2.9 их наяд төгрөг хүрчээ.


2015 онд ДНБ 23.2 их наяд төгрөг байснаас 5.8 их наяд төгрөг нь уул уурхайн бүтээгдэхүүн байсан юм. Монгол Улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний (АҮНБ) үйлдвэрлэл 2016 оны эхний 11 сард 8.8 их наяд төгрөг байсны 71% буюу 6.2 их наяд нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбараас гаралтай байна.

2016 оны эхний 10 сарын байдлаар улсын хилээр 3.7 тэрбум ам.долларын үнэлгээ бүхий бүтээгдэхүүн экспортод гарснаас 3.2 их наяд ам.долларынх нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнд ногдож байна. Уул уурхайн экспортын хэмжээ 2015 онтой харьцуулахад 933.7 сая ам.доллараар багасч, нийт экспортод эзлэх хэмжээ 2 нэгж хувиар буурчээ.

Улсын хилээр гарсан уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний үнэлгээ 2016 оны эхний 10 сарын байдлаар 3.7 тэрбум ам.доллар буюу нийт экспортын бүтээгдэхүүний 87.3%-ийг эзэлж байна.

Дараах графикт ул уурхайн салбарын улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг үзүүлэв.

Зураг 3. Уул уурхайн салбарын ДНБ, АҮНБ-д эзлэх хувь*



* www.1212.mn



**Фрейзерийн
хүрээлэнгийн
Хөрөнгө
оруулалт татах
чадварын
индекс**

Бие даасан, хараат бус судалгааны байгууллага болох Фрейзерийн хүрээлэн (Fraser institute) жил бүр уул уурхайн компаниудаас авсан судалгааны үндсэн дээр ашигт малтмалын боломж болон татварын тогтолцоо, хууль эрх зүйн тодорхой бус байдал зэрэг төрийн бодлогын хүчин зүйлүүд хайгуулын ажлын хөрөнгө оруулалтад хэрхэн нөлөөлж буйг үнэлдэг.

Хөрөнгө оруулалт татах чадварын индекс нь Бодлогын нөлөөллийн индексийн 40%-ийн оролцоо, Ашигт малтмалын боломжийн шилдэг туршлагын индексийн 60%-ийн оролцооноос бүрддэг. Монгол улсын хөрөнгө оруулалт татах чадварын индекс 2015 онд 109 орноос 85 дугаарт эрэмбэлэгджээ.

1.3

МОНГОЛ УЛСЫН
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЧИН, ГАДААДЫН
ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Хүснэгт 1. Азийн улсуудын Хөрөнгө оруулалт татах чадварын индекс, эрэмбэ*

Азийн улс	ОНОО					ЭРЭМБЭ				
	2015	2014	2013	2012/2013	2011/2012	2015	2014	2013	2012/2013	2011/2012
Хятад	58.49	48.89	58.69	54.5	61.07	64/109	94/122	62/112	63/96	59/93
Энэтхэг	55.47	58.26	52.13	58.69	50.34	73/109	68/122	84/112	53/96	82/93
Казахстан	74.66	50.84	63.45	62.5	61.27	20/109	88/122	53/112	42/96	58/93
Киргизстан	45.91	40.69	37.5	55.27	55.71	91/109	109/122	107/112	62/96	75/93
Лаос	54.44	67.06	47.22	*	57.91	77/109	45/122	91/112	*	69/93
Монгол	50.03	49.22	53.25	67.04	67.18	85/109	93/122	80/112	31/96	41/93
Мянмар	48.92	61.7	53.32	*	*	87/109	60/122	79/112	*	*
Вьетнам	53.96	55.62	48.77	56.45	41.64	78/109	78/122	89/112	59/96	91/93

Хөрөнгө оруулалт татах чадварын индекс 2011/2012, 2012/2013 оны тайланд 67 орчим байсан бол 2013 онд 53.2, 2014 онд 49.2 болтлоо буурснаа 2015 онд бага зэрэг нэмэгдэж 50 болжээ.

Зураг 4. Монгол Улсын хөрөнгө оруулалт татах чадварын индекс



Монгол Улсын хөрөнгө оруулалт татах чадварын индекс буурч байгаа нь дүрэм журмын давхцал хийгээд уялдаагүй байдал, хууль эрхзүйн ойлгомжгүй байдал, мэдээллийн ил тод байдал, төмөр зам, авто замд холбогдох боломж, эрчим хүчний хангамж муу, улс төрийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалж байна гэж Фрейзерийн хүрээлэн дүгнэжээ.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР




Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Эрдэс баялгийн засаглалын индекс

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (Natural Resource Governance Institute буюу хуучин нэрээр Revenue Watch Institute-Орлогыг ажиглагч хүрээлэн) нь техникийн зөвлөгөө өгөх, өмгөөлөх, сэдэвчилсэн судалгаа, бодлогын шинжилгээ хийх, чадавхийг бэхжүүлэх замаар тухайн улс орны иргэдэд өөрийн орны газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын үр ашгийг ойлгоход тусалдаг. Тус байгууллага нь байгалийн баялаг ихтэй улс орнуудын газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын засаглалын чанарыг хэмждэг байгалийн баялгийн засаглалын индексийг гаргадаг. 2012 онд хийсэн судалгаанд 58 улс хамрагдсан бөгөөд индексийг 100 гаруй шинжээч 172 асуулт бүхий 50 үзүүлэлтээр боловсруулжээ. Эдгээр 58 үзүүлэлт нь Институци болон хууль эрх зүйн тогтолцоо, Тайлагналын тогтолцоо, Баталгаа болон чанарын хяналт, Дэмжигч орчин гэсэн үндсэн 4 бүлэгт хуваагддаг.

№	Багц үзүүлэлт	Хувь	Үзүүлэлтийн тоо	Байр	Оноо
1	Институци, эрх зүйн орчны тогтолцоо	20%	10	9	80
2	Тайлагналын тогтолцоо	40%	20	41	39
3	Баталгаа, чанарын хяналт	20%	15	37	49
4	Дэмжигч орчин	20%	5	20	48
	Нийт			26	51

Монгол Улс 58 улсаас 51 оноогоор “дунд” хэмээн үнэлэгдэж, 26 дугаар байранд оржээ. Бүтэц болон хууль эрх зүйн зохицуулалтаар маш сайн оноо авсан ч мэдээлж, тайлагнах чиглэлээр хангалтгүй үнэлгээ авч 58 орноос 41-д бичигдсэн байна.

Зураг 5. Олон улсын байгалийн засаглалын индекс*



Хангалттай (71-100)
Дунд (51-70)
Сул (41-50)
Хангалтгүй (0-40)

* www.resourcesgovernance.org

Монгол Улсын зээлжих зэрэглэл

Засгийн газрын зээл авах болон зээлээ эргүүлэн төлөх чадварыг олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагын зээлжих зэрэглэлээр хэмждэг. Энэхүү үнэлгээг Standard&Poor's, Moody's болон Fitch гэсэн 3 агентлаг голчлон тогтоодог.

2016 онд эдгээр байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан юм. Бондын эргэн төлөлт, төсвийн алдагдал, эдийн засгийн өсөлт зэрэг санхүүгийн үзүүлэлтүүд мэдэгдэхүйц муудсан нь зэрэглэлийг бууруулах үндэслэл болжээ. Тухайлбал 2016 оны 11 дүгээр сард Fitch агентлаг Монгол Улсын гадаад болон дотоод валютын зээлжих зэрэглэлийг B- зэрэглэлээс B хүртэл бууруулсан бол Moody's агентлаг урт хугацаатай зээлжих зэрэглэлийг B3-аас Caa1 болгон бууруулав.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


Хүснэгт 2. Монгол Улсын 2016 оны зээлжих зэрэглэл

	Moody's	Fitch Ratings	STANDARD & POOR'S
Зэрэглэл	Caa1	B-	B-
Хэтийн төлөв	Тогтвортой	Тогтвортой	Тогтвортой
Огноо	2016-11-18	2016-11-22	2016-08-19

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Дэлхий уул уурхайн супер мөчлөгтэй уялдан Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт 2005-2012 он хүртэл огцом өсөлт үзүүлсэн боловч 2013 оноос хойш огцом буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 онд хамгийн өндөр түвшиндээ хүрч 4.45 тэрбум ам.долларт хүрч байсан бол 2016 оны эхний хагас жилийн байдлаар 273 сая ам.долларт хүрч буурчээ.

Зураг 6. Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт *





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



2009 онд Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсантай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт 4 дахин өссөн ч 2012 оноос буурсныг дараах шалтгаануудаар тайлбарладаг.

2012 онд батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхдээ тухайн хуулийн этгээдийн 33%-иас дээш байх тохиолдолд Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрөл авах зохицуулалт тусгагдсан юм.

2012 онд боловсруулан хэлэлцүүлсэн ч хараахан батлагдаагүй Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компанийн 34% нь Монгол Улсын хуулийн этгээд, иргэн байх тухай заалт тусгагдсан нь гадаадын хөрөнгө оруулагчдад болгоомжлол төрүүлэв.

Дээрх хүчин зүйлсээс гадна 2009 онд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (*Урт нэртэй хууль- Long named law*) батлагдсан, 2011 онд 106 тусгай зөвшөөрлийг шүүхийн шийдвэрээр цуцалсан, Канадын хөрөнгө оруулалттай “Хан ресурс” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг цуцалж, Арбитрын шүүхэд хариуцагчаар татагдсан, “Саут гоби ресурс” компанийн гадаад захирлуудыг цагдан хорьсон зэрэг нөхцөл шалтгааны улмаас гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын нэр хүнд унасан юм.



1.4


АШИГТ
МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН БҮТЭЦ
ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ,
САЛБАРЫН
ХУУЛЬ ЭРХ
ЗҮЙН ОРЧИН

АМГТГ-ын бүтэц, зохион байгуулалт

Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор хуучнаар Ашигт малтмалын газар, Газрын тосны газрыг нэгтгэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт малтмал, газрын тосны газрыг шинэчлэн байгуулсан.

Тус газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаанд төрөөс баримтлан явуулж байгаа бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дотоод зохион байгуулалтын 12 хэлтэс /төв, лаборатори/-т 185 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 7. Ашигт малтмал, газрын тосны газрын бүтэц зохион байгуулалт





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Орлогч дарга
М.Энхжаргал



Орлогч дарга
Л.Раднаасүрэн

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДОТООД
ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН 12
ХЭЛТЭС



Геологи, хайгуулын хэлтэс



Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс



Нүүрсний судалгааны хэлтэс



Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс



Кадастрын хэлтэс



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТӨСНӨ ГАЗАР



Хууль, эрх зүйн хэлтэс



Төрийн захиргааны удирдлагын хэлтэс



Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Газрын тосны ашиглалтын хэлтэс



Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс



Хүнд үйлдвэр, техник, технологийн хэлтэс



Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын лаборатори

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” /2014-2025 он/-ыг баталсан.

Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”, 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогыг тус тус баталсан.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Ашигт малтмал, газрын тосны салбарын хуулиуд

Тус улсад ашигт малтмалын салбарт батлагдсан хамгийн анхны эрх зүйн баримт бичгийг 1913 онд батлагдсан “Олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм” байсан гэж үздэг. Ашигт малтмал, газрын тосны салбарт өнөөдөр 30 орчим хууль, 50 гаруй журам, заавар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд зарим голлох ач холбогдолтой хуулийг онцлон дурдвал:

Ашигт малтмалын тухай хууль

Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд шинэчлэн баталсан бөгөөд түүнээс хойш уг хуульд өнөөдрийг хүртэл 20 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэлэг зохицуулалтууд:

- УИХ, Засгийн газар, түүнчлэн ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (яам), төрийн захиргааны байгууллага (АМГТГ) зэрэг байгууллагын эрх хэмжээг тодорхой болгосон.
- Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээний загварыг Засгийн газраас батлахаар зохицуулсан.
- Засгийн газраас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх болсон.
- Геологийн салбарт баримтлах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилт бүхий геологийн судалгаа, шинжилгээ, мэдээлэл хариуцсан Үндэсний геологийн алба байгуулахаар тусгасан.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа нийт 9 жил байсныг 12 жил болгосон.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжинд Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид давуу эрх олгодог байхаар зохицуулсан.
- Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлэхийг зааж өгсөн.
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулахаар заасан.
- Ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээний дагуу хүртэх ногдол ашигтай дүйцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай нөөц ашигласны төлбөрийн хэлбэрээр орлуулан авах нөхцөлийг бүрдүүлсэн.



Хөрөнгө оруулалтын тухай хууль

Хөрөнгө оруулалтын тухай хуулиар Монгол Улсад хөрөнгө оруулагчийг гадаад, дотоодын гэж ялгаварлахгүйгээр нийтлэг эрх зүйн зохицуулалт, хамгаалалт, баталгаа бий болгосон бөгөөд хөрөнгө, орлогоо гадаадад саадгүй гүйвуулах, хөрөнгө оруулагчийн оюуны өмчийг хуульд заасны дагуу хамгаалах боломжтой болсон.

Мөн Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад зөвшөөрөл авдаг тогтолцоог халж, улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагаагаа эхлүүлдэг болж, хөрөнгө оруулагчийн 4 төрлийн татварын орчныг тогтвортой байлгах баталгааг төр гаргасан.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон Газрын тосны тухай хууль

Газрын тосны салбарт эрх зүйн таатай орчин бүрдэж, өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн. Мөн уламжлалт бус газрын тос хэмээх эдийн засгийн шинэ салбар хөгжих эрхзүйн үндэс бүрдсэн. Газрын тосны бүтээгдэхүүний гадаад худалдаанд төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан бодлого баримтална.

Төсвийн тухай хууль

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр ашигт малтмалын төлбөрийн орлоготой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр(АМНАТ)-ийн орлогын 33-аас доошгүй хувийг олборлолт хийсэн сум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд тус тус олгохоор заасан.





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

Уг хөтөлбөрт геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр цөөнгүй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал:

- Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геозкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих;
- Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх;
- Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгох;
- Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх;
- Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох;
- Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчин бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх;
- “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанкт хамтран шийдвэрлэх;
- Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах;
- Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих;
- Гадаадын хөрөнгө оруулагчдад бодлогын, хамтын ажиллагааны болон хууль, эрх зүйн тогтвортой байдал, тааламжтай орчин бүрдүүлж, тэдгээрийн эрх ашигт хамаарах олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын болон бусад салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт татах бодлогыг тууштай хэрэгжүүлэхээр тус тус заасан.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

II БҮЛЭГ.


ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1

ХАЙГУУЛЫН
БОЛОН
АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Монгол Улсын хэмжээнд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хайгуулын болон ашиглалтын нийт 3580 тусгай зөвшөөрөл олгогдоод байна. Үүнээс 2022 нь хайгуулын, 1558 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл юм. Нийт нутаг дэвсгэрийн 8.9%-д ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсоноос 8%-ийг хайгуулын, 0.9%-ийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэлж байна.

Зураг 8. Тусгай зөвшөөрлийн тархалтын зураг (2016.12.31) *




* <https://cmcs.mram.gov.mn/cmcs#cid=1>




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

2010 онд батлагдсан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохыг зогсоогоод байсан бөгөөд 2014 онд уг хуулийг хүчингүй болгож, 2015 оноос цахимаар олгож эхэлсэн юм. 2016 онд нийт 757 тусгай зөвшөөрөл олгогдсоноос 666 нь хайгуулын, 91 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.

Зураг 9. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байдал



Зураг 10. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байдал



Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-ын Кадастрын хэлтэс нь 2015-2016 онд нийт 10 багцын 574.9 мян.га бүхий 97 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулж, хайгуулын 39 тусгай зөвшөөрөл олгоод байна.

Монгол Улсын хэмжээнд 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цацраг идэвхт ашигт малтмалын нийт 38 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаагаас 955.7 мянган га талбайд хайгуулын 29, 81.9 мянган га талбайд ашиглалтын 9 тусгай зөвшөөрөл тус тус бүртгэлтэй байна.


Тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлс

Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу тусгай зөвшөөрлийн төлбөрийг улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. Тусгай зөвшөөрлийн төлбөрт 2014 онд 42.8 тэрбум төгрөг, 2015 онд 39.4 тэрбум төгрөг, 2016 онд 34.3 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 11. Тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлс*



АМГТГ-ын Кадастрын хэлтэс нь Ашигт малтмалын тухай хуульд 2014 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2015-01-26-ны өдрөөс хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дараах схемийн дагуу хүлээн авч тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн.

Зураг 12. Цахимаар дугаар олгож хайгуулын тусгай зөвшөөрөл олгох диаграмм**



* www.mram.gov.mn

** <https://cmcs.mram.gov.mn/cmcs#cid=1>



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Кадастрын хэлтэс нь нийт 37 удаа цахим хэлбэрээр 3915 дугаар олгосноос 2335 өргөдлийг бүртгэж хянан шийдвэрлэсэн байна. Үлдсэн 1580 дугаарыг авсан аж ахуйн нэгжүүд цаг хугацаандаа багтаж өргөдлөө гаргаагүй байна. Бүртгэсэн нийт өргөдлийн талбайн хэмжээ 13.26 сая гектар байгаа нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор нийтэд зарласан 20.9 сая гектар талбайн 63.5%-ийг эзэлж байна. Нийт ирүүлсэн 2335 өргөдлөөс:

- Тусгай зөвшөөрөл олгосон- 1244
- Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан- 681
- Өмнөх өргөдөл нь шүүхийн маргаантай болон бусад шалтгаантай тул хүлээгдэж байгаа- 38
- Орон нутгаас дэмжсэн саналтай- 5
- Орон нутгаас дэмжээгүй тул шийдвэрлэгдээгүй нийт- 367

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлс 3.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Мөн цахимаар өргөдөл өгөх системийн эрх нээлгэх /VPN/ төлбөр болох 2.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.2

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ
НӨӨЦ, ХАЙГУУЛ

2.2.1


ГЕОЛОГИЙН
СУДАЛГААНЫ
АЖЛУУД

А.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгаа



Монгол Улсын геологийн судалгааны түвшинг дараах зурагт үзүүлэв.

Зураг 13. Монгол Улсын геологийн судалгааны түвшин*



* www.mram.gov.mn



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Монгол Улсад бүс нутгийн эрдэс түүхий эдийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, эрдэс баялгийн нөөцийн хэтийн төлөвийг үнэлэх, хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал болон газрын хэвлийн ашиглалт, олборлолттой холбоотой шийдвэр гаргахад суурь мэдээлэл болгон ашиглах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажлыг хийж байна.

2016 оны байдлаар Монгол Улсад геологийн судалгааны 4 чиглэлээр 40 төсөл хэрэгжиж байна.

Зураг 14. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүд



1:200 000-ны масштабын Улсын геологийн иж бүрдэл зураг зохиох

УГЗ-200 геологийн иж бүрдэл зураг зохиох 4 төслийн ажил үргэлжлэн хэрэгжиж, 2015 онд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 287,924.35 кв.км нутагт УГЗ-200 геологийн иж бүрдэл зураг зохиож, нутгийн 18%-ийг хамарсан бол 2016-2017 онд 100% тоон мэдээлэл бүхий геологийн зураглалын ажлаар бүрэн бүрхэгдэнэ. “УГЗ-200” иж бүрдэл зургуудыг зохиох, хэвлэлтэд бэлтгэх зааварт тусгагдсаны дагуу үндсэн хавтгай тус бүрээр Геологийн, Ашигт малтмалын, Экологи-геологийн, Дөрөвдөгчийн хурдасны, Баримт материалын гэсэн 5 зургийг 1:200 000-ны масштабаар, дагалдах тойм зургуудын хамтаар иж бүрдлээр нь зохиох ба мэдээллийн санг бүрдүүлнэ.


Хүснэгт 3. УГЗ-200 төслийн хэрэгжилт

Төслийн хэрэгжилт	Тоо хэмжээ /хавтгай/
Нийт хавтгай	344
2001-2010 онд хэрэгжсэн төсөл	114
2010-2012 онд хэрэгжиж үр дүнгийн тайлан өгөх төслүүд	82
2011-2014 онд хэрэгжиж буй төслүүд	71
2013-2016 онд хэрэгжих төсөл	77

Зураг 16. УГЗ-200 зураг, судалгаагаар бүрхэгдсэн (хамрагдсан) байдал*




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



1:50 000-ны масштабын Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил /ГЗЕЭА/

2016 онд 1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын 29 төсөл хэрэгжиж байгаагаас 1 төсөл нь олон улстай хамтарсан байдлаар хэрэгжиж байгаа бол бусад 28 төслийг дотоодын аж ахуй нэгжүүд хэрэгжүүлж байна. Монгол Улсын хэмжээнд 2016 оны байдлаар нийт газар нутгийн 33.7%-д 1:50 000 масштабтай ГЗЕЭ-ийн ажил хийгдсэн.


Зураг 17. Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааны зураг



Сэдэвчилсэн судалгаа

Монгол Улсын хэмжээнд сэдэвчилсэн судалгааны Геомэдээллийн сан, Сансрын зургийн тайлалт, Баруун Монголын цул сульфидын хүдэржилт, түүний хэтийн төлөвийн судалгаа, Монгол орны металлогени, ашигт малтмалын ордын төрлүүдийн тархалт, байршлын зүй тогтлын судалгаа, Геофизикийн Алтай-1, Алтай-2 агаарын геофизикийн судалгаа төслүүд хэрэгжиж байна.

Зураг 18. Алтай-1, Алтай-2 төсөл



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Хамтарсан төсөл

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНЧУ-тай хамтарсан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн “Монгол Алтай-50”, Монгол-Польшийн хамтарсан “Хасагт-50” эрлийн ажлыг гүйцэтгэх төслийн ажлууд дуусч, эцсийн үр дүнгийн тайланг Монголын тал хүлээн авав.

БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн (КИГАМ)-тэй хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Цогтцэций-50 төсөл хэрэгжүүлж байна. 2016 онд төслийн 2 дахь жилийн хээрийн ажлыг гүйцэтгэв.

Монгол улс, ОХУ, БНХАУ, БНСУ-ын “Хойт-Төв-Зүүн Азийн хамтарсан төслийн III үе шатны ажил үргэлжлэн хэрэгжиж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын санхүүжилт

2016 онд эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан геологийн судалгааны ажил харьцангуй оройтсон боловч 2016 оны байдлаар нийт төслийн ажлын санхүүжилт 9.1 тэрбум буюу 98%-тай байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын санхүүжилт

	2013		2014		2015		2016	
	сая.төг	гүйцэтгэл %	сая.төг	гүйцэтгэл %	сая.төг	гүйцэтгэл %	сая.төг	гүйцэтгэл %
БҮГД	6809.9	93.0%	9209.2	92%	9280.6	82%	9164.2	98%
УГЗ 1:200000	763.89	5.6%	807.2	89%	330.5	63%	649.5	99%
1:50000 ГЗЕЭА	5809.4	96.5%	7314.8	93%	5556.7	78%	5103.2	105%
Сэдэвчилсэн ажил	155.8	34.3%	1003.5	88%	3167.7	92%	3183.9	100%
Хамтын ажиллагааны төсөл	80.9	168.9%	83.6	70%	225.6	79%	227.7	92%




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Б.Хувийн хөрөнгөөр гүйцэтгэж буй хайгуулын ажил

Ашигт малтмалын тухай хуулийн 48.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтэс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүр ирүүлдэг хайгуулын ажлын төлөвлөгөө болон жилийн тайланг хүлээн авч хянадаг. Тус хуулийн 33.1, 33.2-т заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянаж, санхүүгийн жилийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулдаг юм. Дараах хүснэгтэд хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо, АМГТГ-т ирүүлсэн хайгуулын ажлын төлөвлөгөөг үзүүлэв. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2016 онд тус газарт нийт 1669 хайгуулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн байна.


Зураг 19. Хайгуулын ажлын жилийн тайлан ирүүлсэн байдал /2016.12.31-ний байдлаар/




Хайгуулын ажлын жилийн тайлангаас үзвэл 2015 онд “Кожеговь”, “Оюут-Улаан”, “Өү Жи Си Эйч Эл”, “Болд Төмөр Ерөө Гол”, “Альшаахайрхан”, “Миллениум сторм”, “Харанга сүмбэр”, “Блэкрок” зэрэг компани хайгуулын ажилд 2-4 тэрбум төгрөг зарцуулсан нь хамгийн өндөр зардалд тооцогдож байна.

Хайгуулын ажлын зардлын гүйцэтгэлээс харвал 2012 оноос эхлэн геологи хайгуулын ажлын хэмжээ жил дараалан буурсан үзүүлэлттэй гарчээ. Энэ нь дэлхийн зах зээлд ашигт малтмалын үнэ унаснаас үүдэн хөрөнгө оруулалт буурсантай холбоотой юм.


Хүснэгт 5. Геологи хайгуулын ажлын төлөвлөлт ба гүйцэтгэл /тэрбум төгрөг/





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 20. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын ажилд зарцуулсан зардлын ажлын төрлөөр эзлэх хувь /2016 он/




2.2.2

ХУВИЙН
ХӨРӨНГӨӨР
ХАЙГУУЛЫН
АЖИЛ ХИЙЖ
НӨӨЦ
ТОГТООСОН
БАЙДАЛ

Ашигт малтмалын тухай хуулийн 48.3-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөөц бүхий үр дүнгийн тайланг боловсруулж ирүүлдэг. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр 2016 онд 105 орчим нөөц бүхий үр дүнгийн тайлан ирүүлснээс 94 ордын нөөцийг бүртгэх шийдвэр гаргасан байна.

2016 онд шинээр алтны үндсэн ордын 6, шороон ордын 33, төмрийн 4, зэсийн 2, холимог металлын 2, ховор металлын 2, нүүрсний 8, хайлуур жоншны 4, ураны 1, бал чулууны 2, шохойн чулууны 3 ордоос гадна барилгын чулуу, элс, хайрга, шаврын ордын нөөц бүртгэгджээ.

Зураг 21. Улсын нөөцийн бүртгэлд шинээр бүртгүүлсэн ордууд /2009-2016.10/





Сүүлийн жилүүдэд бүртгэгдсэн нөөцийг голлох ашигт малтмалын төрлөөр үзвэл,




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР





Зураг 22. Шинээр бүртгэгдсэн алтны үндсэн ордын нөөц, тн



Зураг 23. Шинээр бүртгэгдсэн алтны шороон ордын нөөц, тн




Зураг 24. Шинээр бүртгэгдсэн зэсийн нөөц, мян.тн






АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


Зураг 25. Шинээр бүртгэгдсэн төмрийн хүдрийн нөөц, сая.тн



Зураг 26. Шинээр бүртгэгдсэн нүүрсний нөөц, тэрбум.тн



Зураг 27. Шинээр бүртгэгдсэн хайлуур жоншны хүдрийн нөөц, сая.тн



2.2.3

ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Монгол орны нутаг дэвсгэрт судлаачид мезозойн тунамал хурдаст 13 томоохон сав газар, 59 дэд хотгорыг ялгасан. Эдгээр сав газар нь 17 аймгийн нутаг дэвсгэрт 523 мянган км² талбайг хамардаг.

1990 онд Америкийн EAIT (Exploration Associates International of Texas, Inc) нь Монгол орны мезозойн тунамал хурдаст Тамсаг, Чойбалсан, Дорноговь, Нялга, Өмнөговь, Дундговь, Гашуун, Говь-Алтай, Алтайн өмнөд ба цаадах, Их нуурууд, Нууруудын хотгоруудын газрын тосны геологийн нөөцийг 10 хувийн магадлалаар 2607 сая баррель, 50 хувийн магадлалаар 1031 сая баррель, 95 хувийн магадлалаар 344 сая баррель гэж үнэлсэн байдаг.

Зураг 28.



Дээрх сав газруудын хүрээнд газрын тосны хайгуулын 32 талбай ялгасан. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хайгуулын 27 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ байгуулснаас 2 талбайн БХГ дуусгавар болж, 25 талбайд БХГ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Шинээр 3 талбайд БХГ байгуулах шатанд, 2 талбай нээлттэй байна. Нийт 25 талбайд БХГ-ий дагуу 21 гэрээлэгч компани газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр компанийн 28.5% нь Монгол, 42.8% нь БНХАУ, 28.7% нь бусад /Канад, Швейцар, Австрали г.м/ улсын харьяалалтай.

Зураг 29. Газрын тосны хайгуулын талбай



Газрын тосны хайгуулын ажлууд

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 1993-2016 онд газрын тосны хайгуулын талбайнуудад 272890 км² талбайд 1:200000 масштабын хүндийн хүчний судалгаа; 77630 км² талбайд соронзон хайгуул; 210 физик цэгт пассив сейсм; 33494 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа; 6274 км² талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа; 21990 км агаарын 5 сувагт градиометрийн судалгаа тус тус хийж, хайгуул, үнэлгээ, олборлолтын 1537 цооног өрөмдсөн. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд нийт 3.45 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2016 оны байдлаар, хайгуулын Галба XI талбайд 14 цооног өрөмдсөнөөс 11 цооногт тос илэрч, 3 цооногт тосны урсгал тогтоогдсон. Уг талбайд газрын тосны хэтийн төлөв бүхий 3 бүтэц тогтоож, туршилтаар 1517 м³ тос олборлосон. 2015 онд урьдчилсан байдлаар 3.6 км² талбайд газрын тосны 300*104 тонн нөөц тооцоолж, үнэлгээ хийсэн. Хайгуулын Хөхнуур XVIII талбайд 3 цооногт туршилт хийж 35,2 м³ тос олборлосон байна.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Хүснэгт 6. Газрын тосны БХГ-т талбайнуудад хийгдсэн хайгуулын ажлууд /1993-2016 он/


№	БХГ-т талбай	Чичирхийллийн судалгаа		Хүндийн хүчний судалгаа (км ²)	Өрөмдсөн цооногийн тоо
		2D /тууш.км/	3D /км ² /		
1	Увс I	138		505	2
2	Хар-Ус II			1480	
3	Богд IV	1296.9		FTG 16260 км	1
4	Онги V	1681.4		FTG 5730 км	1
5	Борзон VII	465.8		31430	1
6	Төхөм Х _{хойд}	1130.9		21840	2
7	Төхөм Х _{урд}	345.3		7040	
8	Галба XI	1316	358.9		14
9	Цагаан-Элс XIII	790.6		11593	2
10	Зүүнбаян XIV	1155.7		8730.8	
11	Тариач XV	1761.1	446.5	6570	21
12	Нялга XVI	691.4			2
13	Баянтүмэн XVII	1073.3		7832	
14	Хөхнуур XVIII	2408.2		9861	5
15	Матад XX	1834.6	133.6	7900	12
16	Сулинхээр XXIII	480		13575.8	
17	Дарьганга XXIV	210		17178	
18	Цайдам XXVI	578.5		23503	1
19	Сүхбаатар XXVII	453.1		23043	
20	Арбулаг XXIX	223		1769.4	
21	1997БХГ	5138.8	339.6		124
22	Тосон-Уул XIX	10631.3	4995.2	8000	866
23	Тамсаг XXI				475
24	Буйр XXII				8
Н И Й Т		33494.2	6273.9	272890	1537

Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажлууд

Газрын тосны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэн, хувийн хөрөнгөөр эрлийн ажил хийх хүсэлт гаргасан компаниудтай хамтран газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлал тогтоох, хэтийн төлөв бүхий хайгуулын талбай ялгах зорилгоор нүүрсний давхаргын метан хийн 9, шатдаг занарын 1, газрын тосны 10, нийт 20 эрлийн гэрээ шинээр байгуулснаас 2 гэрээ цуцлагдсан. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3, нийт 18 эрлийн гэрээ хэрэгжиж байна.



Зураг 30. Газрын тосны эрлийн талбай



Эрлийн гэрээний дагуу 4000 км геологийн маршрут, 7250 км² талбайд геологийн судалгаа хийж, 12717 км² талбайд хүндийн хүчний судалгаа, 1600 км² талбайд соронзон хайгуул, 713,84 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа тус тус хийж, эрлийн гүехэн 12 цооног өрөмдөж, нийт 10,87 сая ам.доллар зарцуулсан.

2016 оны байдлаар, эрлийн ажлын үр дүнд Арбулаг талбайн газрын тосны хэтийн төлөвийг тогтоож, хайгуулын талбай ялгасан. Уг талбайд БХГ байгуулагдсан.

“Жени Ойл Шейл Монголиа” ХХК шатдаг занарын дээжинд хийсэн лабораторийн шинжилгээгээр 12-23 хувийн органик нүүрстөрөгчийн агуулгатай, хүхэр болон чийгийн хэмжээ бага, керогеноос тос үүсэх гарц өндөр болохыг тогтоосон бол “Эрдэнэс Тавантолгой” ХК Тавантолгойн нүүрсний ордоос метан хийн туршилтын олборлолт хийж, метан хийн геологийн нөөцийг 40 сая тонн гэж тооцсон.

Австрали улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК эрлийн ажлын үр дүнд Номгон талбайд нүүрсний давхаргын метан хийн БХГ байгуулах хүсэлт гаргаад байна.



Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 10 дугаар тушаалаар байгуулагдсан.

Тус төв нь эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, эрдэс баялгийн салбарын мэдээллийн санг цахим ба биет хэлбэрээр бүрдүүлэх, баяжуулах, орчин үеийн, олон улсын жишигт нийцэхүйц мэдээллийн технологи, программ хангаж ашиглан боловсруулах, хэрэглэгчийг шаардлагатай, үнэн зөв, бодит цаг үеийн мэдээллээр түргэн шуурхай хангах, мэдээллийн сангийн чиглэлээр дотоод, гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой.

Геологийн баримтын төв архив:

• Геологийн баримтын төв архивын тайлангийн сан нь ашиглалтын, нөөцийн, нөхөн бүрдүүлэлтийн, нууцын, цахим, хувийн гаралтай, жилийн ажлын тайлан, төлөвлөгөөний гэсэн 7 төрлийн хөмрөгөөс бүрдэх ба нийтдээ 8050 тайлангийн 38150 хадгаламжийн нэгжтэй.

Хүснэгт 7. Нийт баримтын тоон үзүүлэлт /2016 оны 12 дугаар сарын байдлаар/

№	Хөмрөгийн төрөл	Тоо хэмжээ	Нийт ном	Хавсралт зураг
1	Нөөц хөмрөгийн баримт	8050 ХН	18335	210532
2	Ашиглалтын хөмрөгийн баримт	4704 ХН	10609	119036
3	Нөхөн бүрдүүлэлтийн баримт	1481 ХН	3890	53015
4	Хувийн хөрөнгийн баримт	2270 ХН	5340	52585
5	Агаарын фото зураг	3551 ш	-	652000
6	Позитив, негатив хальс	4010 ХН	3738	-
7	Хээрийн анхдагч баримт	2500 ХН	6100	-
8	Уурхайн олборлолтын тайлан, төлөвлөгөө, хайгуулын жилийн ажлын тайлан, төлөвлөгөө	дэвтэр	35200	-

ТӨРӨЛЖСӨН МЭДЭЭЛЛИЙН САН:


Ашигт малтмалын мэдээллийн сан	
Судалгааны бүртгэл мэдээллийн сан	Уст цэгийн мэдээллийн сан
Давхарга зүйн мэдээллийн сан	Геохимийн мэдээллийн сан
Интрузив биетийн мэдээллийн сан	Ашигт малтмалын балансын мэдээллийн сан

ЗУРГИЙН САН:


Геологийн зураг	Тектоникийн зураг
Ашигт малтмалын зураг	
Геофизикийн зургууд	
Геохимийн зураг	



Зураг 31. Эрдэс баялгийн мэдээллийн сан



Зураг 32. Геофизикийн зургийн сан



Зураг 33. Агаар, сансарын зургийн сан



2.3

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ


2.3.1

АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлд 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 1560 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрөл, байршлаар нь ангилан дараах графикт үзүүлэв.

Зураг 34. Ашиглалтын тусгай зөвшөөрөл (ашигт малтмалын төрлөөр, аймгаар)

Ашигт малтмалын төрлөөр:



Аймгаар:





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 34%-ийг алтны 537, 19%-ийг барилгын материалын 303, 19%-ийг нүүрсний 295, 11%-ийг хайлуур жоншны 167, 5%-ийг төмрийн хүдрийн 77 тусгай зөвшөөрөл тус тус эзэлж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг аймгаар нь ангилан авч үзвэл Төв аймагт хамгийн олон тусгай зөвшөөрөл олгогдсон бол Завхан, Орхон аймагт тус бүр 7 тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Онцлоход, 1992 оны 12 дугаар сарын 30-ны өдөр MV-000906 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг Уул уурхайн аврах ангид олгосон байдаг.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тоо, уулын ажлын төлөвлөгөө (УАТ) ирүүлсэн байдлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, УАТ ирүүлсэн байдал

Д/д	Нөхцөл	АТЗ-ийн тоо	ААН-ийн тоо
1.	Нийт тусгай зөвшөөрөл	1560	1020
2.	Төлөвлөгөө ирүүлсэн	408	348
3.	Үйл ажиллагаа явуулахгүй гэж албан бичгээр мэдэгдсэн	119	95
4.	АМГТГ-т мэдээ, тайлан ирүүлээгүй АТЗ-ийн тоо	1033	577

2016 онд нийт 1020 аж ахуйн нэгж давхардсан тоогоор 1560 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Үүнээс 408 ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр 348 аж ахуйн нэгж төлөвлөгөө ирүүлсэн бол 95 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахгүй гэж мэдэгджээ. 1033 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй 577 аж ахуйн нэгж уулын ажлын тайлан, төлөвлөгөө ирүүлээгүй. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, тайлан гаргах үүргээ биелүүлээгүйгээс энэхүү 1033 тусгай зөвшөөрөл хадгалалтын байдалтай байна.


2.3.2

УУЛЫН АЖЛЫН ТАЙЛАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар заалтын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн уулын ажлын тайлан, ирэх жилийн төлөвлөгөөгөө гаргах үүрэгтэй. Аж ахуйн нэгжээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тухайн жилийн Монгол Улсын төсвийн төсөөлөл, нөөц баялгийн нэгдсэн бүртгэл гаргадаг.

2012-2017 онд ирүүлсэн уулын ажлын тайлан, төлөвлөгөөг дараах зурагт үзүүлэв.

Зураг 35. Уулын ажлын тайлан, төлөвлөгөө ирүүлсэн байдал





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

2016 онд 348 аж ахуйн нэгж 408 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулахаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны 397 төлөвлөгөөг (үүнээс тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэр-12, тодотгол төлөвлөгөө-10) тус газарт ирүүлснээс 342 төлөвлөгөөг зөвшөөрсөн байна.

2.3.3

ТҮР ЗОГСОЛТТОЙ
БАЙГАА ҮЙЛДВЭР,
УУРХАЙН
СУДАЛГАА

Аж ахуйн нэгжүүдээс тус газарт ирүүлсэн 2016 оны уулын ажлын төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл зэрэгт боловсруулалт хийж, үйл ажиллагаа явуулахгүй байгаа үйлдвэр, уурхайн судалгаа гаргасан.

2016 онд нийт 123 үйлдвэр, уурхай үйл ажиллагаа явуулахгүйгээ мэдэгдсэн тайлбар бичиг ирүүлжээ. Эдгээрийг ашигт малтмалын төрлөөр нь ангилбал жоншны 34, алтны 27, төмрийн 17, гянтболдын 4 төсөл байна.

Хүснэгт 9. 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй үйлдвэр, уурхай

Ашигт малтмалын төрөл тоо		
Жонш	34	
Алт	27	
Төмөр	17	
Шохойн чулуу	5	
Гянтболд	4	
Дайрга	4	
Шавар	4	
Элс, хайрга	4	
Алт, Зэс	2	
Гантиг	2	
Өнгөт металл	2	
Хөнгөн цагаан	2	
Цагаан тугалга	2	
Элс	2	
Молибден, Зэс	1	
Алт, мөнгө	1	
Болор	1	
Боржин	1	
Галт уулын шаарга	1	
Зэс	1	
Магнезит	1	
Өнгөлөгөөний чулуу	1	
Полиметалл	1	
Төмөр, Цайр	1	
Ховор металл	1	
Цеолит	1	
Нийт	123	

2016 онд үйл ажиллагаа явуулахгүй болсон шалтгааныг авч үзвэл, хөрөнгө оруулалтаас болж зогссон 61, ТЭЗҮ, БОНБУ шинэчлэн боловсруулж байгаа 23, бүтээгдэхүүний үнийн уналт, зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж зогссон 21, гол мөрний урсацтай давхцалтай 8, шүүхийн маргаантай 5, орон нутгийн зөвшөөрөл хүлээгдэж байгаа 3, гүйцээх хайгуул хийгдэж байгаа 2 аж ахуйн нэгж байна.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Хүснэгт 10. 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан

Үндсэн шалтгаан	Тоо
Хөрөнгө оруулалт шаардлагатай	61
ТЭЗҮ, БОНБУ шинэчлэн боловсруулж байгаа	23
Бүтээгдэхүүний үнийн уналт, борлуулалт	21
Гол мөрний урсацтай давхцалтай	8
Шүүхийн маргаантай	5
Орон нутгийн зөвшөөрөл, бусад	3
Гүйцээх хайгуул хийгдэж байна	2
Нийт	123

2.3.4

АШИГЛАЛТАНД
БЭЛТГЭГДСЭН
ҮЙЛДВЭР, УУРХАЙН
МЭДЭЭЛЭЛ

2016 онд улсын комисст хүлээлгэн өгч, шинээр ашиглалтад орсон үйлдвэр, уурхайн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. 2016 онд шинээр ашиглалтад хүлээн авсан үйлдвэр, уурхайн мэдээлэл

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Ашигт малтмалын төрөл	Хүсэлт өгсөн огноо	Уурхайн хүчин чадал /мян.м³ болон кг/	Хөрөнгө оруулалт /сая төгрөг/	Шинэ ажлын байр
1	Ирмүүн босго ХХК	Сэлэнгэ аймаг Орхонтуул сум	Алт	2016.04.20	124.0	1550.0	31
2	Эм Жи Эл Ресурс ХХК	Төв аймгийн Заамар сум	Алт	2016.04.25	86.1	634.3	29
3	Тод Ундарга ХХК	Сэлэнгэ аймгийн Баянгол сум	Алт	2016.04.29	80.0	4300.0	65
4	Эрдэнийн цахирмаа тал ХХК	Төв аймаг Баян сум	Алт	2016.05.06	50.0	1056.0	35
5	Мэжик бридж ХХК	Дундговь аймаг Өлзийт сум	Жонш	2016.05.24	28.0 тн	1300.00	43
6	Идеал системс ХХК	Ховд аймгийн Мөст сум	Алт	2016.06.07	200.0	369.7	46
7	Эс Би Эф ХХК	Төв аймгийн Заамар сум	Алт	2016.06.08	80.0	1000.0	41
8	Пантатерра ХХК	Сэлэнгэ аймаг Баянгол сум	Алт	2016.06.09	76.7	1211.7	78
9	Алтандорнод Монгол ХХК	Төв аймаг Заамар сум	Алт	2016.05.30	67.5	1400.0	124
10	Уулс заамар ХХК	Төв аймаг Заамар сум	Алт	2016.06.13	150.0	6100.0	61
11	ЛМО Майнинг ХХК	Төв аймгийн Лүн сум	Алт	2016.06.16	100.0	1200.0	41
12	Алтан заамар ХХК	Төв аймаг Заамар, Булган, Бүрэгхангай	Алт	2016.07.19	1691.1	10380.0	116
13	Мираи флюорид ХХК	Дундговь аймаг Гурвансайхан	Жонш	2016.07.26	100.0 тн	446.00	100
14	Ориент Майнинг Инвестмент ХХК	Булган аймаг Бүрэгхангай	Алт	2016.07.25	100.0	3970.0	83
15	Шинэ Сансар ХХК	Баянхонгор аймаг Бөмбөгөр сум	Алт	2016.07.21	68.6	1000.0	32
16	Э-Транс ХХК	Төв аймгийн Баянцагаан сум	Шохойн чулуу	2016.07.20	1500.0 тн	1770.0	31
17	Дүншинхэние ХХК	Дорноговь аймаг Даланжаргалан	Жонш	2016.08.04	100.0 тн	800.00	100
18	Болор Шүр ХХК	Дорнод аймаг Баян-Уул сум	Алт	2016.08.04	40.0	2200.0	44
19	Эф Жи Пи Эм ХХК	Сүхбаатар аймаг Түмэнцогт сум	Жонш	2016.08.11	140.0 тн	1800.00	101
20	Өгөөж Баян Хангай ХХК	Сэлэнгэ аймаг Орхонтуул сум	Алт	2016.08.11	90.0	1560.0	53
21	Шинь шинь ХХК	Дорнод аймаг Дашбалбар сум	Холимог металл	2016.11.07	900.0 тн	212.2	738

2016 онд нийт 47 үйлдвэр, уурхайгаас улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлснээс 21 аж ахуйн нэгжийн уурхайд комисс ажиллаж хүлээн авсан. Эдгээрийн дийлэнх хувийг алтны уурхай эзэлж байгаа бөгөөд нийт 15 алтны уурхай хүлээн авсан байна.

2016 онд уул уурхайн салбарт 1992 ажлын байр шинээр бий болсноос гадна 44.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

2.3.5

УУЛ УУРХАЙН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
МЭДЭЭЛЭЛ



Алт

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 онд батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй буурсан билээ. Засгийн газраас алтны олборлолтыг дэмжиж хууль эрхзүй, татварын таатай нөхцөл бүрдүүлснээр 2013 оноос үйлдвэрлэл өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид ч алт олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, 2016 онд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол банкны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж, 2017 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын алт олборлолтын хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Алт олборлолтын хэмжээ, нийт борлуулалт*

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ	тн	4.39	4.33	7.243	7.537	12.59	18.51
Борлуулалтын орлого	тэрбум.төг	223.1	387.7	504.1	552.7	430.1	1244.0
Үнэ	доллар/унц	1568	1668	1411	1271	1160	1257

Эх сурвалж: Эх сурвалж: Монголбанк

Зэсийн баяжмал

Монгол Улсад Эрдэнэт үйлдвэр болон Оюутолгойн баяжуулах үйлдвэрт хүдэр боловсруулан, зэсийн баяжмал үйлдвэрлэн экспортод гаргаж байна. Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн хүчин чадал болон экспортын хэмжээ харьцангуй тогтмол явж ирсэн бөгөөд цаашид ч тогтмол хэвээр байх төлөвтэй байна.

Хүснэгт 13. Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмал үйлдвэрлэл**

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Зэсийн баяжмал	мян.тн	516.09	517.78	520	516.81	546.19	657.35
Борлуулалтын орлого	тэрбум.төг	1233.7	1195.8	1183.4	1324.4	1035.4	
Үнэ	доллар/тн	1568.2	1668.8	1411.0	1271.2	1160.1	
Зэсийн үнэ	доллар/тн	8859	7952	7332	6863	5510	4790

* www.mongolbank.mn

** www.customs.gov.mn



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Оюутолгойн үйлдвэр 2014 оноос бүтээгдэхүүнээ экспортолж эхэлсэн бөгөөд 2016 оны байдлаар суурилагдсан хүчин чадалдаа бүрэн хүрсэн. Далд уурхайн бүтээн байгуулалтыг төлөвлөгөөт хугацаандаа дуусган ашиглалтад оруулж чадвал ойрын жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээг тогтмол байлгах нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 14. Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн зэсийн баяжмал үйлдвэрлэл

Үзүүлэлт	нэгж	2013 он	2014 он	2015 он	2016 он
Зэсийн баяжмал	мян.тн		734.35	814.2	904.64
Баяжмал дахь алт	кг			736.64	848.0
Баяжмал дахь мөнгө	кг			1157.7	1200.0
Борлуулалтын орлого	тэрбум.төг	92.33	3155.8	3218	
Үнэ	доллар/тн	3383.8	3048.6	2782.1	

Төмрийн хүдэр

Монгол Улсад ашиглалтад бэлтгэгдсэн төмрийн хүдрийн уурхайн олборлолтын хүчин чадал жилдээ 11.5 сая.тн. Гэсэн хэдий ч гадаад зах зээлийн нөхцөл байдал, үнэ ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор олборлолт болон экспортын хэмжээ 65%-иас хэтрээгүй байна.

Хүснэгт 15. Төмрийн хүдрийн олборлолт

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016он
Үйлдвэрлэлийн хэмжээ*	мян.тн	4663.3	6382.1	6793.3	7557.8	6061.2	6084.78
Борлуулалтын орлого	тэрбум.төг	292.96	456.75	460.28	643.95	327.8	
Үнэ (58%)	доллар/тн	167.5	128.4	125	93.1	49.8	42.4



Хайлуур жонш

Манай орны жонш нь ОХУ, БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл болон бусад салбарт худалдаалагддаг. Өнгөрсөн жилүүдэд, ялангуяа 2011-2013 онд зах зээлийн нөхцөл ихээхэн таатай байсан тул олборлолт болон боловсруулах үйлдвэрүүд олноор ашиглалтад орж, жилдээ 400 орчим мян.тн-ыг олборлож байв. Гэвч ойрын ирээдүйд зах зээлийн нөхцөл сайжрахгүй төлөвтэй тул олборлолтын хэмжээ өсөх магадлал бага байна.

Хүснэгт 16. Жоншны үйлдвэрлэл

	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ фф	мян.тн	50.8	98.8	57.2	61	51.6	80
Үйлдвэрлэлийн хэмжээ фк	мян.тн	200.2	278.1	82	117.6	55.8	100
Борлуулалтын орлого	тэрбум.төг	26.83	63.64	51.15	58.38	41.18	
Үнэ ФФ-97	доллар/тн	529.4	456.3	349.4	305.7	283.3	257
Үнэ ФК-85	доллар/тн	352.2	365.7	294	240	244.3	238



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Гянтболд, молибден, цайр, цагаан тугалга

Хар тугалга, цайрын хам баяжмалын экспортын мэдээнээс харахад борлуулалт тогтворгүй бөгөөд хэт бага хэмжээнд байна. 2014 онд 1.7 мян тонн, 2016 онд мөн 1.7 мян.тн-ыг экспортолсон үзүүлэлттэй гарчээ. Үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал жилдээ 20 мян.тн-д хүрч үйлдвэрлэлийн хэмжээг өсгөвөл эдийн засагт тодорхой хэмжээнд нөлөө үзүүлэх боломж бүрдэхээр байна.

Хүснэгт 17. Гянтболдын олборлолт, борлуулалт

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	0.20	0.13	0.53	1.08	0.68	1.46
Борлуулалтын орлого	тэрбум.төг	0.669	2.325	9.47	20.09	11.59	
Үнэ	доллар/тн	59349	55349	57274	50970	36080	32408
Гянтболдын баяжмалын үнэ, 65%	доллар/тн					11651	10545

Хүснэгт 18. Молибдений баяжмал үйлдвэрлэл

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	3.15	3.93	3.67	4.05	5.53	5.78
Үнэ	доллар/тн	34457	28037	22583	25203	14618	14103

Хүснэгт 19. Цайрын баяжмал үйлдвэрлэл

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ	мян.тн	105.85	118.02	103.53	93.10	89.60	126.04
Борлуулалтын орлого	тэрбум.төг	88.184	108.6	105.6	121.98	102.1	
Үнэ	доллар/тн	2198.90	1947.7	1910	2161	1928	2038

Хүснэгт 20. Цагаан тугалганы баяжмал үйлдвэрлэл

Үзүүлэлт	нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үйлдвэрлэлийн хэмжээ	тн	54.80	98.59	16.50	99.80	82.31	50.23
Борлуулалтын орлого	сая.төг	898.1	1375.5	878.5	1989.9	91.17	
Үнэ	доллар/тн	26183	21112	22309	21909	16079	17676




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Нүүрс

Монгол Улсын хэмжээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар **37.4** тэрбум тонн нүүрс улсын нөөцийн бүртгэлд бүртгэгдэж, нийт 171 аж ахуйн нэгж **296** ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

2016 онд Монгол Улс **35,096.5** мян.тн нүүрс олборлож, **33,831.7** мян.тн-ыг борлуулснаас **25,809.3** мян.тн нүүрс экспортод гаргажээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад олборлолт **146.4%**, борлуулалт **152.9%**, экспорт **178.4%** болж өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 36. Нүүрс олборлолт, борлуулалт, экспорт



Нүүрсний уурхайн болон баяжуулах
үйлдвэрийн үйл ажиллагааны
тайлангийн баталгаажсан байдал
/2013-2016/

Хүснэгт 21.

Он	2013	2014	2015	2016
Ирүүлсэн	40	48	40	52
Зөвшөөрсөн	35	40	33	49


Нүүрсний уурхайн болон баяжуулах
үйлдвэрийн үйл ажиллагааны
төлөвлөгөөний баталгаажсан
байдал /2013-2016/

Хүснэгт 22.

Он	2013	2014	2015	2016	2017
Ирүүлсэн	55	58	67	52	47
Зөвшөөрсөн	48	52	58	49	

Зураг 37. Нүүрсний салбараас улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого**
/2013-2015 он, 2016-2020 оны төсөөлөл/

/тэрбум төгрөг/



Тайлбар: Дээрх мэдээллийг нүүрсний орд ашиглах техник эдийн засгийн үндэслэлд тусгаж батлуулсан мэдээлэлд үндэслэн гаргав.


2016* -Хүлээгдэж байгаа гүйцэтгэл

** www.mram.gov.mn

Зураг 38. Нүүрсний салбарын хөрөнгө оруулалт

/2013-2015 он, 2016-2020 оны төсөөлөл/

/тэрбум төгрөг/



2016* -Хүлээгдэж байгаа гүйцэтгэл



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

2.3.6

УУЛ УУРХАЙН
ГАРАЛТАЙ
ЭКСПОРТЫН
ГОЛЛОХ АШИГТ
МАЛТМАЛЫН
БҮТЭЭГДЭХҮҮН
ГАРГАЛТЫН
МЭДЭЭ

Хүснэгт 23. 2016 оны төлөвлөлт ба гүйцэтгэл, бүтээгдэхүүн гаргалтын мэдээ

/2016.12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

№	Ашигт малтмалын төрөл		2016 оны төлөвлөлт				2016 оны гүйцэтгэл*		Экспортын мэдээ (ГЕГ-ын 12 дугаар сарын мэдээнд тулгуурлав)	Төлөвлөлттэй харьцуулсан гүйцэтгэлийн хувь (12.01 байдлаар тооцсон)
			Хүдэр, элс		Бүтээгдэхүүн гаргалт		Бүтээгдэхүүн гаргалт			
			Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга		
1	Гянтболд		---	---	тн	1,216.3	тн	985.77	1,466.47	81
2	Зэс (катод)		мян.тн	17,289.0	тн	1,910.0	тн	2080.36	15,890.63	109
3	Зэс (баяжмал)		мян.тн	68,600.0	мян.тн	1,375.6	мян.тн	1,561.99	1,561.99	114
4	Манган		мян.тн	858.1	мян.тн	262.9	мян.тн	28.76	28.76	11
5	Молибден (баяжмал)		мян.тн	30,600.0	мян.тн	3.8	мян.тн	5.39	5.78	142
6	Мөнгө		мян.тн	300.0	тн	41,400.0 (баяжмал)	тн	94,840 (хүдэр)	94,840 (хүдэр)	32
7	Мөнгө (металлаар)*		---	---	кг	9,576.8	кг	1,920.25	1,920.25	20
8	Төмөр		мян.тн	22,692.2	мян.тн	12,234.6	мян.тн	5,571.93	6,084.78	46
9	Уран		мян.тн	26.5	мян.тн	2.83	мян.тн	0	0	0
10	Хайлуур жонш (хүдэр, баяжмал)	ФР-13-45	мян.тн	1,975.8	мян.тн	246.5	мян.тн	140.86	248.87	---
		ФК-65	мян.тн			9.3				---
		ФК-75	мян.тн			129.7				---
		ФК-85	мян.тн			61.1				---
		ФК-92	мян.тн			78.4				---
		ФФ-95-97	мян.тн			185.0				---
		НИЙТ	мян.тн	1,975.8	мян.тн	709.9	мян.тн	140.86	248.87	20
11	Хар тугалга (баяжмал)		мян.тн	670.0	мян.тн	15.0	мян.тн	10.04	10.04	67
12	Цагаан тугалга (баяжмал)		мян.м³	743.0	тн	411.5	тн	32.20	50.23	8
13	Цайр (баяжмал)		мян.тн	1,005.4	мян.тн	113.4	мян.тн	126.04	126.04	111

Жич: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн экспортолсон (Нүүрс алтнаас бусад) 78 аж ахуйн нэгж байгаагаас АМГТГ-т АМАҮАТөлөвлөгөөгөө ирүүлж, зөвшөөрүүлсэн 35 аж ахуйн нэгж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй боловч төлөвлөгөө ирүүлж, зөвшөөрөөгүй 21 ААН байна. Мөн ямар нэг тусгай зөвшөөрөлгүй 20 ААН бүтээгдэхүүн экспортолсон байна.

* 2016 оны төлөвлөгөө ирүүлсэн ААН-үүдийн гүйцэтгэлийг Гаалийн ерөнхий газрын 2017.01.01-ний өдрийн экспортын мэдээнд тулгуурлан гаргав.


2.3.7

УУЛ УУРХАЙН
САЛБАРЫН ОРОН
НУТАГТ ТӨЛСӨН
ТАТВАР, ТӨЛБӨР,
НӨХӨН СЭРГЭЭЛТ




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээс улс орон нутгийн төсөвт эхний 11 сарын байдлаар нийт 638.7 тэрбум төгрөгийн орлого оруулжээ.



ААНОАТ	34%
НДШ, ЭМДШ	9%
бусад	7.00%
УНАТ	5.00%
НӨАТ	2.90%
ҮХХТ	2.50%
АБТ	2.30%
ГТ	1.70%
ХАОАТ	0.60%
АӨЯХТ	0.2%
АМНАТ	35.10%



төмөр	2.2%
барилгын материал	1.2%
хар тугалга	0.80%
жонш	0.70%
газрын тос	0.60%
хөнгөн цагаан	0.20%
гянтболд	0.10%
бусад	0.10%
уран	0.1%
молибден	0%
зэс	65.10%
нүүрс	17.90%
алт	6.30%
цайр	4.60%

Уулын үйлдвэрүүдээс зэсийн баяжмал үйлдвэрлэгчид 415.8 тэрбум төгрөг, нүүрс олборлогчид 114.2 тэрбум төгрөг, алт олборлогчид 40.3 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт оруулснаараа тэргүүлсэн байна. Татварын төрлөөр авч үзвэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 224 тэрбум төгрөг, орлогын албан татвар 213.7 тэрбум төгрөг байгаа нь дийлэнх хэсгийг бүрдүүлжээ.

2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 3834 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 13.95 сая га талбайд үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан нь нийт нутаг дэвсгэрийн 8.47 хувийг эзэлж байна. Үүнээс 1.4 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.9%-ийг ашиглалтын 1572 тусгай зөвшөөрөл, 12.54 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 8.01%-ийг хайгуулын 2262 тусгай зөвшөөрөл эзэлжээ. Эдгээрээс 342 аж ахуйн нэгж байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

2015 оны үйл ажиллагааны тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээллээр уул уурхайн олборлолтын улмаас шинээр эвдрэлд орсон газрын хэмжээ 590 га бөгөөд 483 га-д техникийн нөхөн сэргээлт, 387 га-д биологийн нөхөн сэргээлт тус тус хийгджээ. 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээллээр уул уурхайн олборлолтын улмаас шинээр эвдрэлд орох газрын хэмжээ 1124 га байх бөгөөд техникийн нөхөн сэргээлтийг 894 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 483 га-д тус тус хийхээр тусгасан байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 27.9 мянган га талбай уулын ажилд хамрагдаад байна. Үүнээс техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай 75% буюу 20.8 мянган га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 29% буюу 7.9 мянган га байна. Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал 97.42 тэрбум төгрөг, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал 60.74 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 24. Уулын ажилд хамрагдсан болон нөхөн сэргээсэн талбайн хэмжээ, зардал

№	Үзүүлэлт	Өмнөх онуудад	2015 он гүйцэтгэл	2016 он төлөвлөгөө	НИЙТ
1	Уулын ажилд хамрагдсан талбай /га/	26198	590	1124	27912
2	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай /га/	19316	571	960	20846
3	Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал /сая.төг/	88859	334	5212	97420
4	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	10786	483	894	12163
5	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	7103	387	483	7973
6	БОХ зардал / сая.төг/	52957	3885	3895	60737



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Ажиллах хүчин, ХАБЭА-н талаарх мэдээлэл

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээллээр нийт 25392 хүн ажиллаж байна. Үүнээс 2933 монгол, 119 гадаад инженер техникийн ажилтан, 4083 монгол, 39 гадаад мэргэжлийн ажилтан, 4441 монгол, 536 гадаад эмэгтэй ажилтан байна.


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд нийт 34349.4 сая төгрөг төсөвлөгджээ. Үүнээс 16292.4 сая төгрөг нь хамгаалах хувцас, хэрэгсэлд, 3795.94 сая төгрөг эрүүл ахуйн зардалд хамаарч байна

2.3.8

УУЛ УУРХАЙН
САЛБАРЫН
НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСАГТ ЭЗЛЭХ
БАЙР СУУРЬ

2016 онд Монгол улсын ДНБ-ий 17 орчим хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бөгөөд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 71% буюу 6.2 их наяд төгрөгийн үйлдвэрлэл явуулжээ.


Зураг 39. Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөө



Улсын хилээр оны эхнээс 11 сар дуусталх хугацаанд 3.7 тэрбум ам.долларын үнэлгээ бүхий уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн экспортод гарсан нь нийт экспортын 87%-ийг эзэлж байна.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



2.3.9

УУЛ УУРХАЙН
САЛБАР ДАХЬ
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

Уул уурхайн салбарт 2016 онд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр хийгдсэн гол ажлууд

- Хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр болон сонгон шалгаруулалтаар олгох ажил үргэлжлэн хэрэгжив.
- Геологи, хайгуул, уул уурхайн үйл ажиллагаанд орон нутгаас дэмжлэг авах зорилгоор Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан нь 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэв. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг орон нутагт хуваарилах тухай хуулийн өөрчлөлтийг орон нутагт сурталчилж ажиллав.
- Алтны олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын үр дүнд алт тушаалт нэмэгдэв.
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулснаар зогсоод байсан төслүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж эхлэв.
- Цөмийн энергийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу “Арева майнс” ХХК-ийн Зөөвч-Овоо, Дулаан-Уул, “Гурвансайхан” ХХК-ийн Хайрхан, Хараат, Гурвансайхан, Өлзийтийн ураны ордуудыг ашиглах “Орд ашиглах гэрээ”-г АМГТГ байгуулж, Монгол Улсад анх удаа цацраг идэвхт ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад бэлэн болгов.
- “Сентерра гоулд” ХХК-ийн Гацууртын алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар “Орд ашиглах гэрээ” байгуулахаар ажиллаж байна.

2.4


ГАЗРЫН ТОСНЫ
АШИГЛАЛТ,
ОЛБОРЛОЛТ

2.4.1

ГАЗРЫН ТОСНЫ
ГЭРЭЭЛЭЛТ

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 32 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар 25 талбайд 21 гэрээлэгч БХГ байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна.

Зураг 40. Газрын тосны гэрээлэлт хийсэн, олборлолт явуулж байгаа талбайн мэдээлэл



Эдгээрээс Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, БХГ-97 талбайд “Доншен газрын тос (Монгол)” ХХК тус тус газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 35. Газрын тосны олборлолт явуулж байгаа компани, талбайн мэдээлэл

№	Ашиглалтын талбайн нэр	Гэрээлэгч компани	Гэрээ байгуулсан огноо
1	Тосон-Уул ХИХ	Петрочайна Дачин Тамсаг ХХК	1993.04.26
2	Тамсаг-ХХИ		1995.12.11
3	БХГ-97	Доншен газрын тос Монгол ХХК	1997.01.24

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК:

Хятадын Үндэсний газрын тосны корпорацийн харьяа төрийн өмчит “Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь 2005 оны 8 дугаар сард Тамсагийн сав газрын ХИХ, ХХИ, ХХII гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх үүргийг АНУ-ын “СОКО Интернейшнл” ХХК-иас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг Монгол Улсад байгуулан Дорнод аймгийн Халх гол, Матад сумдын нутагт орших Тосон-Уул ХИХ, Тамсаг ХХИ талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

“Доншен газрын тос Монгол” ХХК:

БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Девелопмент Групп Сток” компани нь Монгол Улсын Засгийн газрын 1997.02.19-ний өдрийн 47 тоот тогтоолоор 2003 оны 2 дугаар сарын 15-нд батлагдсан БХГ-ний эрх, үүргийг Австралийн “Рок Ойл (Говь)” компаниас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийг Монгол Улсад байгуулан, Дорноговь аймгийн нутагт орших 1997 оны БХГ-т талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2.4.2


ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, НӨӨЦ

(Ашиглалтын 3 талбайд)



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Зураг 41. Газрын тосны хайгуул, нөөц



“Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК нь (1993-2015 онд) хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1431 цооног (Тосон-Уул XIX талбайд 848 цооног, Тамсаг XXI талбайд 459 цооног, БХГ-97 талбайд 124) өрөмдөн, 12,78 мянган тууш км хоёр хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 4,37 мянган тууш км, Тамсаг XXI талбайд 3,27 мянган тууш км, БХГ-97 талбайд 5,14 мянган тууш км), 5,33 мянган км² гурван хэмжээст (Тосон-Уул XIX талбайд 2,32 мянган км², Тамсаг XXI талбайд 2,67 мянган км², БХГ-97 талбайд 339,6 км²) чичирхийллийн судалгаа хийсэн.

ЭБМЗ-өөр 2011 онд Тосон-Уул XIX талбайн газрын тосны нөөцийн тооцооны нэмэлт тайланг дахин хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 06 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 148 дугаар тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 60,06 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 6,50 сая тонноор нэмж, Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэснээр дээрх талбайн нийт газрын тосны “баталгаат” нөөц 179,08 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөц 20,17 сая тонн гэж бүртгэгджээ.

Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/12 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 127,509 сая тн, үүнээс байгалийн горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 14,01 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 21,018 сая тонноор Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн.

БХГ-97 талбайн газрын тосны нөөцийг 26,05 сая тонн буюу 186,3 сая баррель; үүнээс “ашиглалтын баталгаат” нөөцийг 2,07 сая тонн буюу 14,86 сая баррелиар тус тус тогтоосон ба уг нөөцийн тооцооны тайланг ЭБЭХ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, тус зөвлөлийн 2010.04.18-ны өдрийн 03 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын “Нөөц бүртгэх тухай” 2011.06.08-ны өдрийн 137 дугаар тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.



1.7

1.6

2.3

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


2.4.3

ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ



Монгол Улсын хэмжээнд 1996-2015 оны хооронд нийт 35,5 сая баррель буюу 4,8 сая тонн тос олборлож, 33,58 сая баррель буюу 4,50 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортолж, газрын тосны орлогоос нийт 952,9 тэрбум төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлжээ. Үүнээс зөвхөн 2015 онд 8,7 сая баррель буюу 1,1 сая тонн газрын тос олборлож, 8,2 сая баррель буюу 1 сая тонн газрын тос экспортолж, Улсын төсөвт 160,6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Зураг 42. Газрын тосны олборлолт, экспорт, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого



Тосон-Уул XIX талбайн 456 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулснаас хонгогт дунджаар 381 цооногоор 10192 баррель буюу 1350 тонн газрын тос олборлож, 10034 баррель буюу 1333 тонн түүхий тосыг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомтоор БНХАУ-д экспортолж байна.

Тамсаг-XXI талбайд 229 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулснаас хонгогт дунджаар 218 цооногоор 12054 баррель буюу 1600 тонн газрын тос олборлож, 13636 баррель буюу 1885 тонн түүхий тосыг Дорнод аймгийн Халхгол сумын Баянхошууны боомтоор БНХАУ-д экспортолж байна.

БХГ-97 талбайн 106 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан ба үүнээс 103 цооногоос хонгогт дунджаар 948 баррель буюу 133 тонн газрын тос олборлож, 7 хонгогт 1 удаа 21 вагон цистернээр ойролцоогоор 8535 баррель буюу 1170 тонн түүхий тосыг Дорноговь аймгийн Замын-Үүдийн боомтоор БНХАУ-д экспортолж байна.

Монгол Улсын хэмжээнд 2016 онд нийт 9.92 сая баррель буюу 1.36 сая тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2016.01.01-2016.11.30-ны хооронд нийт 7,518,013 баррель буюу 1,019,737 тонн газрын тос олборлож, 7,359,270 баррель буюу 999,028 тонн түүхий тос БНХАУ-д экспортолж, Улсын төсөвт 92.3 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Зураг 43. 2016 онд олборлосон болон экспортолсон газрын тосны хэмжээ
/мян.баррель/

2016 оны газрын тосны олборлолт, экспорт



2.4.4

УЛС ОРОН НУТАГТ
ТӨЛСӨН ТАТВАР,
ТӨЛБӨР, ШИМТГЭЛ,
ХУРААМЖ

Газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК-иуд нь 1993-2015 оны хооронд нийт 3.41 сая ам.долларын татвар төлж, 54.31 сая ам.долларын нөөц ашигласны төлбөр хийсэн байна.

Хүснэгт 26. Газрын тосны улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, шимтгэл, хураамж*

Үзүүлэлт	Огноо	Тосон-Уул XIX	Тамсаг XXI	БХГ-97	Нийт
Нөөц ашигласны төлбөр (сая ам.доллар)	1993-2015	0	29.61	24.7	54.31
	2016 оны төлөвлөгөө	0	15.88	1.49	17.37
Татвар, төлбөр (сая ам.доллар)	1993-2015	1.99	0.69	0.73	3.41

* www.mram.gov.mn

2.4.5

ГАЗРЫН ТОСНЫ
САЛБАРТ
ХИЙГДСЭН
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК-иуд нь 1993-2015 оны хооронд нийт 2.83 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 2016 онд 441.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 27. Газрын тосны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Огноо	Тосон-Уул XIX	Тамсаг XXI	БХГ-97	Нийт
Хөрөнгө оруулалт (сая ам.доллар)	1993-2015	1795.4	742.87	291.41	2829.68
	2016 оны төлөвлөгөө	173.9	251	17	441.9


2.5

МОНГОЛ УЛСЫН
ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ХЭРЭГЛЭЭ,
ИМПОРТ

Өнөөгийн байдлаар Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байна.

Зураг 44. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний импорт

Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ,
хэтийн төлөв /МЯН.ТОНН/



Автобензин, дизелийн түлшний импорт 2006-2013 он хүртэл хугацаанд жилд дунджаар 10 хувиар өсч ирсэн ч сүүлийн 2 жилд эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан буурсан үзүүлэлттэй байна. Шатахууны импортын хэмжээг төрлөөр нь авч үзвэл сүүлийн арван жилд А-80 автобензин тогтмол буурч байгаа бол Аи-92 автобензиний импорт тогтмол өсч байна. Харин дизелийн түлшний импорт уурхайнуудын үйл ажиллагаатай уялдан тогтворгүй, хэлбэлзэлтэй байгаа боловч урт хугацаанд өсөх хандлагатай байна.



Зураг 45. 2016 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүн


2016 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүн

/нэр төрлөөр, нийлүүлэгчээр/

төрлөөр



улсаар



Газрын тосны бүтээгдэхүүний импортыг бүтцээр нь авч үзвэл 90-ээс дээш октантай автобензин 27%, 90-ээс доош октантай автобензин 4 орчим хувь, дизель түлш 50%, онгоцны түлш 2%, бусад /тос тосолгооны материал, мазут, хий / 17%-ийг эзэлж байна. Нийт импортын 93 гаруй хувийг ОХУ, 4.6 орчим хувийг БНСУ, 2 хувийг БНХАУ, үлдсэнийг бусад улсаас импортолж байна.

Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ сүүлийн таван жилд 66%-иар өссөн бол тээврийн хэрэгслийн оношилгоонд хамрагдсан нийт автомашины тоо 53%-иар өсчээ.


Хүснэгт 28. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, автомашины тоо

Үзүүлэлт/он	2010	2011	2012	2013	2014	2015	Нийт өсөлт
Нийт хэрэглээ	650,299	798,252	871,974	989,588	1,046,193	980,373	+66%
Автотээврийн хэрэгслийн тоо	254,486	312,542	345,473	384,864	437,677	482,049	+53%

Монгол Улсад дунджаар 1 автотээврийн хэрэгсэл нэмэгдэхэд шатахууны хэрэглээ 1.8 тонн буюу өдөрт 6 литр шатахууны хэрэглээ нэмэгдэхээр тооцоо гарч байна.

Манай улсын хувьд автобензиний хэрэглээний дийлэнхийг жижиг тэрэг, нийт тээврийн хэрэгсэл эзэлдгээс хувийн хэрэглээ зонхилдог. Харин дизелийн түлшний хэрэглээний дийлэнхийг ачаа тээвэр, уул уурхайн машин механизм зэрэг хүчин чадал ихтэй техник хэрэгслүүд эзэлж байна. Дизелийн түлшний хэрэглээнд нөлөөлж буй голлох хүчин зүйлст бөөний борлуулалт буюу уул уурхай, төмөр замын салбар, жижиглэнгийн борлуулалт буюу автозамын тээвэр, хувийн хэрэглээ багтдаг.

Дизелийн түлшний борлуулалт



Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ туршилтын лабораторийн үйл ажиллагаа

Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол улсад мөрдөж буй стандартын дагуу чанарын өндөр түвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулан үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 46. Газрын тосны бүтээгдэхүүний төв лаборатори



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Газрын тосны бүтээгдэхүүн нь онцгой шатамхай шингэн тул барилгын норм, дүрэмд заагдсан нөхцөл шаардлагын дагуу галд тэсвэрлэлтийн 2 дугаар зэрэгт хамаарах зориулалтын лабораторийн барилгыг улсын төсвийн хөрөнгөөр бариулж 2013 онд ашиглалтад хүлээн авсан. Тус лаборатори нь цэвэр, бохир шинжилгээний үндсэн хоёр өрөөнд нийт 40 нэр төрлийн 70 гаруй багаж тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулан шалгалт тохируулгыг хийсэн. Газрын тосны бүтээгдэхүүн, тос тосолгооны материалд иж бүрэн шинжилгээ хийх хүчин чадалтай.

Зураг 47. Уул уурхайн шинжилгээ, туршилтын лаборатори



Уул уурхайн шинжилгээ туршилтын лабораторийн тусгай зориулалтын 1268,31 мкв барилгыг улсын төсвийн хөрөнгөөр бариулсан. Тус лаборатори нь хатуу түлшний 93, хөрс усны 50 гаруй, нийт 140 гаруй тоног төхөөрөмж угсарч, суурилуулан шалгалт тохируулгыг хийсэн. Хөрс, усны бохирдол, шатах ашигт малтмалын физик, химийн найрлага, механик, дулааны шинж чанарыг тодорхойлох хүчин чадалтай "Олон улсын итгэмжлэлийн эрх"-тэй лаборатори юм.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



2.6

ХҮНД ҮЙЛДВЭР


Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хүнд үйлдвэрийн салбарын эзлэх хувь, ач холбогдол, бусад салбарт үзүүлэх хүчин зүйлс байнга нэмэгдсээр байна. Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа манай улсын хувьд уул уурхайн гаралтай эрдэс түүхий эдээр нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засаг, нийгмийн хөгжилд эрс өсөлт бий болгох боломжтой юм.

2.6.1

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад 1998 онд Техник, технологийн хууль батлагдсанаас хойш хүнд үйлдвэрийн салбар төрийн захиргааны төв байгууллагын харьяа нэгж хэсэг болох нөхцөл бүрдсэн юм. 2014 онд аж үйлдвэрийн салбарын бие даасан яамтай болсон. Аж үйлдвэрийн яам байгуулагдсанаар аж үйлдвэр, тэр дундаа хүнд үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлогыг УИХ-аар батлуулсан билээ.


Зураг 48. Хүнд үйлдвэрийн салбарын хууль эрхзүйн орчин





Хүнд үйлдвэрийн бодлогын баримт бичгүүдэд импортыг орлохуйц, экспортыг дэмжсэн үйлдвэрлэл хөгжүүлэхэд татварын болоод бусад төрлийн дэмжлэг төрөөс үзүүлэхээр тусгасан билээ. Үүний зэрэгцээ дотоодод үйлдвэрлэж байгаа зэс, төмөр, цемент зэрэг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг импортын ижил төрлийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц байлгах хэрэгтэй байна. Манай улсын нийт үйлдвэрлэлийн дийлэнх нь уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан, хялбар технологид суурилсан бөгөөд экспортын бүтээгдэхүүний 81.9%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн, үүнээс 97%-ийг технологийн багтаамжгүй болон нам технологит бүтээгдэхүүн эзэлж байгааг дараах зурагт үзүүлэв.

Зураг 49. Экспортын бүтээгдэхүүний технологийн агууламж хувиар



Эх сурвалж: Аж үйлдвэрийн яамнаас гаргасан "Үйлдвэржилт" сэтгүүл

Монгол Улсын хүнд үйлдвэрийн салбар ДНБ-ий 5%-ийг үйлдвэрлэж байна. Тус салбар дэлхийн эдийн засгийн хямрал, эрдэс баялгийн түүхий эдийн үнийн уналт, Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашралтаас шууд хамааралтай байна. Үйлдвэржилтийн хөгжлийн эцсийн шатанд хүрсэн Япон, Солонгос, АНУ, Тайвань тэргүүтэй хөгжингүй орнууд өнөөдөр хөгжлийн шинэ үе шат болох инновацид суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлж явна. Монгол улс хөгжлийн энэхүү өндөрлөгт хүрэхэд нөөц баялаг, боломж хангалттай байгааг эрдэмтэн судлаачид хэлж сануулсаар байна.


Монгол улсын бизнесийн орчин хийгээд үйлдвэржилтийн талаар олон улсын байгууллагуудын судалгааны дүн тааруу үзүүлэлттэй гарч байгаа. Үүнийг сайжруулахад төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо туйлаас чухал юм. Дэлхийн эдийн засгийн форумын тайланд дурдсанаар Монгол Улсын өрсөлдөх чадвар 133 орноос 109 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Нийт боловсруулах үйлдвэрлэлд нам технологи дөнгөж 5,3%-ийг эзэлж байгаа нь ОХУ-аас 4 дахин, БНХАУ-аас 8 дахин доогуур байна.

Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүд нь боловсруулах салбараас бүтээлч соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүртэл өргөн цар хүрээтэй асуудлыг хамарсан юм. Бодлого, шийдвэр хэрэгжсэнээр ДНБ-д үзүүлж байгаа боловсруулах үйлдвэрийн дэмжлэг сайжирч, хүнд үйлдвэрийн салбарын бүтээмж өснө. Мөн боловсруулах үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь хоёр дахин нэмэгдэнэ гэсэн тооцоолол бий. Үүнээс уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 29.5 хувийг эзэлж байна.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 50. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Боловсруулах үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, дулаан хангамжийг оролцуулсан аж үйлдвэрийн салбар ДНБ-ий 30 гаруй хувийг эзэлдэг. Энэ хувь хэмжээг өсгөн нэмэгдүүлж аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, тэр дундаа уул уурхайн боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн, технологи шингэсэн бүтээгдэхүүн гаргах чиглэлээр хөгжүүлэх бодлого тодорхой байх ёстой. Тиймээс Аж үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх судалгаа, шинжилгээ, үнэлгээний өргөн цар хүрээтэй ажлыг тогтмол хийж байна.

Хүснэгт 29. Хүнд үйлдвэрийн салбар дахь гол нэр төрлийн боловсруулах үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Нэгж	2016 оны хагас жилээр
Катодын зэс 99%	тн	7,284,611.00
Металл бэлдэц	Мян.тн	7,623.2
Металл цувимал	Мян.тн	8,511.29
Цахилгаан дамжуулах утас	тн	29.62
Цемент	Мян.тн	68.7
Шохой	мян.тн	6.30

Эх сурвалж: "Статистикийн мэдээллийн нэгдсэн сан".

Хүснэгт 30. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл

Аж үйлдвэрийн салбар	Нэгж	2015	2016	Дундаж өсөлт
		8-р сарын байдлаар	8-р сарын байдлаар	
Уул уурхай, олборлох үйлдвэрлэл	Тэрбум. төгрөг	5 589.7	5 931.8	-6.1%
Боловсруулах аж үйлдвэр	Тэрбум. төгрөг	3 726.7	4,122.5	+10.6
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	тн	-	9,6	-

Эх сурвалж: "Статистикийн мэдээллийн нэгдсэн сан"

Хүснэгт 31. Хүнд үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт

Бүтээгдэхүүн	Нэгж	2016 оны хагас жилээр
Катодын зэс, 99.9%	тн	7,284,611.00
Төмөр	сая төг	13,719.20
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	Кг	8,511.29
Газрын тосны бүтээгдэхүүн	Тн	-
Химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Сая төг	3,719.0
Цемент үйлдвэрлэл	тн	-

Эх сурвалж: "Статистикийн мэдээллийн нэгдсэн сан"



Дунд болон урт хугацааны төрийн тодорхой бодлого, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэл идэвхжиж, нийгмийн уур амьсгалд дотоодын бараа бүтээгдэхүүнээ ашиглах, хэрэглэх дадал хэвших хандлага бий болж эхэлж байна. Өнгөрсөн хугацаанд аж үйлдвэрийн салбарын хэмжээнд 2.3 тэрбум ам.доллар буюу 4.6 их наяд төгрөгийн 4 төсөл хэрэгжиж байгаагаас 3 нь хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа юм. Үндэсний хөрөнгө оруулагчдын оруулсан бодит хөрөнгө оруулалт 2015 оны байдлаар 963.1 сая.ам доллар буюу 1.9 их наяд төгрөгт хүрчээ.

Хүснэгт 32. Монгол улсын бүтээгдэхүүний гадаад зах зээлийн орчин

Үйлдвэрлэгч	Шинээр гаргасан ба нэмэгдсэн гол бүтээгдэхүүн	Хэмжээ мөнгөн дүн	Улс
“Алтайн хүдэр”, “Болдтөмөр Ерөө гол” ХХК	Төмрийн хүдэр, баяжмал	220 мян.тонн 10.0 сая \$	Сингапур
“Эрдэнэс Тавантолгой” ХХК	Коксжих нүүрс	442 мян.тонн 9.6 сая \$	
“Мэйжор дриллинг Монгол” ХХК	Ган хоолой ба өрмийн яндан хоолой	24 тонн 137 мян \$	Индонез
“Ачит ихт” ХХК	Тунгаасан зэс ба хайлш	99 тонн буюу 496 мян \$	

Эх сурвалж: Аж үйлдвэрийн яамнаас гаргасан “Үйлдвэржилт” сэтгүүл

Хүснэгт 33. Монгол улсын төмөрлөгийн үйлдвэрлэлийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоо хэмжээ

Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрийн тоо	Суурилагдсан хүчин чадал /жил/	Бүтээгдэхүүний хэмжээ
Ган бөмбөлөг, туйван, бэлдэц, ширэм	19	390.1 мян.тн	141.0 мян.тн
Катодын зэс	2	12.0 мян.тн	10.8 мян.тн
Кабель утас	2	4680.0 мян.м	2574.0 мян.м
Молибдений исэл	1	3.6 мян.тн	0
Автобус, цахилгаан машин	1	120 ш	36 ш
автомашин эд анги	2	1860.0 мян.ш	1860.0 мян.ш
Мотоцикл хагас угсрах	1	700 ш	700 ш
Мотоцикл эд анги обуд	1	30.0 мян.ш	9.0 мян.ш
Тоног төхөөрөмж /ХАА, хүнд даац, бага овор/	3	70 ш	3 ш
Авто чиргүүл	2	40 ш	4 ш
Цахилгаан мотор угсралт	1	200 ш	80 ш
Моторын эд анги	1	14 ш	3 ш
Авто шил	1	132.0 мян.м ²	92.4 мян.м ²
Агаар шүүгч	2	810.0 мян.ш	81.0 мян.ш
Зуух, пийшин	1	1320 ш	924 ш
Цахилгаан болон хөнгөн цагаан тогоо	1	27000 ш	22950 ш
Нийтийн хоолны тоног төхөөрөмж	1	240 ш	240 ш
Төмөр торон хашаа	1	144.0 мян.м	14.4 мян.м
Гэрлийн шон	1	1500 ш	225 ш
Металл хийц, эдлэл	3	10.5 мян.тн	2.4 мян.тн
Төмөр бетон дэр	2	368.0 мян.ш	35.0 мян.ш

Эх сурвалж: Аж үйлдвэрийн яамнаас гаргасан “Үйлдвэржилт” сэтгүүл



Манай улс жил бүр 60-100 үндсэн нэр төрлийн төмөрлөг бүтээгдэхүүн, ган, ширмэн болон өнгөт металлын цувимал, цутгамал эдлэл, үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэг, эд ангийг импортоор авч байна. Аж үйлдвэрийн салбарын үндэс суурь болсон төмөрлөгийн үйлдвэрлэлийг дотооддоо үе шаттай хөгжүүлснээр эдгээр олон нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээний тодорхой хувийг дотоодын үйлдвэрлэлээрээ хангах бүрэн боломжтой.

Хүснэгт 34. Төмөрлөг бүтээгдэхүүний зах зээлийн нийлүүлэлт /2012-2016 он, /мян.тн/ сая.ам.доллар

№ Бүтээгдэхүүний нэр	2012		2013		2014		2015		2016 /11-р сарын байдлаар/	
	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
1. Барилгын бүх төрлийн цувимал, цутгамал ган бүтээгдэхүүн	293,4	271,6	365,4	277,5	388,2	291,2	252,4	164,1	325,8	760,2
2. Барилгын даацын ба даацын бус төмөр хийц	87,02	170,75	64,34	121,23	75,2	112,8	43,2	74,0	109,5	543,4
3. Тоног төхөөрөмжийн ган, ширмэн сэлбэг эд анги	11,9	28,6	18,6	33,5	22,5	35,0	19,6	28,45	11,0	25,6
4. Машин механизмын ган ширмэн сэлбэг эд анги	30,7	55,4	37,2	68,75	40,5	75,0	48,1	65,4	233,4	170,1
5. Бүх төрлийн төмөрлөг хийц, эдлэл	106,67	148,72	99,09	183,26	105,32	173,04	85,4	136,64	88,1	56,3
НИЙТ	529,69	675,05	584,6	684,2	631,7	687,04	448,7	468,59	767,8	1555,6

Эх сурвалж: "Төмөрлөгийн аж үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ, боломж, гарц" эмхэтгэлийн 44 дүгээр хуудас.

Өнөөдрийн байдлаар манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа гангийн үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 180,0 гаруй мян.тн боловч хүчин чадлын ашиглалт 50-60%-тай байгаа нь түүхий эдийн хязгаарлагдмал нөөц, техник технологийн түвшний харилцан адилгүй байдал, мэргэжлийн инженер техникийн ажилтны хүрэлцээгүйгээс шалтгаалж байна.

Хүснэгт 35. Гангийн үйлдвэрүүдийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл

№	Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн	Үйлдвэрийн тоо	Хүчин чадал, мян.тн/жил
1	Барилгын ган туйван	14	180,0
2	Тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэг, эд анги	3	20,0
3	Цувимал, цутгамал ган бөмбөлөг	8	40,0
4	Цутгамал ган, ширмэн эдлэл	3	5,0

Эх сурвалж: "Төмөрлөгийн аж үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ, боломж, гарц" эмхэтгэлийн 48 дугаар хуудас

2.6.3

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Урьдчилсан ТЭЗҮ-ээр боловсруулах үйлдвэрийг Чойр, Сайншанд, Бор-Өндөр, Чойбалсан зэрэг байршлууд дээр газрын тосны ордын байршил, дэд бүтэц, түүхий тос болон бэлэн бүтээгдэхүүний логистик, зах зээлд ойр байх зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт байгуулахаар Засгийн газрын тогтоол гарсан. Үйлдвэрийн үндсэн технологи, хүчин чадлыг олон улсад газрын тос боловсруулах үйлдвэрт өргөн ашиглагдаж байгаа 5 төрлийн технологиос түүхий тосны шинж чанарт тохирсон байдал, тунгалаг бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүний стандарт зэргийг тооцоолж сонгохоор төлөвлөсөн.

Үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум ам.доллар байх бөгөөд боловсруулах үйлдвэр 0.7 тэрбум ам.доллар, газрын тос дамжуулах хоолой 264.5 сая ам.доллар, жилд 1.2 тэрбум ам.долларын борлуулалт хийх, жилийн цэвэр ашиг 160 сая ам.доллар, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 8-10 жил байхаар тооцоолж байна.

Тус үйлдвэр нь жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулж, евро-4,5 стандартын шаардлага хангасан 560 мянган тонн автобензин, 670 мянган тонн дизель түлш, 107 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дагалдах химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Дэлхийн зах зээл дээр 1 баррель түүхий тосны үнэ 40-60 ам.доллар байх үед үйлдвэрийн нэгж бүтээгдэхүүний үнэ 866-1244 төг/л байхаар байна.

Нийгэм, эдийн засгийн үр ашиг

- Үйлдвэр ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүний импорт 1.2 тэрбум ам.доллараар буурч, энэ хэмжээгээр гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэнэ.
- Валютын гадагшаа урсгал 20 орчим хувиар буурч, ам.долларын ханш 18-25 хувиар буурна.
- Улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 150 сая ам.доллар төвлөрүүлнэ.
- 600 гаруй шууд ажлын байр шинээр бий болно.
- Үйлдвэрийг дагаж нийт 30 төрлийн будаг, автомашины дугуй, резинен эдлэл, хуванцар, хими- цэвэрлэгээний материал, үнэртэн гоо сайхан, эмийн үйлдвэрүүд байгуулагдана.
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдэгдэхээр болсон.

2.6.4

НҮҮРС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нүүрс шингэрүүлэх, хийжүүлэх үйлдвэр байгуулахаар нийт 5 төсөл техник эдийн засгийн үнэлгээ боловсруулан, хэрэгжүүлэх шатандаа явж байна. Эдгээр үйлдвэрийг түүхий эд, дэд бүтэц, бэлэн бүтээгдэхүүний логистик, зах зээл ойр байх зэрэг үзүүлэлтэд түшиглэн Дорнод аймгийн Адуунчулуу нүүрсний уурхай, Төв аймгийн Төгрөг нуурын нүүрсний орд, Багануурын нүүрсний уурхай зэрэгт түшиглэн Монгол Улсын төв болон зүүн аймгийн нутгуудад байгуулахаар сонгосон байна.

Үйлдвэрүүдийн үндсэн технологи, хүчин чадлыг олон улсад нүүрс хийжүүлэх шингэрүүлэх, боловсруулах үйлдвэрт өргөн ашиглаж байгаа Фишер-Трофшийн арга, “Бергиус” технологи, SRC-I, SRC-II зэрэг технологиос нүүрсний шинж чанарт тохирох байдал, бүтээгдэхүүний гарц, бүтээгдэхүүний стандарт зэргийг тооцоолон сонгохоор төлөвлөсөн.

Эдгээр үйлдвэрт 1,1-2,4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Жилд дунджаар 2,5-6 сая тонн нүүрс боловсруулж, 0,4-1,2 сая тонн хөдөлгүүрийн түлш, 50-100 мянган тонн шингэрүүлсэн хий, 200-300 MBт цахилгаан бусад дагалдах бүтээгдэхүүн боловсруулан гаргахаар төлөвлөөд байна. Хөрөнгө оруулалт эргэн төлөгдөх хугацааг 8-15 жил байхаар тусгажээ.

Нийгэм, эдийн засгийн үр ашиг

- ДНБ-ийг 15 хүртэл хувиар нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- Үйлдвэр ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүн автобензин, дизель түлш, хийн импорт 1-1,5 тэрбум ам.доллараар буурч, энэ хэмжээгээр гадаад худалдааны тэнцлийн ашиг нэмэгдэнэ.
- Валютын гарах урсгал 15-20 орчим хувиар, ам.долларын ханш 18-25 хувиар буурна.
- Улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 150-300 сая ам.доллар төвлөрүүлнэ.
- 400-1000 шууд ажлын байр, 1000-1500 шууд бус ажлын байр шинээр бий болгоно.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



2.6.5


ХАР ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

“Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”-ийн зорилго нь Төрөөс эрдэс баялаг, аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогуудад тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлж, өндөр чанарын ган, тусгай зориулалтын хайлш бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар үндэсний экспортыг дэмжихэд оршино. Хөтөлбөр нь төмрийн хүдэр, ганг чанаржуулагч элементүүд (манган, хромын хүдэр), галд тэсвэртэй материалуудыг эрж хайх, олборлох, баяжуулах, төмрийн төрөл бүрийн бэлдэц, тусгай зориулалтын хайлш (төмөрт цахиур, төмөрт хром, төмөрт гянтболд, төмөрт молибден, төмөрт титан, төмөрт ванади), өндөр чанарын ган, металлургийн кокс үйлдвэрлэх, жонш, шохой, нийлэг хий, хүчилтөрөгчийн нийлүүлэлт, цахилгаан эрчим хүч, үйлдвэрлэлийн усны хангамж, тээвэр логистик, бүтээгдэхүүний маркетинг, төрийн худалдан авалт зэрэг салбарын хүрээнд үйлчилнэ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр 6 зорилт дэвшүүлж, зорилт бүрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдэж, төмөрлөг бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь, хэмжээ өсч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын таатай орчин бий болж, худалдааны эргэлт сайжирч, экспортын зах зээл өргөжинө. Мөн стандарт, гарал үүсэл хангасан бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, өрсөлдөх чадвар өсч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг тодорхой чиглэл, байршилд зохистой төвлөрүүлэх, эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэж, олон улсын стандартын шаардлага хангасан, өндөр чанарын ган, тусгай зориулалтын хайлш бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болох эхлэл тавигдана. Мөн төмөр боловсруулах, машин тоног төхөөрөмж, хийцийн үйлдвэрүүд байгуулагдаж, нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжсэнээр инженер, техникийн өндөр мэргэжлийн ажилтнууд эх орныхоо үйлдвэрүүдэд ажиллах нөхцөл сайжирч, бүтээмж нэмэгдэнэ.





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 273 дугаар тушаалаар байгуулагдсан “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах” үнэлгээний хороо ажиллаж, тендерийн үнэлгээ хийгдсэн. “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөхийн тендерт Канад улсын HATCH компани шалгарч, Аж үйлдвэрийн яам, Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн нэгжтэй 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр гурвалсан гэрээ (Contract No. MB/MOF/MINIS/CS/QCBS/1.1.3 (c) 2015) байгуулсан. “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төсөл”-ийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах Зөвлөх компаниар “Экотон” ХХК шалгарч, Аж үйлдвэрийн яам, Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн нэгжтэй 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр гурвалсан гэрээ (Contract No. MB/MOF/MINIS/CS/QCBS/1.1.3 (d) 2015) байгуулж, ажлаа эхлүүлээд байна.

“Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг 2017 онд УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн бодлогын газар хүлээн авна.



2.6.6

УУЛ УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

“Уул уурхай, металлургийн цогцолбор” байгуулах төслийн хүрээнд “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК дараах бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөө дэд станцын өргөтгөл, Төмөртэйн ордыг цахилгаан эрчим хүчээр хангах 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 16 МВА чадалтай Төмөртэйн дэд станцыг барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгч, бүрэн ашиглалтад оруулав. **(2012-2014 он)**
2. Төмөртэйн уурхайд 750 тн/цаг хүчин чадалтай хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг угсарч, бүрэн ашиглалтад оруулав. **(2014 он)**
3. Төмөртэйн уурхайн Зүүний зүүн биет дээр ил уурхайн бэлтгэл ажлыг хангаж, уурхайд шаардлагатай машин механизм, техник хэрэгсэл худалдан авч, Зүүний зүүн уурхайг 2014 онд шинээр нээн, хөрс хуулалтыг эхлүүлэв.
4. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өөрийн 45 МВА Төмөрлөг дэд станцыг 10 МВА дэд станцаар өргөтгөх ажлыг хийж дуусгав. **(2013-2014 он)**
5. Сэлэнгэ аймгийн Ерөө суманд орших Хандгайт өртөөн дэх жилд 2.5 сая тн төмрийн хүдрийн баяжмал ачиж тээвэрлэх Хандгайт терминалыг байгуулж ашиглалтад оруулав. **(2014 он)**
6. Жилд 1 сая тн хүдэр боловсруулж, 700 мян.тн нойтон баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийг хаягдлын байгууламжийн хамт ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгөв. **(2013-2014 он)**
7. Дарханы Төмөрлөгийн үйлдвэр дээр жилд 2 сая тн баяжмал ачих хүчин чадалтай төмөр замын терминал барьж ашиглалтад оруулав. **(2014 он)**
8. Төмөртолгойн уурхайд 500 тн/цаг хүчин чадалтай 2 дахь хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг угсарч дуусган, улсын комисст хүлээлгэн өгөв. **(2014 он)**
9. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас Дулаанханы 4 замын уулзвар хүртэлх 104.5 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлж, замын далан байгуулах ажлуудыг гүйцэтгээд байна **(2015 он)**
10. 2015 оны 12 дугаар сард Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн төмөр зам, жилд 2.5-8 сая тн төмрийн хүдрийн баяжмал ачиж тээвэрлэх Төмөртэйн терминал, иж бүрэн өртөөний бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, улсын комисст хүлээлгэн өөв. **(2014-2015 он)**

“Уул уурхай, металлургийн цогцолбор” байгуулах төслийн хүрээнд дээрх бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 300 сая орчим ам долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.

• Санхүүжилт:	Дотоодын хөрөнгө оруулалт
• Нийт хөрөнгө оруулалт:	800 сая ам.доллар
• Үндсэн бүтээгдэхүүн:	жилд 350,0 мян.тн ган туйван, ган утас, ган бөмбөлгийн бэлдэц үйлдвэрлэх
• Дагалдах бүтээгдэхүүн:	жилд 500,0 мян.тн цувимал ган, аргалж /pellets/ үйлдвэрлэх
• Түүхий эд:	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэй, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайгаас
• Борлуулалт:	Дотоодын зах зээлийг бүрэн хангана.
• Боловсон хүчин:	Шинээр 800 ажлын байр бий болно.
• Төсөл эхлэх, хэрэгжих хугацаа:	2016-2018 он
• Улсын төсөвт:	жилд 30 сая ам.доллар татвар, төлбөр төвлөрүүлэх болно



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

2.6.7

ӨНГӨТ
ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ

УИХ-ын 2015 оны “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” 247 дугаар тогтоолын “Зэс хайлуулах үйлдвэр байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх” тухай заалт, УИХ-ын 2010 оны “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Зэс хайлуулах үйлдвэр” байгуулах тухай зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 229 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийн 14.17 дугаар заалт, Засгийн газрын 2009 оны 320 дугаар тогтоолын “Засгийн газраас эхний ээлжинд хэрэгжүүлэх томоохон төслүүдийн жагсаалт”-ын 3 дугаар заалт зэрэгт тусгагдсан.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын “Volant Industry” компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төслийн институт /ENFI/-ын боловсруулсан “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр”-ийн ТЭЗҮ-ийг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Аж үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн аваад байна.

Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар **“Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийг Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байгуулах тухай”** 247 дугаар тогтоолыг батлуулж, тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 134 тоот тушаал гарч, төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсан. Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай” 318 дугаар тогтоолыг баталсан болно.

Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Төслийн нэгж байгуулах тухай” 107 дугаар тогтоолын дагуу төслийн нэгжийн төсөв, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Зэсийн баяжмал хайлах болон конвертерийн SKS зуух.

SKS зэсийн баяжмал хайлах болон конвертерийн зуух нь хэвтээ цилиндр хэлбэртэй, түүнийг эргүүлэх төхөөрөмжөөр тоноглогдсон, хүчилтөрөгчөөр баяжуулсан агаарыг хайлах зуухны дороос хэд хэдэн хэсгээр хайлмал материалд шууд өгөх хоолой бүхий галд тэсвэртэй материалаар доторлосон, хэсэгчилсэн хөргөлтийн системтэй зуух юм.

Төслийн ерөнхий мэдээлэл:	
• Санхүүжилт:	Үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулна.
• Нийт хөрөнгө оруулалт:	798 сая ам.доллар
• Хүчин чадал:	Жилд 530 мян.тн зэсийн баяжмал боловсруулна
• Үндсэн бүтээгдэхүүн:	Жилд 120 мян.тн катодын зэс
• Дагалдах бүтээгдэхүүн:	Жилд элементийн хүхэр 170 мян.тн , хүхрийн хүчил 200 мян.тн
• Шинээр бий болох ажлын байр:	759 ажлын байр
• Төсөл хэрэгжих хугацаа:	2017-2019 он



АВСТРАЛИ-МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Австрали Улсын Гадаад Харилцаа, Худалдааны Яам нь “Адам Смит Интернэйшнл” компанийг энэхүү хөтөлбөрийн (АМЕР) хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулсан бөгөөд энэхүү хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг 2015-2018 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Тус хөтөлбөр нь 2015-2016 онд дараах техникийн туслалцааны төслүүдийг хэрэгжүүлсэн.

- Монгол Улсад Үндэсний Геологийн алба байгуулахад техникийн туслалцаа үзүүлэх.
- Монгол Улсын алтны салбарыг 2015-2025 он хүртэл хөгжүүлэх стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх,
- Ашигт малтмал баяжуулах үйлдвэрүүдийн аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэх,
- Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох,

АМЕР хөтөлбөрийн зүгээс 2017 онд АМГТГ-ын захиалгаар Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулахад техникийн туслалцаа үзүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү ажлын хүрээнд Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа интернетэд суурилсан каталогийн систем (WebGIS) боловсруулах юм.



“МОНГОЛ УЛС: ИНСТИТУЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ЗАМААР ЭРДЭС БАЯЛГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

Канад Улсын Гадаад хэргийн яамнаас санхүүжүүлж буй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл нь төрийн байгууллагууд болон орон нутгийн иргэдээс бүрдсэн бүлгүүдийн чадавхийг олборлох салбарыг үр дүнтэй удирдах чиглэлээр хөгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийг сэргээж, тогтвортой өсөлт бий болгоход 2016-2022 онд хувь нэмэр оруулж ажиллана.

MERIT төслийн зорилго нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал юм.

Үндсэн үйл ажиллагаа:

- Байгаль орчны менежмент, эрсдэлийн удирдлага, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа зэрэг чиглэлээр олборлох салбарын олон улсын жишигт хүрсэн үр чадвар, шилдэг туршлагаудыг нэвтрүүлэх. Тухайлбал, компанийн нийгмийн хариуцлага, ОУИТБС-ын тайлан гэх мэт.
- Төслийн удирдлага, мониторинг, үнэлгээ хийх
- Хүний нөөц, байгууллагын болон санхүүгийн удирдлага (манлайллын сургалт гэх мэт)
- Стратеги төлөвлөлт
- Мэдээллийн удирдлага /мэдлэгийн менежмент, мэдээллийн технологи болон GIS-ийн үр чадвар, программ болон техник хангамж/
- Харилцааны үр чадвар, олон нийттэй харилцах, олон талт зөвлөгөө зохион байгуулах, нутгийн иргэд, иргэний нийгмийн төлөөлөгчдөд олборлох үйлдвэрлэлийн нөлөөлөл болон шинэ боломжуудын талаар мэдээлэл өгөх
- Олборлох салбарын менежментэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.



“МОНГОЛ УЛСАД ОЛБОРЛОХ САЛБАРЫН УДИРДЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Канад улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх” (SESMIM) төсөл нь 2015-2020 онд Монгол Улсын олборлох салбарын тогтвортой хөгжлийг дэмжиж ил тод, үр ашигтай байдлаар төрийн бодлогыг хэрэгжүүлэн олборлох салбарын чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж ажиллана.

Төсөл нь олборлох салбарын бодлого, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, салбарын яам болон бусад байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, нотолгоонд суурилсан хүйсийн тэнцвэрт байдал, нийгэм, байгаль орчинд үр ашигтай шийдвэр гаргахад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх 3 үндсэн зорилтын хүрээнд ажиллах юм.

Төслийг Канадын Агритийм Канад зөвлөх компани хэрэгжүүлэн ажиллах бөгөөд Монгол Улсаас голлон хамтарч ажиллах байгууллага нь Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газар байна. Мөн Алберта мужийн захиргаа, Алберта болон Калгарын их сургууль зэрэг бусад байгууллагатай хамтран ажиллана.

“ХОЙД-ТӨВ-ЗҮҮН АЗИЙН 3 ХЭМЖЭЭСТ ГЕОЛОГИЙН СТРУКТУРУУД БА МЕТАЛЛОГЕНИ” ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ

Хойд-Төв-Зүүн Азийн нутгийг хамарсан геологийн том тогтцын хэмжээнд хийгдсэн геологи, ашигт малтмалуудын мэдээллийг нэгтгэн уялдуулж, оролцогч улсуудын геологийн мэдээллийг цуглуулж, орчин үеийн геологийн судалгааны төвшинг бүрэн тусгасан хамтарсан судалгаа хийх 5 улсын (Монгол, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ) хамтарсан төсөл.

Манай талаас Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн региональ геофизикийн (соронзонгийн болон хүндийн хүчний) судалгааны материалд боловсруулалт хийж ОХУ, БНХАУ зэрэг хөрш зэргэлдээ орнуудын ижил төстэй зургуудтай уялдуулах замаар Хойд – Төв – Зүүн Азийн чулуулаг бүрхэвчийн зузааны 1:5000000-ын масштабтай ерөнхий зураг зохиоход оролцоно.

Мөн Монгол Алтайн бүс буюу А1 талбай (М-45, М-46, L-46), Монгол-Агнуурын бүс буюу А2 талбайн (М-49, М-50) Монгол орны хэсэгт хамаарах хэсгүүдэд геологи, тектоник, металлогенийн 1:1000 000-ын масштабтай зургуудыг тоон мэдээллийн хэлбэрээр зохиож, хил залгаа орших ОХУ, БНХАУ-ын газар нутгийн дээрх масштабын зургуудтай уялдуулан холбож эцэслэн гаргана.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН БОЛОН УРД ХЭСЭГТ 1:50 000-НЫ МАСШТАБЫН ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ БОЛОН АШИГТ МАЛТМАЛЫН СУДАЛГАА ХИЙХ ТӨСӨЛ

БНСУ-ын КИГАМ байгууллагатай хамтран Монгол орны өмнөд хэсэгт 1:50000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл юм. 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 2 тал гэрээнд гарын үсэг зурснаар “Монгол орны өмнөд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх” техникийн хамтын ажиллагааны төслийн ажил эхэлсэн.

Тус газар нь БНСУ-ын КИГАМ байгууллагатай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт төслийн 2 дахь жилийн хээрийн ажлыг гүйцэтгээд байгаа бөгөөд төслийн хээрийн материалыг хүлээн авсан.



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

“ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ” ТӨСӨЛ

Швейцарийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар Швейцарийн Хөгжлийн агентлагтай хамтран хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдэд чиглэсэн төслийг 2005 оноос хэрэгжүүлж байна. Монгол Улсын бичил уурхайн салбарт бичил уурхайн талаарх олон улсын сайн туршлагаас суралцуулах, үр шимийг хүртэх, хувь нэмэр оруулах зорилготой уг төсөл 2018 он хүртэл хэрэгжинэ.

Төслийн зорилтууд нь:

- Бичил уурхайд чиглэсэн төрийн таатай бодлогыг дэмжин албан ёсны, хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд тохиромжтой хууль эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлэхэд үүрэг гүйцэтгэх, бичил уурхайн ил тод, шударга бодлого, зохицуулалтын орчин бий болгож, хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- Бичил уурхайчид тухайн оршин суугаа орон нутагтаа аюул осолгүй, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай, эдийн засгийн хувьд үр ашигтай бичил уурхайн үйл ажиллагаа явуулах чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчдыг энэ зорилгод хүрэхийн тулд зохион байгуулалтад орж, үйл ажиллагаагаа зохицуулахад нь дэмжлэг үзүүлж чадваржуулах;

Төслийн хүлээгдэж буй үр дүн:

Үр дүн 1: Хүний эрхэд суурилсан бичил уурхайн бодлого болон бичил уурхайчдыг дэмжих орчин бий болгох

Үр дүн 2: Бичил уурхайн нийлүүлэлтийн албан ёсны сүлжээний оролцогч талуудын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх

Үр дүн 3: Мэдлэг харилцан солилцох, бичил уурхайн мэдлэгийн төв бий болсон байна.



“МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ” ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСӨЛ

2014 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр гэрээнд гарын үсэг зурснаар энэхүү техникийн хамтын ажиллагааны төслийн ажил эхэлсэн.

Төслийн зорилго нь байгууллагын ажилтан албан хаагчид эрдэс баялгийн салбарын төрийн олон хувийн хэвшлийнхнийг мэргэжлийн, чанарын өндөр төвшний мэдээллээр хангах чадамжтай болгох юм.

Төслийн 1 дүгээр үе шатанд ажилтан албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлийн сургалтууд зохион байгуулсны зэрэгцээ ашигт малтмалын тодорхой төрлүүдээр судалгааны ажлууд хийх, мэдээллийн товхимол бэлтгэн гаргах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлууд хэрэгжив.

Төслийн дараагийн үе шатны ажлуудыг 2017 оны II улирлаас эхлэхээр төлөвлөсөн бөгөөд дараах ажлын саналууд гарсан болно.

- Хайгуулын төслийн эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх, ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх
- Ашигт малтмалын төслийн ТЭЗҮ боловсруулах стандартыг сайжруулах, ТЭЗҮ-ийн хамрах хүрээг тогтоох, урьдчилсан үнэлгээ, ТЭЗҮ хүлээн авдаг ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх
- Геологи, уул уурхайн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх
- Зарим төрлийн ашигт малтмалын хайгуулын талбайд хээрийн болон нарийвчилсан судалгаа хийх
- Ашигт малтмалын гадаад зах зээлийн судалгаа, анализ хийх чадавхийг дээшлүүлэх
- Бусад шаардлагатай сургалтууд

Гадаад хамтын ажиллагааны хөрөнгөөр хэрэгжиж байгаа БНЧУ-тай хамтарсан “1:50000-ны масштабын геологийн зураглал”, ерөнхий эрлийн “Монгол Алтай-50”, БНПУ-тай хамтарсан Хасагт хайрханы талбайн хэмжээнд 1: 50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил гүйцэтгэн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судлан, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх төсөл

УТХ-өөр болон гадаад хамтын ажиллагааны хөрөнгөөр хэрэгжиж байгаа БНЧУ-тай хамтарсан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн “Монгол Алтай-50” төслийн эцсийн үр дүнгийн тайланд 2016 оны 4 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд шуурхай хяналт хийсэн. Уг хурлын тэмдэглэл, төслийн танилцуулгыг инженер техникийн ажилчдын мэдээ, бусад баримтын хамт бүрдүүлж, дүгнэлт өгөн, үүрэг даалгавар өгсөн болно. “Монгол Алтай-50” төслийн үр дүнгийн тайланг хянаж, ЭБМЗ-ийн 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 3 дугаар хурлаар хэлэлцүүлэв.

Монгол-Польшийн хамтарсан Хасагт-50 эрлийн ажлын төслийн эцсийн үр дүнгийн тайланг анхдагч материалын хамт хүлээн авч, АМГТГ-ын геологийн төв архивт хүлээлгэн өгөв.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



III БҮЛЭГ.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОС, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ 2017-2020 ОНД ХИЙГДЭХ ГОЛ АЖЛУУД, ХҮРЭХ ҮР ДҮН



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Ашигт малтмал, газрын тосны газар нь Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/-ын баримт бичиг болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан бодлогуудыг цаашид хэрэгжүүлж ажиллах тул эдгээр баримтад тулгуурлан Монгол Улсын геологи, уул уурхай, газрын тосны салбарын 2017-2020 оны урьдчилсан төсөөллийг боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга, урт хугацааны төлөвлөгөө боловсруулан, хүрэх үр дүнг урьдчилсан байдлаар тодорхойлов.

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/-ын баримт бичгийг баталсан. Тус бодлогын баримт бичгийн үндсэн зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Ашигт малтмал, газрын тосны газар нь Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн хүрээнд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд тус агентлагийн 2017-2020 оны үйл ажиллагааны төсөөллийг дээрх бодлогын баримт бичигт тулгуурлан гаргасан.



Бодлогын баримт бичигт тусгагдсан гол заалтуудыг тоймлон хавсралтад тусгав.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар нь ирэх 4 жил Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.



Мөрийн хөтөлбөрт тусгагдсан уул уурхайн салбартай холбоотой 2017 онд хэрэгжүүлэх боломжтой томоохон заалтуудыг дараах хүснэгтэд үзүүлэв.

3.1

ТӨРӨӨС ЭРДЭС
БАЯЛГИЙН
САЛБАРТ
БАРИМТЛАХ
БОДЛОГО

3.2

ЗАСГИЙН
ГАЗРЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨРТ
ТУСГАГДСАН
ТОМООХОН
АЖЛУУД



**Хүснэгт 36. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан,
2017 онд хэрэгжих боломжтой заалтууд***

Мөрийн хөтөлбөрийн заалт	
УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР	
“Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	“Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана.	Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.	Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.
“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.
Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.	Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчин бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.
Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгоно.	Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчин бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
“Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанкт хамтран шийдвэрлэнэ.	Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчин бүрдүүлнэ.	Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	Металл хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Мөрийн хөтөлбөрийн заалт

ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, бүтэц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тогтоохоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэдэг геологийн шинжлэх ухааны ажил, сэдэвчилсэн судалгаа, зураглал, эрлийн ажлын хэмжээ болон улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг татан оруулах, энэ төрлийн ажлыг хувийн хөрөнгөөр гүйцэтгэхийг бодлогоор дэмжих;

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд геофизик, геохими, уул-өрөмдлөгийн ажлыг цогцоор нь гүйцэтгэж чанарыг сайжруулах, хүдрийн дүүрэг, илрэл бүхий талбайд зарим онцгой тохиолдолд нарийвчилсан судалгаа гүйцэтгэх;

Улсын хэмжээний геоэкологийн нэгдсэн судалгааг эрчимжүүлж, тодорхой хот, аймаг болон сумдын хэмжээнд геоэкологийн төрөлжсөн судалгааг гүйцэтгэх,



Мөрийн хөтөлбөрийн заалт

ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.

Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.



* <http://legalinfo.mn/law/details/12120>




АМГТГ-ын Кадастрын хэлтэс нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу өргөдөл болон сонгон шалгаруулалтын журмаар олгож байна. Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоож, Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 511 дүгээр тогтоолоор хавсралтад өөрчлөлт оруулан баталсан юм.

Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох

Ашигт малтмалын тухай хуульд Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон, эрдсийн хуримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгохоор заасан. Сонгон шалгаруулалт явуулахдаа тусгай зөвшөөрөл олгох талбайг ялган багцалж, 30-аас доошгүй хоногийн өмнө өргөдөл хүлээн авах хугацааг өдөр тутмын сониноор нийтэд зарлаж, сонгон шалгаруулалт явуулдаг.


Зураг 51. Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох талбай



Өргөдлийн журмаар тусгай зөвшөөрөл олгох

Кадастрын хэлтэс Монгол улсад татвар төлөгч аж ахуйн нэгжид өргөдлийн журмаар олгох боломжтой талбайн мэдээллийг өдөр тутмын сонин болон өөрийн цахим хуудас, байгууллагын гаднах дэлгэцээр олон нийтэд ил тод, нээлттэйгээр зарлана. Зарласан талбайд тусгай зөвшөөрөл олгохдоо өргөдөл гаргах дугаарыг цахимаар олгох системд хамгийн түрүүнд бүртгүүлсэн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэдэг.

Зураг 52. Өргөдлөөр тусгай зөвшөөрөл олгох талбай





Монгол улсад 80 гаруй төрлийн ашигт малтмалын 1000 гаруй орд, 9000 гаруй илрэлийн тархалт байршил, төрөл зүйлийг тодорхойлон судалсан байдаг.

Хайгуулын ажлыг идэвхжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд тусгай зөвшөөрлийг зөвшөөрөгдсөн талбайн хэмжээнд олгох нь чухал байна. Одоогоор тусгай зөвшөөрөл олгох ажил зогсонги байдалтай байгаа боловч 2017 оноос өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох ажил идэвхижсэнээр хайгуулын ажил дагаад идэвхжинэ. Мөн ашигт малтмалын түүхий эдийн зах зээлийн үнэ унаж байсан бол одоо өсөх хандлага ажиглагдаж байна.

Сонгон шалгаруулалтын талбайг шинэчлэх ажил хийгдэж геологийн 1:50000-ны зураглалын ажлаар ялгагдсан хэтийн төлөв, эрдсийн хуримтлалтай тогтоосон талбайг нэмж Засгийн газраар шийдвэр гаргуулахаар төлөвлөгдсөн. Засгийн газрын тогтоол гарсанаар УТХ-өөр зураглал хийж эхний ээлжинд ашигт малтмалын хэтийн төлөвтэй болох нь талбайнуудад хийгдэх хайгуулын ажил эрчимжинэ.

Дэлхийн хэмжээнд сүүлийн 4-5 жилд хайгуулын ажилд оруулсан хөрөнгө оруулалтыг олон улсын судалгааны байгууллагууд гаргасан байдаг бөгөөд үүгээр алт, зэс, цайр, жонш гэх мэт ашигт малтмалын хайгуулд жилд дунджаар 15-20 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж байна. Үүнээс Австрали, Канад хоёр 8%-ийг, Орос 2%, Хятад 3%, Казахстан 3%-ийг нь татдаг байна. Монгол улс геологийн тогтцын ашигт малтмалуудын хувьд хэтийн төлөвтэй, ашигт малтмалын хайгуул хийх маш их бололцоотой. Тиймээс Монгол улсад гадны хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлж чадвал ойролцоогоор жилдээ 0.5-2 тэрбум долларыг хайгуулын салбарт татах бололцоотой.

Олон улсад геологи, уул уурхайн салбарт дундаас том хэмжээний компаниуд хөрөнгө оруулах сонирхол ихтэй болж байна. Монгол улсын хууль эрх зүйн салбар тогтвортой болж шинэчилэгдсэнээр хууль эрхзүйн орчноо дагаад өрсөлдөх чадвар сайтай болсон. Монгол улсын татварын орчин, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээгээр бусад улстай харьцуулахад илт сайжирсан.

Үнэт металл буюу алтны үндсэн орд, газрын ховор элемент, өнгөт болон ховор металл, уран, газрын тосны чиглэлээр хөрөнгө оруулагч нарын сонирхолыг татах чиглэлээр мэдээллийг бэлтгэж хуулийн хүрээнд нээлттэй болгох чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.



Монгол Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн гол нэр төрлийн ашигт малтмалын нөөцийн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 37. Монгол улсын ашигт малтмалын нөөц

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	Нөөц	Дэлхийд эзлэх байр
Алт	тн	Үндсэн 425тн, дайвар 850тн	-
Зэс	мян.тн	30 574.1	-
Нүүрс	тэрбум тн	37.1 (таамаг нөөц 173.1)	VII байрт *
Уран	тн	180 783	XI байрт **

* USGS data 2012

** www.worldatlas.com


Монгол Улсын ашигт малтмал, газрын тосны олборлолт, экспортын 2017-2020 оны урьдчилсан төсөөллийг төрөөс эрдэс баялаг, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, цацраг идэвхт ашигт малтмал болон хүнд үйлдвэрийн салбарт баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тулгуурлан боловсруулав.

Хүснэгт 38. Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөөлөл
2017-2020 он*

Ашигт малтмалын төрөл	хэмжих нэгж	2017 он	2018 он	2019 он	2020 он
Алт	тн	15.1	16.5	24.8	9.2
Зэс	мян.тн	1,326.0	1,064.8	1,220.8	1,255.9
Катодын зэс	тн	2,300.0	2,300.0	2,300.0	2,300.0
Нүүрс	сая.тн	31,241.5	37,058.0	41,186.0	44,191.0
Төмрийн хүдэр	сая.тн	11.0	11.0	11.0	11.0
Цайр	мян.тн	94.0	90.0	90.0	90.0
Молибден	мян.тн	4.5	4.5	4.5	4.5
Жонш	мян.тн	200.0	250.0	240.0	250.0
Гянтболд	тн	298.0	330.0	280.0	240.0
Цагаан тугалганы баяжмал	тн	85.0	85.0	85.0	85.0
Газрын тос	мян.тн	995.0	1,002.0	940.0	940.0
Мөнгө	мян.тн	39.0	29.2	37.7	37.0


Зураг 53

Зэс, катодын зэс, газрын тосны бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл




Зураг 54.

Цайр, жоншны бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл




Зураг 55.

Нүүрсний бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл




Зураг 56

Мөнгө, цагаан тугалга, гянтболдын бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл



Зураг 57

Алт, молебден, төмрийн хүдрийн бүтээгдэхүүн гаргалтын урьдчилсан төсөөлөл



Газрын тос гаргалтын урьдчилсан төсөөлөл

	2017 он	2018 он	2019 он	2020 он
Олборлолт, экспорт (тонн)	995,000	1,002,000	940,000	940,000



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Олон улсын байгууллагаас 2016 онд гаргасан судалгаагаар Монгол Улсын хөрөнгө оруулалтыг татах чадвар суларч, гадаадын хөрөнгө оруулалт буурсан талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Иймд АМГТГ дээрх судалгааны дүгнэлт, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлд хийгдэж байгаа ажлуудад үндэслэн 2017 онд хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр дараах 17 ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт 39. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулалт татах чиглэлээр 2017 онд хийгдэх гол ажлууд, хэрэгжүүлэх арга зам *

Хийгдэх ажлууд	Хэрэгжүүлэх арга зам
1. Хилийн бүсийн дагуух геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх	Хил залгаа, хөрш улс орнуудтай хамтран геологи, хайгуулын судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх.
2. Эрдэс баялгийн судалгааны мэдээллийг ил тод болгож хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах	АМГТГ-т Геологийн судалгаа, ашигт малтмалын хуулиар хориглоогүй мэдээллийг холбогдох төлбөрийн нөхцөлтэйгөөр цахим хуудаст байрлуулах.
3. Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг нэмэгдүүлж шалгаруулалтыг үр дүнтэй, өрсөлдөөнтэй болгох	Улсын болон хувийн хөрөнгөөр хийгдсэн эрэл хайгуулын ажлын үр дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайнуудыг шинээр ялгаж, сонгон шалгаруулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэн, зарлагдаж байгаа талбайн геологийн судалгааны ажлын болон ашигт малтмалын чадамжийн талаарх багц мэдээллийн чанарыг сайжруулах.
4. Салбарын үйл ажиллагааг орон нутгийн ард иргэдэд зөв таниулах, сурталчлах, үйл ажиллагааг нь дэмжүүлэх, үүнтэй холбоотой хяналтыг дээшлүүлэх. /хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагааны талаар үнэн зөв, тодорхой ойлголттой болох/	Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хамтарсан уулзалт зохион байгуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тусгайлан хөтөлбөр, хуваарь, төлөвлөгөөний дагуу олон нийтэд сурталчлан, таниулах үйл ажиллагааг орон нутаг, аймаг, бүс, улсын хэмжээнд хэрэгжүүлэх.
5. Газрын тосны БХГ байгуулсан компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллах талаар Засгийн газраас орон нутгийн удирдлага, ИТХ болон төрийн байгууллагуудад хатуу даалгах, Засгийн газрын шийдвэр, хуулийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулж чадахгүй тохиолдолд хариуцлага тооцох.
6. Газрын тосны олборлолт хийж байгаа болон эхлэх шатанд байгаа талбайнуудын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.	Ашиглалтад шилжсэн Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ-97 талбайнуудын нөөцөд тулгуурлан газрын тос боловсруулах үйлдвэр барих ТЭЗҮ-г боловсруулж, ТЭЗҮ-д тулгуурлан хөрөнгө оруулалт татах.
7. Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын БХГ-ний талбайг сонгох аргачлалыг геологийн нарийвчилсан судалгааны үр дүнг үндэслэн хийх	Урьд өмнө хийгдсэн уламжлалт, уламжлалт бус газрын тосны геологийн болон геофизикийн хайгуул судалгааны ажлуудыг нэгтгэн, сав газар, хотгоруудыг урьдчилсан байдлаар үнэлэн, дүн шинжилгээ хийж хэтийн төлөв бүхий талбайг ялгах.
8. Газрын тосны талбайнуудын судалгаанд салбарын судлаачдыг идэвхтэй татан оролцуулж, судалгааны чиглэл бүрээр шинжлэх ухааны бүтээлүүд гаргуулах нь хөрөнгө оруулагчдад ихээхэн мэдээлэл өгөх ба мөн сурталчилгаа ч болно.	Гадаад, дотоодын судлаачдыг хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд нь Засгийн газар болон Яамнаас дэмжиж ажиллах. Дотоодын судлаачдын санал санаачилгыг дэмжих, одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг зогсоолгүй харин цар хүрээг нь тэлэх тал дээр дэмжих.

* www.mram.gov.mn

Хийгдэх ажлууд	Хэрэгжүүлэх арга зам
9. Газрын тосны салбар дахь БХГ-т талбай эзэмшигч компаниудын хариуцлагыг өндөржүүлэх.	Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ-гээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй компаниудын БХГ-г цуцалж, цуцлагдсан талбайд дахин сонгон шалгаруулалт зарлах замаар хөрөнгө оруулалтыг сэргээх.
10. Газрын тосны гэрээлэгч компаниудын зүгээс хөрөнгө оруулагчдын итгэлийг баталгаажуулах үүднээс тогтвортой байдлын гэрээ байгуулах сонирхолтой байдаг. Иймээс тогтвортой байдлын гэрээ байгуулж болох эсэх талаар дахин судлаж.	Эрх зүйн талаас судалж үзэх.
11. АМГТГ-ын цахим хуудаст хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх, санал авах эргэх холбоо бүхий байнгын ажиллагаатай цонх бий болгох	Хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл санал болгогч болон хөрөнгө оруулах сонирхол бүхий этгээд өөрсдийн мэдээллээ нээлттэй оруулах боломжтой цахим хуудас ажиллуулах. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сул байгаа талбайн илрэл, (ашигт малтмалын төрлөөр), эрдэсжсэн цэг, хүдэржилтийн бүсийн холбогдолтой мэдээллийг хөрөнгө оруулагчид судлах боломжийг бий болгох. Гадаадын хөрөнгө оруулагчдаас Монголын эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулахад тулгарч буй хүндрэлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, санал болгож буй нөхцөл зэрэг мэдээллийг онлайнаар авах, түүнд эргэж хариу өгөх боломжтой цахим хуудас ажиллуулах. Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа хэрхэн явуулах талаар үлгэрчилсэн схем зураг, тайлбар болон зөвлөмж бүхий танилцуулгыг /талбайг судлан сонгохоос бүтээгдэхүүн гаргах хүртэлх бүхий л үйл ажиллагааны үе шатыг харуулсан схем, төрийн, орон нутгийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог харуулсан схем г.м./олон нийтэд ил тод, нээлттэй болгож танилцуулах.
12. Ашигт малтмалын эрэлт, нийлүүлэлтийн судалгааны мэдээллийг ил тод болгох, нэн тэргүүнд эрэл, хайгуулын ажлын боломжоор хангах	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талбайг сонгохдоо богино хугацаанд үр ашиг өгөх, дэлхийн зах зээлд эрэлт ихтэй, нийлүүлэлт багатай ашигт малтмалын төрлөөр (алт, төмөр, лити, газрын ховор элемент гэх зэрэг), хэтийн төлөвтэй минерагений бүс, дүүргийн хэмжээнд явуулсан өмнөх геологийн судалгаанд тулгуурлан эхний ээлжинд сонгон олгох зэрэг суурь судалгаанд тулгуурласан боловсруулалт хийх.
13. Ногдол ашгийн татвар бууруулах талаар судалгаа хийж, холбогдох саналыг хүргүүлэх.	Ногдол ашиг шилжүүлэх, авахад ногдох татвар 20% байгаа нь өндөр байгаа тал дээр судалгааг хийж, санал боловсруулан хүргүүлэх.
14. Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх.	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсгийн "гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 000 ам.доллар"-ыг нийт хөрөнгө оруулалт гэж өөрчлөх саналыг хүргүүлэх.
15. Хуулийн орчуулгыг цахим хуудаст байршуулах /Promotion Mongolia, Mining Mongolia, Invest Mongolia/	Ашигт малтмалын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг эрх зүйн актуудын албан орчуулга гаргаж, цахим хуудас болон холбогдох газруудад байршуулах.
16. Геологи уул уурхайн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татахын тулд үндэсний геомэдээллийн санг боловсронгуй, олон улсын стандарт, чанарын шаардлага хангахаар болгох.	Боловсруулан гаргаж байгаа мэдээллийн сангийн төрлийг нэмэх, чанарыг сайжруулах, мэргэжилтнүүдийн орон тоог нэмэх, шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмжөөр хангах. Геомэдээллийн төв архив, мэдээллийн нэгдсэн сангаас бодитой, шинэ буюу нэмэлт өөрчлөлт хийгдсэн, тодорхой мэдээллийг түргэн шуурхай авах, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



3.7

САЛБАРЫН
НЭГДСЭН
МЭДЭЭЛЛИЙН
САН БҮРДҮҮЛЭХ,
БОЛОВСРУУЛАХ,
ХЭРЭГЛЭГЧДЭД
ТҮГЭЭХ

Тайлан болон бусад цаасан дээрх мэдээллүүдийг цахим хэлбэрт оруулж үйлчилгээнд гаргах асуудлыг холбогдох хууль эрх зүйн болон техник технологийн түвшинд судалж байна.

Тайлангийн бүртгэлийн програмд бүх мэдээллийг бүрэн оруулж програмыг үйлчилгээнд нэвтрүүлэх, геологийн төрөл бүрийн судалгааны талбайн давхаргыг GIS програм дээр давхцуулж харуулах, элдэв шүүлтүүрээр хайж үзүүлэх, WebGIS-д суурилсан програм хангамж шинээр хийлгэж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

Өгөгдлийн сангийн талаар цаашид хийх ажлууд: Одоо байгаа Өгөгдлийн сангуудыг MS Access-аас дээд түвшний SQL чиглэлийн хүчирхэг програм хангамжид шилжүүлж, хадгалалт хамгаалалт, хандалтыг сайжруулах, үүссэн холбогдох GIS давхаргуудтай холбож шинэ бүтээгдэхүүн гаргах, онлайн хэрэглээнд оруулах зэрэг ажлуудыг хийх шаардлагатай байгаа. Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, баланс хөтлөх ажлыг шинээр програм хангамж зохиож, шилжүүлэх ажлыг хийнэ.

GIS давхаргуудын талаар цаашид хийх ажлууд: Одоо эдгээрийг тухайн масштабынх нь хэмжээнд төрөл ангиллаар нь нэгтгэж, өгөгдлийн сантай холбож бүрэн сэдэвчилсэн зураг (бүтээгдэхүүн) гаргах шаардлагатай байна. Хандалт, аюулгүй байдлыг хангахын тулд Spatial database (PostgreSQL/PostGIS) системд оруулж нэгтгэн ArcGIS болон бусад Open source програмуудыг хэрэглэнэ. Мөн эдгээр мэдээллийг бүртгэх, мэдээллийн тухай мэдээлэл буюу Metadata бүрдүүлэх, мэдээлэл зураг буюу картограм хамгийн түрүүнд хийж ашиглах шаардлагатай байгаа.

3.8

ЭРДЭС
БҮТЭЭГДЭХҮҮН,
ГАЗРЫН
ТОСНЫ ҮНИЙН
УРЬДЧИЛСАН
ТӨСӨӨЛӨЛ

Ашигт малтмал, газрын тосны газар нь сар бүр дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнэ, уул уурхайн салбарын экспортын орлогыг өөрийн цахим хуудсаар дамжуулж хэрэглэгчдэд мэдээлдэг болно.

Дэлхийн банкны гаргасан эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн урьдчилсан төсөөллийг ашиглаж Монгол Улсын уул уурхай, газрын тосны салбараас олох орлогыг тооцоолов.




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


Хүснэгт 40. Гол нэрийн бүтээгдэхүүний үнийн урьдчилсан төсөөлөл

Ашигт малтмалын төрөл	хэмжих нэгж	2017 он	2018 он	2019 он	2020 он
Алт		1,066.0	1,058.0	1,049.0	1,041.0
Зэс	s/унц	5,190.0	5,388.0	5,593.0	5,807.0
Катодын зэс	s/тн	5,190.0	5,388.0	5,593.0	5,807.0
Нүүрс - Экспорт	s/тн	51.9	53.9	55.9	58.1
Төмрийн хүдэр	s/тн	39.4	41.3	43.4	45.5
Цайр	s/тн	1,858.0	1,919.0	1,981.0	2,046.0
Молибден	s/тн	13,588.0	13,073.0	12,558.0	12,043.0
Жонш	s/тн	237.0	213.0	189.0	165.0
Гянтболд	s/тн	9,439.0	9,333.0	7,227.0	6,121.0
Цагаан тугалганы баяжмал	s/тн	15,730.0	14,495.0	17,297.0	18,138.0
Газрын тос	s/тн	43.9	46.2	48.6	51.2

Эх сурвалж: Дэлхийн банк



Зураг 58. Алт, зэс, цайрын үнийн мэдээлэл






АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

3.9

ГЕОЛОГИ,
УУЛ УУРХАЙ,
ГАЗРЫН ТОСНЫ
САЛБАРААС УЛС,
ОРОН НУТАГТ
ТӨВЛӨРҮҮЛЭХ
ТАТВАР
ТӨЛБӨРҮҮДИЙН
УРЬДЧИЛСАН
ТӨСӨӨЛӨЛ



Уул уурхай, газрын тосны салбарын Монгол Улсын эдийн засагт оруулах хувь нэмэр, ашигт малтмалын экспортын бүтээгдэхүүний орлогыг Дэлхийн банкны 2016 онд гаргасан тайланд тусгасан үнийн урьдчилсан төсөөлөл, ашигт малтмалын экспортын бүтээгдэхүүний урьдчилсан төсөөллийг ашиглан тооцоолов.

Хүснэгт 41. Уул уурхай, газрын тосны салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, сая.доллараар


Ашигт малтмалын төрөл		2017 он	2018 он	2019 он	2020 он
Алт		371.8	284.8	172.4	144.3
Зэс		597.9	620.7	644.3	669.0
Катодын зэс		11.9	12.4	12.9	13.4
Нүүрс - Экспорт		596.9	687.2	782.6	871.5
Нүүрс - Дотоодын хэрэгцээ		82.4	115.6	131.9	141.9
Төмрийн хүдэр		172.8	181.1	190.3	199.5
Цайр		113.5	112.3	115.9	119.7
Молибден		28.7	27.6	26.6	25.5
Жонш		28.4	32.0	27.2	24.8
Гянтболд		2.8	3.1	2.0	1.5
Цагаан тугалганы баяжмал		1.3	1.4	1.5	1.5
Газрын тос экспорт		87.5	128.5	142.6	160.5
Алт-Зэсийн баяжмал, Оюутолгой		911.8	1,202.7	1,965.6	1,345.8
Нийт	сая.\$US	3,007.9	3,409.4	4,215.7	3,718.8

Эх сурвалж: Дэлхийн банк

Зураг 59. Уул уурхай, газрын тосны салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, сая доллараар *




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Уул уурхай, газрын тосны салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2017-2020 онд 3-3.7 тэрбум ам.долларт хэлбэлзэх урьдчилсан төлөвтэй байна. Үүнээс ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл Оюутолгойн зэс-алтны баяжмалын орлого 30%, зэсийн баяжмалын орлого 20%, нүүрсний экспортын орлого 20%, алтны орлого 12%-тай байна. Зэс, экспортын нүүрсний орлого нийт орлогын 70%-ийг эзэлж байна.

Зураг 60. Уул уурхай, газрын тосны салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувь хэмжээ, ашигт малтмалын төрлөөр






АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 61. Эдийн засаг дахь татварын ачаалал *



Уул уурхай, газрын тосны салбараас Монгол Улсын нэгдсэн төсөвт оруулах орлогыг тухайн ашигт малтмалын төрлөөс хамаарсан татварын ачааллыг ашиглан тооцоолов.


Зураг 62. Уул уурхай, газрын тосны салбараас улсын нэгдсэн төсөвт 2017-2020 онд төвлөрүүлэх орлого





Монгол Улсын уул уурхай, газрын тосны салбарын орлогын хуваарилалтын схемийг дараах зурагт үзүүлэв.

Зураг 63. Монгол Улсын уул уурхай, газрын тосны орлогын хуваарилалтын схем*



Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд уул уурхай, газрын тосны салбараас орох орлогыг удирдахаар тусгасан байдаг.

Улсын нэгдсэн төсвийн хэтрэлт ДНБ-ий 2% -иас хэтрэхгүй байх,

Эрдэс бүтээгдэхүүний орлого ДНБ-ий 3%-ийн өсөлтөөс өндөр байх үед илүү орлогыг “Тогтворжилтын сан”-д тусгах,

Улсын нийт өр ДНБ-ий 40%-иас хэтрэхгүй байх,

Улсын төсвийн зарцуулалт уул уурхай, газрын тосны орлогоос бусад орлогын өсөлтөөс хэтрэхгүй байх,



Уул уурхайн салбараас улсын нэгдсэн төсөвт эзлэх
хувийг дараах зурагт үзүүлэв.

**Зураг 64. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, уул уурхайн салбарын
эзлэх хувь***



Эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс үүдсэн эдийн засгийн тогтворгүй байдлаас сэргийлэхийн тулд тогтворжилтын сан үүсгэж, түүнийг хянах, удирдах, зарцуулах Хөгжлийн банк (National Development Bank) байгуулж ажилладаг туршлага бусад улс орнуудад байдаг. Монгол Улс Хүний хөгжлийн сан байгуулж, Хөгжлийн банк байгуулан удирдуулсан ч Сангийн тухай хуулийн хэрэгжилтэд УИХ, Засгийн газар оролцсон тул сангийн хөрөнгийг урт хугацаанд өгөөжөө өгөх, эрсдэлтэй аймаг хоорондыг холбосон авто зам, төмөр зам, усан цахилгаан станц зэрэг дэд бүтцийн төслүүдэд зарцуулсан юм.

Цаашид бид олон улсын сайн туршлагад үндэслэн байгалийн баялгийн нөөц болон ашигт малтмалын орлогыг удирдах, институциудын үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах замаар хөрөнгө оруулалт татах чиглэлд онцгой анхаарах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд байгалийн баялаг арвин улсуудад түгээмэл ашиглагдаг “Байгалийн баялгийн Харти” буюу “Natural Resources Charter”-ийн 12 зарчмыг баримтлан ажиллана.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Зураг 65. Байгалийн нөөцийн Харт



Байгалийн нөөцийн засаглалыг сайжруулах 12 жор тус бүрээс Монгол Улсад



Хүснэгт 42. Байгалын нөөцийн засаглалыг сайжруулах 12 ЖОР*

ЖОР	ТАЙЛБАР	ХИЙГДЭХ АЖЛУУД
ЖОР 1 Стратеги, зөвлөгөө ба институциуд	Байгалийн нөөцийн менежмент нь цогц асуудлыг өөртөө багтаасан үндэсний стратеги, тов тодорхой эрх зүйн тогтолцоо, чадварлаг институци бий болгох замаар иргэдэд байгалийн нөөц хамгийн үр өгөөжтэй байхыг баталгаажуулах ёстой.	• Урт хугацаагаар төлөвлөх • Олон нийтийн оролцоог хангах • Стратеги цогц шийдэлтэй байх • Тодорхой газар нутгуудад ашигт малтмалын хайгуул хийх эсэхийг шийдвэрлэх • Стратегийг аль болох эрт боловсруулж, ирээдүйн тодорхойгүй байдалд бэлтгэлтэй байх • Стратегийг тов тодорхой, харилцан уялдаатай институцийн орчин болгон хувиргах • Нэгдсэн зорилготой, чадварлаг институциуд байгуулах
ЖОР 2 Хариуцлага ба ил тод байдал	Нөөцийн засаглал нь шийдвэр гаргагчдыг мэдээлэл бүхий олон нийтийн өмнө үйл ажиллагаагаа тайлагнадаг, хариуцлага хүлээдэг байхыг шаарддаг.	• Шийдвэр гаргах бүх түвшинд мэдээллийн ил тод байдлыг хангах • Институциудын чиг үүргийг тодорхой тогтоож өгөх • Сайн засаглалыг шаардаж буй мэдээлэл бүхий иргэдийг дэмжих • Зөвшөөрлийн эрх хуваарилахдаа тохиромжтой арга хэрэгсэл сонгох • Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах • Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газрын зорилтуудтай нийцүүлж, тодорхой давтамжтайгаар баталгаажуулж байх • Бодит нөөцийг бүртгэж хөтлөх
ЖОР 3 Хайгуул ба тусгай зөвшөөрөл	Засгийн газар хайгуул, ашиглалтын үр ашигтай үйл ажиллагааг дэмжиж, зөвшөөрлийн эрхийг ил тод хуваарилах хэрэгтэй	• Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн эрх зүйн байдлыг баталгаажуулах • Байгалийн нөөцийн мэдээллийн сан үүсгэж, ажиллуулах • Хайгуул хийх газруудыг тогтоож, өмчлөлийн эрхийг баталгаажуулах
ЖОР 4 Татвар	Татварын дэглэм ба гэрээний нөхцөлүүд нь Засгийн газарт байгалийн нөөцийн үнэ цэнийг бүрэн ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалт татах асуудалтай уялдуулах боломж олгож, нөхцөл байдал өөрчлөгдөхөд тогтвортой үйлчилдэг байх хэрэгтэй	• Татварын дэглэмийн хэлбэр бус гүйцэтгэх үүрэгт анхаарах • Байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах • Орлого, төлбөр хураамжид хэрхэн татвар ногдуулах асуудлыг тодорхойлох • Татварын хөнгөлөлтөөс зайлсхийж, татварын дэглэмийг оновчтой болгох • Засгийн газрын хүртэх ашгийг нэмэгдүүлэхэд төрийн эзэмшлийн хувийг ашиглахаас зайлсхийх • Ил тод, тогтвортой, найдвартай орчин бүрдүүлэх • Шаардлага хангасан татварын удирдлага бий болгож, татвараас зайлсхийх асуудлаар журам боловсруулах
ЖОР 5 Орон нутагт үзүүлэх нөлөө	Засгийн газар орон нутагт хүртээх үр өгөөжийг эрэлхийлж, олборлох төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хохирол нөхөн төлөх асуудлыг анхааралдаа авах хэрэгтэй	• Шийдвэр гаргалт, үнэлгээнд орон нутгийн иргэдийг оролцуулах • Олборлолтын сөрөг нөлөөллийг үнэлэх бууруулах • Олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх орон нутгийг хөгжүүлэх боломжуудыг ашиглах • Орон нутгийн засаг захиргааны төлөөллүүдтэй харилцан мэдээлэл солилцож, тэдгээрийг чадваржуулах • Чиг үүргийн өөрчлөлтийг зохицуулах • Төрийн өмчит үндэсний компанийн үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох

* www.resourcesgovernance.org Natural resources charter



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

ЖОР	ТАЙЛБАР	ХИЙГДЭХ АЖЛУУД
ЖОР 6 Төрийн өмчит үндэсний Компаниуд	Төрийн өмчит үндэсний компаниуд хариуцлагатай, эрх үүрэг нь тодорхой, ашиг олох зорилготой байх ёстой	- Төрийн өмчит үндэсний компанийн удирдлагын чиг үүрэгт анхаарах - Хяналт-тэнцвэрийн зарчим бий болгох
ЖОР 7 Орлогын хуваарилалт	Засгийн газар орлогыг одоо болон ирээдүй үеийнхэнд тэгш хүртэхүйц оновчтой үр дүн бий болгоход хөрөнгө оруулах ёстой	- Ирээдүй үеийнхэнд тэгш хуваарилах - Өнөөгийн иргэдийн эрх тэгш байдлыг хангах - Хөрөнгө оруулалтын үр ашгийг баталгаажуулах
ЖОР 8 Орлогын савлагаа	Засгийн газар орлогын савлагааг харгалзаж, дотоодын зардлаа огцом өөрчлөхгүй байх ёстой	- Олборлох салбарын татварын дэглэм орлогын савлагаанд хэрхэн нөлөөлж болохыг тооцоолох - Үнэ тогтворжуулах гэрээ - Гадаад активыг нэмэгдүүлэн, богино хугацааны зээл авах - Тогтмол зардалд бус хөрөнгө оруулах зардлуудад эхлээд өөрчлөлт хийх - Аливаа арга хэмжээг зохистой хэрэгжүүлэх үүднээс хяналт тогтоох
ЖОР 9 Засгийн газрын зарцуулалт	Засгийн газар байгалийн нөөцийн орлогыг үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломж болгон ашиглах ёстой	- Эдийн засгийн доройтлоос зайлсхийх үүднээс төсвийн зарлагын бодлогод зохицуулалт хийх - Төрийн үйлчилгээний зарцуулалтын менежментийг сайжруулах
ЖОР 10 Хувийн хэвшлийн хөгжил	Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, тэднийг олборлох салбарт татах хэрэгтэй	- Хувийн хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх - Бизнесийн тодорхой салбарт чиглэсэн дэмжлэг үзүүлэх - Орон нутгийн ажиллах хүчний талаарх хууль тогтоомж хэрглэх эсэхээ шийдвэрлэх
ЖОР 11 Үндэстэн дамнасан Компаниудын үүрэг	Компаниуд байгаль орчин, нийгэм, хүний эрхийн хамгийн дээд стандартуудын дагуу үүрэг хүлээж, тогтвортой хөгжлийг хангах ёстой	- Авлигыг тэвчих - Тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах - Төслийн талаарх холбогдох мэдээллээр хангах
ЖОР 12 Олон улсын үүрэг тогтолцоо	Засгийн газрууд, Олон улсын байгууллагуудын зүгээс тогтвортой хөгжлийг дэмжих стандартуудыг эдийн засгийн өсөлтөд нийцүүлэх хэрэгтэй	- Олборлох үйлдвэрлэлийн салбарын мэдээллийн ил тод байдлын шалгууруудыг бий болгох, хянах, хэрэгжүүлэх - Олборлох үйлдвэрлэлийн салбарын төслүүдийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн стандартуудад нийцүүлэх - Олборлолтын төслийг байгаль орчин, нийгмийн стандартуудад нийцүүлэх - Хууль бус санхүүгийн урсгал, авлигыг бууруулах - Олборлох салбар дахь ур чадварын сайжрал, солилцоог дэмжих




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Уул уурхай, газрын тосны салбараас орох орлогыг **Байгалын нөөцийн Хартийн 7, 8, 9 дүгээр жорд** тусгасан зөвлөмжийн дагуу байгалийн нөөцийн сайн засаглалтай улс орнуудын баримталдаг дараах зарчмын дагуу удирдахад чиглүүлж ажиллана.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Ашигт малтмалын орлогыг удирдах зарчим *



3.11

УУЛ УУРХАЙ,
ГАЗРЫН ТОСНЫ
САЛБАРЫН
БОРЛУУЛАЛТ,
ЭДИЙН ЗАСАГТ
ЭЗЛЭХ БАЙР
СУУРЬ, ДНБ-ИЙ
ТӨСӨӨЛӨЛ


Уул уурхай, газрын тосны салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөлөлд үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан төсөөллийг дараах байдлаар гаргав.

Зураг 66. Улсын нэгдсэн төсөв, уул уурхайн салбарын орлогын 2017-2020 оны төсөөлөл



Монгол улсын ДНБ 2016 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 23 их наяд төгрөгт хүрэх магадлалтай бөгөөд 2017 онд 23.1 их наяд төгрөг болохоор төсөөлж байна. Үүнээс уул уурхай, олборлох салбарын хэмжээ 2016 оны эцэст 3.9 их наяд төгрөг, 2017 онд 4 их наяд төгрөг болох магадлалтай ба ДНБ-д эзлэх хувь хэмжээ 17%-даа хадгалагдах боломжтой.

Зураг 67. ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь




АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2016 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 9.6 их наяд төгрөгт хүрэх магадлалтай бөгөөд 2017 онд мөн 9.6 их наяд төгрөг болохоор төсөөлж байна. АҮНБ дэх уул уурхай, олборлох салбарын хэмжээ 2016 оны эцэст 6.8 их наяд төгрөг, 2017 онд 6.9 их наяд төгрөгт хүрэх боломжтой ба эзлэх хувь хэмжээ нь 72% байх магадлалтай байна.

Экспортын хэмжээ 2016 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 4.8 тэрбум ам.доллар, 2017 онд 4.9 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн салбарын экспорт 2016 онд 4.2 тэрбум ам.доллар, 2017 онд 4.3 тэрбум ам.долларт хүрэх боломжтой бөгөөд нийт экспортын 88%-ийг эзлэхээр таамаглалаа.

Зураг 68.
АҮНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь



Зураг 69.
Экспортын бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

3.12

МОНГОЛ УЛСЫН
ГЕОЛОГИ, УУЛ
УУРХАЙ, ГАЗРЫН
ТОСНЫ САЛБАРЫН
ГАДААД ОРЧИН,
ТОМООХОН
СУДАЛГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДЫН
ИНДЕКСИЙН
УРЬДЧИЛСАН
ТӨСӨӨЛӨЛ

Геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах чиглэлээр Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан гол заалтуудыг хэрэгжүүлэх замаар дэлхийн томоохон судалгааны байгууллагуудаас жил бүр гаргадаг индексүүдийг сайжруулах урьдчилсан төсөөллийг дараах байдлаар гаргалаа.



Бие даасан, улс төрийн хараат бус, судалгааны байгууллага болох "Fraser institute"-ийн гаргадаг Хөрөнгө оруулалт татах чадварын индекс 2015 онд 109 орноос 85 дугаарт эрэмбэлэгдсэн. Үүнийг 20 орноор урагшлуулж, 65 дугаарт эрэмблүүлэх зорилт тавьж байна.

Тус зорилтыг гаргахдаа оноо алдсан гол үзүүлэлтийг түлхүү сайжруулахыг зорьж байна. Тухайлбал, 2015 оны үзүүлэлтийг сулруулсан Төрийн институцын уялдаа холбоо, дүрэм журмын давхцал, ил тод байдал, дэд бүтэц бүхий суурь судалгааг сайжруулах чиглэлд ажиллана.

Хүснэгт 43. Хөрөнгө оруулалтыг татах чадварын индексийг сайруулах гол үзүүлэлт

Хүчин зүйлс	Хувь	2015 он зэрэглэл	2016 он Төсөөлөл
Дүрэм, журмын давхцал, уялдаагүй байдал (төвийн болон орон нутгийн байгууллагууд, байгууллагын доторх газрын хэлтсүүдийн шийдвэрүүдийн давхцал гэх мэт)	11%	101/109	81/109
Хуулийн систем (шударга, ил тод, авлигагүй, цаг үедээ нийцсэн, хурдан шуурхай хууль, шүүхийн систем)	11%	92/109	76/109
Дэд бүтэц (төмөр зам, авто замд холбогдох боломж, эрчим хүчний хангамж)	6%	107/109	101/109
Улс төрийн тогтвортой байдал	13%	92/109	85/109

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн нь баялаг ихтэй улс орнуудын газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын засаглалын индексийг гаргадаг. Тус индекст сөргөөр нөлөөлсөн дараах хүчин зүйлсийг сайжруулах чиглэлээр ажиллана.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР


- Тусгай зөвшөөрөл олгохоор сонгоноор зарлагдаж байгаа талбайд хийгдсэн судалгааны ажлын тухай мэдээллийг нийтийн хүртээл болгож чадахгүй байгаад дүгнэлт хийх,
- Тусгай зөвшөөрөл эзэмшихээр хийсэн гэрээ нь олон нийтийн хүртээл болдоггүй,
- Хүрээлэн буй орчны үнэлгээ нь зөвхөн үйл ажиллагаа нь тогтворжсон аж ахуйн нэгжийн хувьд хийгддэг,

- Салбарын төрийн захиргааны төв байгууллага нь орлого, татварын талаар тайлагнадаггүй,
- Салбарын төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэн нийтэлдэг боловч өнгөрсөн жилүүдийн харьцуулсан судалгааг гаргадаггүй,

- Төрийн эзэмшлийн уул уурхайн компаниудад тавих олон нийтийн хяналт муу
- Авилгатай тэмцэх болон Засгийн газрын идэвхтэй байдал оноо буурахад нөлөөлсөн
- Стратегийн ордууд дахь төрийн оролцоог “Эрдэнэс Монгол” компаниар дамжуулан хангадаг ч тухайн компанийн талаарх мэдээлэл маш хомс

Дээрх үзүүлэлтийг сайжруулснаар Монгол Улс “дунд” буюу 51 оноо авч, 26 дугаар байранд байгааг сайжруулж “Хангалттай” буюу 70-аас дээш оноо авахаар төлөвлөн ажиллаж байна.


Зураг 70. Байгалийн баялгийн засаглалын индексийн хүрэх үр дүн





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

IV БҮЛЭГ. ХАВСРАЛТ





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

4.1

ИРЭЭДҮЙТЭЙ
ХАЙГУУЛЫН
ТӨСЛҮҮД

БАЯНЦОГТЫН ВОЛЬФРАМ-МОЛИБДЕНИЙ ОРД



Төслийн нэр	БАЯНЦОГТЫН ВОЛЬФРАМ-МОЛИБДЕНИЙ ОРД
Байршил	Хэнтий аймаг, Цэнхэрмандал сум Улаанбаатар хотоос зүүн зүгт 195 км, Багануур хотоос зүүн тийш 68 км, Цэнхэрмандал сумаас 18 км, Улаанбаатар-Өндөрхааны чиглэлийн хатуу хучилттай засмал замаас хойш 20 км
Эзэмшигч	“Өндөр Баянцог” ХХК Олимпын-12, “Скай плаза” бизнес төв 4 давхар
Холбоо барих	tuvdendorj.g@bayantsogtmining.mn Утас: 327525 Факс: 976-11-327525
Хүдрийн биетийн тодорхойлолт	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй Ордын хүдэржилт нь Жанчивлангийн бүрдэл буюу грейзенжсэн, порфирлог граниттай холбоотой үүссэн байна. Хүдэржилт нь кварц-мусковитын буюу грейзений хувирлаас тогтох ба шток хэлбэрийн биет үүсгэнэ. Грейзенийн хувирлын бүсэд вольфрамит, молибденит, пирит, халькопирит, арсенопиритийн шигтгээ агуулагдана.
Ордын нөөц	Хамгийн бага вольфрамын дүйцүүлсэн агуулга (Eq.WO ₃) 200 г/т байгаа нь урьдчилсан техник эдийн засгийн үнэлгээгээр тогтоогдож байгаа бөгөөд гадаргуугаас 550м хүртэл гүнд тархсан, нөөцийн бодитой (B) зэрэглэлд хамаарах 4, боломжтой (C) зэрэглэлд хамаарах 5 блокийн хэмжээнд WO ₃ 275.51 г/т, Mo 206.28 г/т, Sn 141.88 г/т, Ag 1.55 г/т буюу 511.1 г/т вольфрамын дүйцүүлсэн (Eq.WO ₃) дундаж агуулгатай 269.67 сая тонн хүдэрт 74,296.4 тн метал вольфрам, 55,627.4 тн метал молибден, 38,261.9 тн метал цагаантугалга, 417.63 тн мөнгөний нөөц буюу нийт 137,831.2 тн метал вольфрамын дүйцүүлсэн нөөцтэй болохыг тогтоогоод байна.
Дэд бүтэц	Дунд зэрэг

ЗӨӨВЧ ОВООГИЙН УРАНЫ ТӨСӨЛ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Төслийн нэр	УРАНЫ ТӨСӨЛ /Дулаан уул, Зөөвч овоогийн орд/
Байршил	Дорноговь аймаг, Улаанбадрах сум
Эзэмшигч	“Арева Монгол” ХХК. “Арева” групп 2007 онд “Ийст Эйша Минералс Энержи” компанийг худалдан авч 2008 оны 3 дугаар сард нэрийг нь “Арева Монгол” ХХК болгон өөрчилсөн. “Арева Монгол” ХХК нь Монгол дахь үйл ажиллагааг хариуцан, улсын болон орон нутгийн удирдлагуудтай бүх чиглэлийн хамтын ажиллагаа хөгжүүлэх чиг үүрэг бүхий компани юм. Төв оффис нь Улаанбаатар хотод байрладаг.
Компанийн эзэмшигчид:	Монголын “Мон-Атом”, Францын “Арева”, Японы “Мицубиши”
Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Жамьян гүний гудамж, Ай Си Си цамхагийн 3 давхар.
Холбоо барих	cogegobi@magicnet.mn Утас: 320698, 323400 Факс: 976-11-329037
Ордын өнөөгийн байдал	Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй. Дорноговь аймаг дахь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай “Арева”-д, Сүхбаатар, Дорноговь аймаг дахь хайгуулын тусгай зөвшөөрлүүд “Кожегов” компанид бүртгэлтэй байна.
Ашигт малтмалын төрөл	уран
Ордын нөөц	Дулаан уулын ураны орд. Бодитой болон Боломжтой /В+С/ зэрэглэлээр хүдрийн 58117825,63 тн буюу 217,69 г/т дундаж агуулгатай 11896,44 т металл ураны нөөц тооцоогдсон байна. Зөөвч овоогийн ураны орд. Бодитой болон Боломжтой /В+С/ зэрэглэлээр хүдрийн 288698781,25 тн буюу 234,52 г/т дундаж агуулгатай 67706,77 т металл ураны нөөц тооцоогдсон байна.
Дэд бүтэц	сул



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

“СЭЛЭНГЭ” ТӨМРИЙН ХҮДРИЙН ТӨСӨЛ



Төслийн нэр	“СЭЛЭНГЭ” ТӨМРИЙН ХҮДРИЙН ТӨСӨЛ
Байршил	Сэлэнгэ, Дархан-Уул аймаг Улаанбаатар хотоос баруун хойшоо 336.1 км, Дархан-Уул аймгийн Дархан хотоос зүүн хойшоо 113.1 км, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотоос зүүн урагшаа 101.2км, Ерөө сумаас баруун урагшаа 24.0 км
Эзэмшигч	Харанга хүдэр ХХК, Ди Би бюлдинг 502, Улаанбаатар.
Харанга ресурс компани: Postal address: Telephone: Email: Холбоо барих утас:	Street address: Level 1, 330 Churchill Avenue, Subiaco WA 6008, Australia PO Box 540, Subiaco WA 6904, Australia + 61 8 9200 4415 Fax: + 61 8 9200 4469 admin@haranga.com saruul.p@haranga.com 77077711 Факс: 976-11-321914
Ордын өнөөгийн байдал	Тус компани 5 хайгуулын тусгай зөвшөөрөл, 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.
Хүдрийн биетийн тодорхойлолт	Баянцогтын ордын хэмжээнд 8 биеэ даасан хүдрийн биетээс гадна бусад жижиг биетүүд үүссэн бөгөөд орон зай байршлын хувьд хоорондоо харьцангуй параллель байрлалтай, баруун хойш 70-80°-ээр унаж зүүн хойш 40-50°-ээр сунасан. Баянцогтын ордын хэмжээнд төмрийн дундаж агуулга 20.14%, хүхрийн дундаж агуулга 1.49%, Дундбулагийн ордын хэмжээнд төмрийн дундаж агуулга 16%, хүхэр 0.37%, Өндөр-Ухаагийн ордын хэмжээнд төмрийн дундаж агуулга 14.5%, хүхрийн агуулга 0.2% тус тус байна.
Ордын нөөц	Баянцогтын төмрийн хүдрийн бүлэг ордод бодитой В зэргээр 238,80сая.тн, металлаар 39,3сая.тн, боломжит С зэргээр 10.6сая.тн, металлаар 1,8сая.тн нөөц тогтоогдсон. Уг төслийн Хүйтэн гол хэсгээс нэмж 50-100 сая тонн хүдрийн нөөцийг хайгуулаар илрүүлэх боломжтой гэж тус компани тооцоолж байна.
Дэд бүтэц	Харьцангуй сайн

ХАРМАГТАЙН ЗЭС-АЛТНЫ ТӨСӨЛ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Төслийн нэр	ХАРМАГТАЙН ЗЭС-АЛТНЫ ТӨСӨЛ
Байршил	Өмнөговь аймгийн Цогтцэций сум Улаанбаатараас 420 км, Оюутолгойгоос хойш 120 км, Цагаансуваргаас баруун тийш 100 км
Эзэмшигч	“Оюут-Улаан”
Холбоо барих	Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, Хоршооллын хотхон Утас: + 976 70 120 211 Факс: + 976 70 130 211 Email: andrew.stewart@xanadumines.com info@xanadumines.com
Ордын өнөөгийн байдал	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Цаашид нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.
Ашигт малтмалын төрөл	Алт-зэс
Хүдрийн биетийн тодорхойлолт	Хармагтайн хүдрийн талбайн геологийн тогтоцод хожуу карбон-түрүү пермийн интрузив чулуулгуудаар түрэгдсэн доод девоны тунамал- вулканоген хурдас оролцоно. Орд нь алт-зэсийн хүдэржилттэй Алтантолгой, Зэсэн уул, Цагаансудал гэсэн хүдрийн 3 биетээс тогтоно. Эдгээр хүдрийн биетүүд нь геологийн тогтоц, хувирал, хүдэржилтийн хувьд ерөнхийдөө төстэй ч хүдэржилтийн эрчимжилтээрээ хоорондоо ялгаатай. Au-дундаж агуулга 0.4-4.1г/тн, Ag-дундаж агуулга 5-23г/тн, Cu-дундаж агуулга 0.64-0.84%. Цагаан судал нь дунджаар 0.281г/тн алт, 0.318% зэстэй буюу ядуу агуулгатай, олон зэрэгцээ линзүүдээс тогтдог, турмалинжсан Алтантолгой нь гадаргаас 200м-ийн гүнд оршдог, 0.392г/тн алт, 0.450% зэстэй.
Ордын нөөц	Хармагтайн алт-зэсийн порфирын ордын хүдрийн үр ашигтай, баттай, бодитой болон боломжтой (A+B+C) нөөц 18031254.0тн, алтны нөөц 13.428тн, зэсийн нөөц 88475.0тн, Хармагтайн алт-зэсийн порфирын ордын хүдрийн тодорхой нөхцөлд үр ашигтай баттай, бодитой болон боломжтой (A+B+C) нөөц 68535851.0тн, алтны нөөц 25.008тн, зэсийн нөөц 259525.0тн, алт-зэсийн порфирын ордын хүдрийн нийт баттай, бодитой болон боломжтой (A+B+C) нөөц 86567105.0тн, алтны нөөц 38.436тн, зэсийн нөөц 348000.0тн гэж бүртгэгдсэн.
Дэд бүтэц	сул



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

ХҮРЭЛ ҮНЭГ ЗЭСИЙН ТӨСӨЛ



Төслийн нэр	БРОНЗ ФОКС ТӨСӨЛ
Байршил	Дорноговь аймаг, Мандах сум Улаанбаатараас 480 км, Хятадын хилээс 190 км Уг төсөл нь Монголын өмнөд хэсэгт илрээд байгаа зэсийн томоохон төслүүдийн нэг бөгөөд одоогоор нээгдээд байгаа Оюутолгой, Цагаансуваргын ордуудтай геологийн тогтоцын хувьд нэг байршилд оршдог.
Эзэмшигч	“Надмин”-ийг 100% “Кинкора групп лимитед” эзэмшдэг. Торонтогийн Venture биржид бүртгэлтэй “Kincora Copper” (TSX Venture: KCC) компани Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт нэлээд тооны хайгуулын тусгай завшөөрөл эзэмшиж байна.
Холбоо барих	Утас: +976 70 100 095 Факс: +976 70 100 097 Email: altantuya@kincoracopper.com enquiries@kincoracopper.com
Ордын өнөөгийн байдал	2004-2009 оны хооронд “Айвенхоу Майнз Монголиа Инк” компани уг төсөл дээр хайгуулын ажил идэвхтэй хийж гүйцэтгэсэн. Үүнд геохимийн дээжлэлт, штуф, цахилгаан болон соронзон хайгуул, суваг малталт болон өрөмдлөгийн ажлууд багтана. Үүний дараа буюу 2012 онд “Кинкора коппер” компани уг төслийг өөрийн компанийн нэр дээр шилжүүлэн авч эрэл, хайгуулын шатны нэлээд ажил хийж гүйцэтгэсээр ирсэн.
Хүдрийн биетийн тодорхойлолт	Дээрх хайгуулын ажлын явцад хэтийн төлөв бүхий 3 төрлийн эрдэсжилт тогтоогдсон байдаг. Үүнд: Cu-Au-Mo агуулсан порфирын төрөл, структур дагасан гидротермаль Au-ны төрөл, мөн Shear zone дагасан алтны төрөл багтана. Эдгээрээс порфирын төрлийн илрэл дээр илүү төвлөрч ажилласан.
Ордын нөөц	Хайгуулын ажлаар 0.5-1.5 хувийн зэсийн агууламжтай зэсийн хүдрийн дээжийг илрүүлсэн. Нэлээд хэмжээний алтны нөөц илрэх боломжтой. Одоогийн байдлаар 1200 метрийн гүнд өрөмдлөг хийхэд хөрсний тонн тутамд 1.5 грамм алт байгаа нь тогтоогдсон. Цаашид гүний өрөмдлөг хийвэл илүү агуулгатай байх магадлалтай.
Дэд бүтэц	Харьцангуй сайн

БАЯН-УУЛЫН АЛТНЫ ҮНДСЭН ОРД



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Төслийн нэр	БАЯН-УУЛЫН АЛТНЫ ҮНДСЭН ОРД
Байршил	Төв аймаг, Дэлгэрхаан, Бүрэн сум
Эзэмшигч	“Миллениум Сторм” ХХК Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай. Виржиний арлууд. Golden Spring management limited
Холбоо барих	enkhtuvshin.yu@bayanairag.com утас:329360 факс:976-11-318088
Ордын өнөөгийн байдал	Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй. 2001-2003 онд “Юниверсал Минералз” ХХК, 2003-2005 онд Канадын “Айвенхоу Майнз Монгол” компани Баян-Уулын талбайд эрлийн ажил хийсэн. Хайгуулын ажил хийгдсэн. Эрдэсжилтийн 2 болон 3-7 бүсийн хэмжээнд эрэл хайгуул явуулж, өндөр агуулгатай алтны үндсэн орд, мөн зэс молибденийн эрдэсжилттэй порфир төрлийн биетийг гүнд нь хайх шаардлагатай.
Ашигт малтмалын төрөл	Алт
Хүдрийн биетийн тодорхойлолт	Баян-Уулын алтны үндсэн орд нь Баян-Уулын хүдрийн талбайн 1, 2, 3 дугаар эрдэсжсэн бүсүүдийг хамрах ба хайгуулын ажил хийгдэж, нөөц нь тооцоологдсон 1, 2 дугаар хүдрийн биетүүд нь 1 дүгээр эрдэсжсэн бүсэд байрлана.
Ордын нөөц	Баян-Уулын ордын хэмжээнд хүдэр агуулагч 7 эрдэсжсэн бүс тогтоогдоод байгаагаас зөвхөн 1 дүгээр эрдэсжилтийн бүсийн хэмжээнд 1 дүгээр хүдрийн биетийн Төвийн болон Баруун хойд хэсэг, мөн 2 дугаар хүдрийн биетийн нөөцийн тооцооллыг хийсэн. Баян-Уулын ордын 1 дүгээр биетийн нөөцийн тооцооллын үр дүнгээр алтны нөөц 24.29 тн /В+С/ бол ордын хэмжээнд илрүүлсэн эрдэс баялаг нь 0.28г/т дундаж агуулгатай 5.3 тн алт тогтоогдсон.
Дэд бүтэц	Сул



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

УЛААНБУЛАГИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРД



Төслийн нэр	УЛААНБУЛАГИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРД
Байршил	Сэлэнгэ, Төв аймаг, Мандал, Борнуур сум Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрийн хил залгаа хэсэгт, Улаанбаатар хотоос баруун хойш 130-140 км, Улаанбаатар-Алтанбулагийг холбосон төв замаас холгүй оршдог.
Эзэмшигч	“Бороо гоулд” ХХК Багамын арал улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай
Холбоо барих	turbold.b@centerragold.mn, john.kazakoff@centerragold.mn
Ордын өнөөгийн байдал	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй
Ашигт малтмалын төрөл	алт
Ордын нөөц	Улаанбулагийн алтны үндсэн орд нь газрын гадаргаас 30-100 м хүртэл гүн үргэлжилнэ. Улаанбулагийн алтны үндсэн ордын эдийн засгийн үр ашигтай нөөцийн исэлдсэн хүдэрт алтны дундаж агуулга 1.14 г/т, хагас исэлдсэн хүдэрт алтны дундаж агуулга 1.39 г/т, анхдагч хүдэрт алтны дундаж агуулга 1.51 г/т түвшинд 3284.5 мян.т хүдэрт 4243.9 кг алт, үүнээс бодитой (В) нөөц 2841.5 мян.т хүдэрт 3765.4 кг алт, боломжтой (С) нөөц 443 мян.т хүдэрт 478.4 кг алт агуулагдаж байна
Дэд бүтэц	Харьцангуй сайн

АЛТАН ЦАГААН ОВООГИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРД



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Төслийн нэр		АЛТАН ЦАГААН-ОВООГИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРД
Байршил	Дорнод аймаг, Цагаан-Овоо сум Улаанбаатар хотоос зүүн тийш 650км, Дорнод аймгийн төвөөс баруун-хойш 180км, Цагаан-Овоо сумаас баруун тийш 38 км.	
Эзэмшигч	“Сентерра гоулд Монголиа” ХХК Дэд ерөнхийлөгч Жон Пирсон	
Холбоо барих	turbold.b@centerragold.mn, john.kazakoff@cen Утас: (416) 204-1241 Емэйл: john.pearson@centerragold.com	
Ордын өнөөгийн байдал Ашигт малтмалын төрөл	Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй Алт-холимог метал	
Хүдрийн биетийн тодорхойлолт	Алтан Цагаан-Овоогийн алт-холимог металлын хүдэржилт нь I, II, IV гэсэн хоолой хэлбэрийн биетүүдээс бүрдэх бөгөөд эдгээр нь хоорондоо 40-60м-ийн зайтай оршдог. Хоолой тус бүрт исэлдсэн бүс байх бөгөөд исэлдлийн бүс нь II хоолойгоос IV хоолой буюу ордын баруун хойд захаас зүүн урд зах руу нимгэрдэг. Исэлдлийн бүсийн хамгийн их зузаан II хоолойд илрэх бөгөөд ойролцоогоор 70м байна. Хамгийн бага зузаан IV хоолойн зүүн урд захад 10м хэмжээтэй.	
Ордын нөөц	Ордын нийт нөөц 21.842,20 мян.тн хүдэр, 28.1 тн алтны нөөц тогтоогдсон байна.	
Дэд бүтэц	сул	



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

УЛААН ДЭЛИЙН ЦИРКОН-ХҮНД ГАЗРЫН ХОВОР ЭЛЕМЕНТИЙН ХҮДЭРЖИЛТИЙН ТӨСӨЛ



Төслийн нэр	УЛААН ДЭЛИЙН ЦИРКОН-ХҮНД ГАЗРЫН ХОВОР ЭЛЕМЕНТИЙН ХҮДЭРЖИЛТИЙН ТӨСӨЛ
Байршил	Увс аймаг, Завхан сум
Эзэмшигч	“Гео-инфо ХХК” Монголын үндэсний геологийн зөвлөх компани Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ, уул уурхай, алт олборлолт, хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг
Холбоо барих	gis@geo-info.mn утас: 98110919
Ордын өнөөгийн байдал	Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажил гүйцэтгэж гарсан үр дүнгээр нөөц бүхий үр дүнгийн тайлан хийгдэж байна.
Ашигт малтмалын төрөл	Циркон, хүнд газрын ховор элемент (голлох эрдсүүд: циркон, эльпидит, ксенотим, синхизит, апатит, монацит, малахит, паризит, ильменит, магнетит)
Ордын нөөц	Нөөц бодогдож байгаа (Урьдчилан үнэлсэн баялгаар 6,3 сая тн Zr-REE хүдэр 1000 ppm REE 100 м гүн хүртэл)
Дэд бүтэц	сул

ХӨХ ДЭЛИЙН ЛИТИЙН ОРД



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Төслийн нэр	ХӨХ ДЭЛИЙН ЛИТИЙН ОРД
Байршил	Дундговь аймаг, Өлзийт сум. Улаанбаатар хотоос зүүн урагш 550 км, Мандалговь хотоос зүүн урагш 98 км.
Эзэмшигч	“Алкали Метал Монголиа” ХХК
Холбоо барих	Picuris_mn@gmail.com
Ордын өнөөгийн байдал	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаас нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан, одоогоор олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй.
Ордын хэлбэр хэмжээ, агуулга	Хөх дэлийн литийн тунамал орд нь Цагаан нуурын хотгорын баруун-урд үзүүр хэсэгт Төгрөгийн хонхорт оршино. Ордын тогтоогдсон урт нь 6000.0м, өргөн 5000.0м, хүдрийн биетийн дундаж зузаан 51.11м. Үндсэн элементээс гадна дагалдах ашигт малтмалаар кали, стронци, дагалдагч элементүүдээр цези, рубиди, газрын ховор шорооны хөнгөн бүлгийн элементүүд. Литийн агуулга нь 793ppm-ээс 3480ppm-ийн хооронд дунджаар 1656ppm, n=5.
Ордын нөөц	Ордын нөөцийн тооцооллын үр дүнд баттай (А), бодитой (В), боломжтой (С) зэрэглэлээр 283,9 сая тн хүдрийн нөөц, 0.156% дундаж агуулгатай 443,6 мян тн литийн нөөц тооцоологдсоноос баттай (А) зэрэглэлээр тооцоолсон хүдрийн нөөц 23,5 сая.тн, бодитой (В) зэрэглэлээр 98,7 сая.тн буюу литий металлын нөөц 37,7 мян тн баттай (А) зэрэглэлээр, бодитой (В) зэрэглэлээр 151,3 мян тн гэж тооцоологдсон. Үүний зэрэгцээ баттай (А), бодитой (В) нөөцийн зэрэглэлээр 0.145% дундаж агуулгатай 173.3 мян тн стронцийн, 3.7 % дундаж агуулгатай 4 970.5 мян. тн калийн нөөц тус тус тооцоологдсон. Ордын тогтоосон эрдэс баялгийг (P1) 644,3 сая тн хүдэр буюу 0.153% дундаж агуулгатай 992,2 мян. тн литий металаар гэж үнэлсэн.
Дэд бүтэц	Харьцангуй сул



A person wearing a green jacket, a cap, and sunglasses is kneeling in a dry, open field. They are next to a rock that has the year '2026' painted on it in blue. The field is covered with dry grass and small rocks, and there are some vehicles visible in the distance under a clear sky.

Төслийн нэр	МӨНХТИЙН ЦАГААН ДӨРВӨЛЖИНГИЙН ЛИТИЙН ОРД
Байршил	Говьсүмбэр, Дундговь аймаг, Шивээговь, Баянжаргалан сум
Эзэмшигч	“Литиум майнинг” ХХК
Холбоо барих	r_djorj@yahoo.com
Ордын өнөөгийн байдал	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй.
Ашигт малтмалын төрөл	Литий, рубидий, цезий
Ордын нөөц	Нөөцийг бодитой болон боломжтой зэрэглэлээр 0.65% Li2O-дундаж агуулгатай 2276989тн хүдэр, химийн цэврээр 14575тн литийн, 0.15% агуулгатай Rb2O-ийн 4286.1тн рубиди, 0.03% агуулгатай 0.622тн цезийн нөөц тооцоолсон байна.
Дэд бүтэц	Дэд бүтцэд харьцангуй ойр байршилтай

МАНДАЛЫН МОЛИБДЕН-ВОЛЬФРАМЫН ОРД



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

Төслийн нэр	МАНДАЛЫН МОЛИБДЕН-ВОЛЬФРАМЫН ОРД
Байршил	Хөвсгөл аймаг, Цагаан-Уул сум
Эзэмшигч	“Монгол ресурс корпораци” ХХК Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг.
Холбоо барих	Емэйл: info@mongolianresource.com., Saraa_gua@yahoo.com Утас:70135599, 99099513 Факс: 976 -70125599
Ордын өнөөгийн байдал	Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй.
Хүдрийн биетийн тодорхойлолт	Доод пермийн интрузив бүрдлийн жижиг, дунд ширхэгт боржингийн силл, диорит, базальтын дэл судлууд зүсэж тогтсон байдаг. Мандал бүрдлийн боржингоор огтлогдсон хэсэгтэй молибден-вольфрамын хүдэржилт илэрдэг. Мандал ордын хэмжээнд нийт 1 том цул хүдрийн биет тогтоогдсон бөгөөд хүдрийн биет нь зүүн урдаас баруун хойш сунаж тогтсон, төв хэсэгтээ бараг эрдэсжилтгүй лейкократ боржингийн шток агуулсан буюу түүнийг тойрсон байдалтай орших биет юм.
Ордын нөөц	Мандал ордын эдийн засгийн үр ашигтай байх баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэргийн нөөцийг эквМо-1124.0 г/тн, Мо-961.89 г/тн, W-242.12 г/тн-ын дундаж агуулгатай 294,949,392.65 тн хүдэрт 331,523.96 тн эквМо, 283,708.52 тн молибден, 71,412.67 тн вольфрам, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай байх баттай, бодитой болон боломжтой (A+B+C) зэргийн нөөцийг эквМо-245.23 г/тн, Мо-151.14 г/тн, W-140.53 г/тн-ын дундаж агуулгатай 19,874,107.98 тн хүдэрт 4,873.66 тн эквМо, 3,003.68 тн молибден, 2,792.83 тн вольфрамын нөөцийг тус тус тооцоолсон байна. Мөн Баруун Мандалын илрэл дээр урьдчилан үнэлсэн баялаг (P1)-аар 57000 тн вольфрам, 3500 тн молибденийг үнэлсэн байна.
Дэд бүтэц	сул



ӨНДӨР-ЦАХИРЫН МОЛИБДЕН-ВОЛЬФРАМЫН ОРД



Төслийн нэр	ӨНДӨР-ЦАХИРЫН МОЛИБДЕН-ВОЛЬФРАМЫН ОРД
Байршил	Говь-Алтай аймаг, Тайшир сум Улаанбаатар хотоос 1050км, Говь-Алтай аймгийн төвөөс 45 км, Бургастайн боомтоос 300 км
Эзэмшигч	“Содгазар” ХХК
Холбоо барих:	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж, Шүрэн барилга, 5 давхарт 16 тоот, Улаанбаатар, УБ-14210 Импортлогч, уул уурхай, алт олборлолт, хайгуул, sodgazar@yahoo.com, gtumur@hunnucoal.com Утас: 319952, 99055756 Факс: 976-11- 319952
Ордын өнөөгийн байдал	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй
Ашигт малтмалын төрөл	Молибден, вольфрам
Ордын нөөц	Ордын хайгуулын ажлаар 18757,09 мян.тн хүдэрт агуулагдах 0,083%-ийн молибдений дундаж агуулгатай 156,453 мян.тн металлын нөөцийг бодитой, боломжтой зэргээр тогтоосон байна. Ордод тогтоогдсон 18757,09 мян.тн молибдений балансын хүдэр дэх дагалдах ашигт бүрдвэр болох 0,04 г/т дундаж агуулгатай 7,465 мян.тн рений, 0,015%-ийн дундаж агуулгатай 28.887 мян.тн вольфрамын металлын нөөц тус тус тооцогджээ.
Дэд бүтэц	сул



4.2

ОЛБОРЛОЛТ
ЯВУУЛЖ БАЙГАА
ТОМООХОН
ҮЙЛДВЭР, УУРХАЙ


ЦАНХИЙН БАРУУН, ЗҮҮН УУРХАЙНУУД



Уурхайн нэр	ЦАНХИЙН ЗҮҮН/ БАРУУН
Байршил	Өмнөговь аймаг, Цогтцэций сум
Эзэмшигч	“Эрдэнэс Тавантолгой” ХК
Цахим хаяг	www.erdenestt.mn
Олборлолт эхэлсэн он	2010/ 2013
Нүүрсний төрөл	Коксжих
Нүүрсний нөөц	1.5 тэрбум тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох жилийн хүчин чадал	15,000,000.0/ 20,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Гашуунсухайтын боомттой 245 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг.



УХААХУДАГИЙН УУРХАЙ



Уурхайн нэр	УХААХУДАГ
Байршил	Өмнөговь аймаг, Цогтцэций сум
Эзэмшигч	"Энержи ресурс" ХХК
Цахим хаяг	www.energyresources.mn
Олборлолт эхэлсэн он	2009
Нүүрсний төрөл	Коксжих
Нүүрсний нөөц	435.7 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	15,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Гашуунсухайтын боомттой 245 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Төвийн эрчим хүчний системд олбогдсон. Өөрийн эзэмшлийн 18МВт-ын цахилгаан станцаас эрчим хүчээ хангадаг. 15 сая тонн нүүрс угаан баяжуулах үйлдвэртэй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

ТАВАНТОЛГОЙН УУРХАЙ



Уурхайн нэр	ТАВАНТОЛГОЙ
Байршил	Өмнөговь аймаг, Цогтцэций сум
Эзэмшигч	“Тавантолгой” ХК
Цахим хаяг	www.tavantolgoi.mn
Олборлолт эхэлсэн он	1966
Нүүрсний төрөл	Коксжих
Нүүрсний нөөц	218.7 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	1,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Гашуунсухайтын боомттой 245 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг.



БАРУУН НОЁН УУЛ- 1 УУРХАЙ



Уурхайн нэр	БАРУУН НОЁН УУЛ- 1
Байршил	Өмнөговь аймаг, Ноён сум
Эзэмшигч	"Цагаан өвөлжөө" ХХК
Цахим хаяг	www.terracomresources.com
Олборлолт эхэлсэн он	2014
Нүүрсний төрөл	Коксжих
Нүүрсний нөөц	18.1 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	1,500,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Шивээхүрэнгийн боомт хүртэл 140 км зайтай. Нарийн сухайт-Шивээхүрэнгийн нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаас 98.4 км зайнд оршдог ба дээрх чиглэлд хатуу хучилттай автозам барихаар ажиллаж байна. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг.



ОВООТ ТОЛГОЙН УУРХАЙ



Уурхайн нэр	ОВООТТОЛГОЙ
Байршил	Өмнөговь аймаг, Гурвантэс сум
Эзэмшигч	"Саус гоби сэндс" ХХК
Цахим хаяг	www.southgobi.com
Олборлолт эхэлсэн он	2008
Нүүрсний төрөл	Хагас коксжих
Нүүрсний нөөц	136.7 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	9,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Шивээхүрэнгийн боомттой 44.8 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. БНХАУ-ын эрчим хүчний системээс цахилгаанаар хангагддаг.



НАРИЙНСУХАЙТЫН УУРХАЙ



Уурхайн нэр	НАРИЙНСУХАЙТ
Байршил	Өмнөговь аймаг, Гурвантэс сум
Эзэмшигч	“Монголын Алт” /МАК/ ХХК
Цахим хаяг	www.mak.mn
Олборлолт эхэлсэн он	2008
Нүүрсний төрөл	Хагас коксжих
Нүүрсний нөөц	587.5 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	14,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Шивээхүрэнгийн боомттой 44.8 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. БНХАУ-ын эрчим хүчний системээс цахилгаанаар хангагддаг.



ХҮРЭНШАНДЫН УУРХАЙ



Уурхайн нэр	ХҮРЭНШАНД
Байршил	Өмнөговь аймаг, Гурвантэс сум
Эзэмшигч	“Өсөх зоос” ХХК
Цахим хаяг	
Олборлолт эхэлсэн он	2014
Нүүрсний төрөл	Хагас коксжих
Нүүрсний нөөц	42.8 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	3,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Шивээхүрэнгийн боомттой 44.8 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг.



ХӨШӨӨТИЙН УУРХАЙ



Уурхайн нэр	ХӨШӨӨТ
Байршил	Ховд аймаг, Дарви сум
Эзэмшигч	“Моэнко” ХХК
Цахим хаяг	www.moenco.mn
Олборлолт эхэлсэн он	2011
Нүүрсний төрөл	Коксжих
Нүүрсний нөөц	171.1 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	3,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Ховд аймгийн Булган боомттой 310 км нүүрс тээврийн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг. Жилд 2.8 сая тонн нүүрс хуурайгаар баяжуулах үйлдвэртэй.



МАНДАХНУУРЫН УУРХАЙ



Уурхайн нэр	МАНДАХ НУУР
Байршил	Дорноговь аймаг, Мандах сум
Эзэмшигч	“Их говь энерги” ХХК
Цахим хаяг	www.ikhgobienergy.mn
Олборлолт эхэлсэн он	2013
Нүүрсний төрөл	Хагас антрацит/ чулуун нүүрс
Нүүрсний нөөц	54.8 сая тонн/ 8.6 сая тонн
ТЭЗҮ-д тусгагдсан нүүрс олборлох хүчин чадал	1,000,000.0 тонн/жил
Дэд бүтэц	Дорноговь аймгийн Хангийн боомттой 145 км шороон замаар холбогдсон. Дизель цахилгаан үүсгүүрээр эрчим хүчээ хангадаг.



ХОВД ГОЛЫН ГЯНТБОЛДЫН УУРХАЙ



Уурхайн нэр	ХОВД ГОЛЫН ГЯНТБОЛДЫН ОРД
Байршил	Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум
Эзэмшигч	“СС Монголиа” ХХК
Холбоо барих	www.ssm.mn
Олборлолт эхэлсэн он Ашигт малтмалын төрөл	2014 оноос Ховдголын далд уурхайд эрчимтэй олборлолт хийж эхэлсэн. Гянтболд
Ордын Нөөц	Нөөцийн шинэчилсэн тооцоогоор бодитой нөөцийн хэмжээ 5 блокоор 69.8 мян.тн хүдэрт 6.0 %-ийн дундаж агуулгатай 4176.5 тн. боломжтой нөөц 3 блокоор 18.7 мян.тн хүдэрт 6.1 % агуулгатай 1246 тн. нийт нөөц (B+C) 88.5 мян.тн хүдэрт 5422.5 тн гянтболдын гуравч ислийн нөөц тогтоогдсон.
ТЭЗҮ-нд тусгагдсан олборлох хүчин чадал	150 тн/хоног хүдэр
Бүтээгдэхүүн	65-70 %-ийн гянтболдын гуравч ислийн агуулгатай баяжмал үйлдвэрлэж байна.
Дэд бүтэц	Төвийн эрчим хүчтэй 15 кВт-ийн 36,5 км урт өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон. Өдөрт 5 тонн баяжмал гаргах хүчин чадалтай баяжуулах үйлдвэртэй.



БАЯН-АЙРГИЙН АЛТНЫ УУРХАЙ



Уурхайн нэр	БАЯН-АЙРАГ
Байршил	Завхан аймаг, Дөрвөлжин сум
Эзэмшигч	“Баян-Айраг Эксплорейшн” ХХК
Холбоо барих	www.bayanairag.com/
Ордын ашиглалтын байдал	Ил уурхайн олборлолтын ажлыг 2014 оноос хийж эхэлсэн.
Ашигт малтмалын төрөл	Алт, мөнгө
Ордын Нөөц	Нөөцийн шинэчилсэн тооцоогоор бодитой нөөцийн хэмжээ 15896 мян.тн хүдэрт 1.06 гр/тн-ийн дундаж агуулгатай 16.89 тн алт, 6.88 гр/тн-ийн агуулгатай 109.297тн мөнгө. Боломжтой нөөцийн хэмжээ 2143 мян.тн хүдэрт 0.62 % агуулгатай 1.33 тн алт, 4.31 гр/тн-ийн агуулгатай 9.24 тн мөнгө. Нийт нөөц (B+C) 18040 мян.тн хүдэрт 1.01 гр/тн агуулгатай 18.22 тн алт, 6.57 гр/тн агуулгатай 118.54 тн мөнгөний нөөц тогтоогдсон.
ТЭЗҮ-д тусгагдсан олборлох хүчин чадал	
Дэд бүтэц	



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР

ТӨМӨРТЭЙН ОВООНЫ ЦАЙРЫН УУРХАЙ



Уурхайн нэр	ТӨМӨРТИЙН-ОВОО
Байршил	Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум
Эзэмшигч	“Цайрт минерал” ХХК
Холбоо барих	www.tsairt.mn
Ордын ашиглалтын байдал	2005 оноос олборлолт хийж эхэлсэн.
Ашигт малтмалын төрөл	Цайр
Ордын Нөөц	Төмөртийн-Овооны цайрын ордын нөөцийг 1980 онд В+С1+С2 зэргээр балансын нөөцийн хэмжээ 7,689,4 мян.тн цайрын хүдрийн нөөцтэй, 885,4 мян.тн металлын нөөцтэйгөөр баталсан бөгөөд 2005-2012 онд ил аргаар 3,056 мян.тн хүдэр олборлосон. 2012 оны эцсийн байдлаар нийт 4,632.9 мян. тн хүдэрт 508.97 мян.тн металлын нөөц үлдсэн байна.
ТЭЗҮ-нд тусгагдсан олборлох хүчин чадал	400 мян.тн хүдэр олборлохоор тооцсон
Бүтээгдэхүүн	50 %-ийн агуулгатай цайрын баяжмал үйлдвэрлэж байна.
Дэд бүтэц	Уурхайн цахилгааны хэрэгцээг Баруун-Урт Чойбалсангийн шугамнаас Т холболт хийж, 110 кВ-ын шугамыг 16 км зайд татан хангадаг. Төмөртийн-Овооны цайрын ордын усны эх үүсвэрийг В зэрэглэлээр үнэлж, хоногт 3000 м³ хэмжээтэйгээр 25 жилийн турш ашиглаж болохыг тогтоосон. Уг ус хангамжийн эх үүсвэрийн талбайд хамгийн оновчтой байршлыг тодорхойлон ус хангамжид зориулж 4 худаг /DK01, DK02, DK03, DK04/ гаргасан.

ЭРДЭНЭТИЙН ЗЭС-МОЛИБДЕНИЙ УУРХАЙ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗАР



Уурхайн нэр	ЭРДЭНЭТИЙН УУРХАЙ
Байршил	Булган аймаг, Хангал сум
Эзэмшигч	“Эрдэнэт” ХК
Холбоо барих	www.erdenetmc.mn
Ордын ашиглалтын байдал	1978 оноос жилдээ 4 сая тонн хүдэр, 1980 онд жилд 8 сая тонн хүдэр, 1981 онд жилд 16 сая тонн хүдэр, 1989 онд жилд 20 сая тонн хүдэр, 2006 онд 26 сая. тн хүдэр, 2012 оноос онд 30 сая. тн хүдэр олборлон, боловсруулах болсон.
Ашигт малтмалын төрөл	Зэс-Молибден
